



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ХҮРЭЭЛЭН

**АЗИЙН БҮС НУТГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ
МОНГОЛЫН ҮҮРЭГ, ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ**

**СУУРЬ СУДАЛГААНЫ СЭДЭВТ АЖЛЫН ТАЙЛАН
2017-2019**

Төслийн удирдагч:

Д.ЗОЛБОО доктор (Ph.D), дэд профессор.
Олон улсын харилцааны хүрээлэн

Захиалагч байгууллага:

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан,
Спортын Яам

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх Ухаан Технологийн Сан

УЛААНБААТАР 2019

Улсын бүртгэлийн дугаар:

Нууцын зэрэглэл: Б энгийн

Аравтын бүрэн ангиллын код:

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар: ШyCC 2017/35

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ХҮРЭЭЛЭН**

**АЗИЙН БҮС НУТГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ
МОНГОЛЫН ҮҮРЭГ, ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ**

**СУУРЬ СУДАЛГААНЫ СЭДЭВТ АЖЛЫН ТАЙЛАН
2017-2019**

Төслийн удирдагч:

Д.ЗОЛБОО доктор /Ph.D/, дэд профессор
Олон улсын харилцааны хүрээлэн

Захиалагч байгууллага:

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан,
Спортын Яам

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх Ухаан Технологийн Сан

Тайланг өмчлөгч:

Олон улсын харилцааны хүрээлэн
Ш/х-187, Улаанбаатар-38,
Монгол Улс 15141
Утас: 322613, 99292529
э-хаяг: zolbood@mas.ac.mn

Улаанбаатар 2019

ТӨСЛИЙН КАРТ

Сэдэвт ажлыг баталсан тушаал, огноо:	2017.06.15
Сэдвийн тайлангийн бүрэн нэр:	Азийн бүс нутгийн байгууллагуудын үйл ажиллагаан дахь Монголын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх боломж
Сэдэвт ажлын төрөл:	Суурь судалгааны сэдэвт ажил
Захиалагч байгууллага:	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам
Гүйцэтгэгч байгууллага: Хэрэгжүүлэх хугацаа:	Олон улсын харилцааны хүрээлэн 2017-2019 он
Гүйцэтгэгч байгууллагын	
- Нэр:	ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн
- Регистрийн дугаар:	РД 9095837
- Дансны дугаар:	100900015270
- Банкны нэр:	Төрийн сан банк
- Хаяг:	Чингэлтэй дүүрэг, Баруун сэлбэ-15, ШУА-ийн Хүрээлэнгүүдийн II байр www.ija.ac.mn ija@mas.ac.mn
Сэдвийн удирдагчийн	
- Нэр:	Д.Золбоо. Доктор /Ph.D/, дэд профессор
- Регистрийн дугаар:	Олон улсын харилцааны хүрээлэн УХ76032870
- Утасны дугаар:	а: 322613, гар: 99292529
- И-мэйл:	zolbood@mas.ac.mn
Гэрээний дугаар:	ШуСС2017/35
Санхүүжүүлэгч байгууллага:	Шинжлэх ухаан, технологийн сан
Сэдэвт ажлын код:	17НН05СС366
Тайлангийн төрөл:	Эцсийн тайлан
Нууцын зэрэглэл:	Энгийн
Тайланг өмчлөгч байгууллага:	ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн
Сэдэв гүйцэтгэсэн хот:	Улаанбаатар
Тайлан бичсэн он:	2019 он

РЕФЕРАТ

Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд “Азийн улсуудтай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт хамтын ажиллагаанд оролцох, Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж оролцох: олон улс, бүс нутгийн эдийн засгийн интеграц болон дэд бүтцийн сүлжээнд нэгдэхийг эрмэлзэх, далайн боомт хүрэх, дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх: гадаад худалдааг эдийн засгийн өсөлт, хүн амын эрэлт хэрэгцээг хангахад чиглүүлж, үр ашгийг нь дээшлүүлэх, гадаад худалдааны тааламжтай нөхцлүүдийг олох замаар өөрийн бараа, үйлчилгээний зах зээлийг тэлэх нөхцөл бүрдүүлэхийг зорино” гэж заасан билээ.

Манай хүрээлэнгээс хэрэгжүүлсэн энэхүү төслийн суурь судалгаа нь Монгол Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Гадаад харилцааны салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний дотор “5.6.4.... олон улсын болон бүс нутгийн бусад байгууллагуудтай хамтын ажиллагааг идэвхтэй үргэлжлүүлнэ” хэмээн заасан зорилттой нягт уялдсан болно.

Эдийн засгийн эмзэг, хэт хамааралтай байдлыг даван туулхад чиглэсэн Гадаад бодлогын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх гол сувгийн нэг нь Ази Номхон далайн бүс нутгийн хамтын ажиллагаанд нэгдэх, өөрийн оролцоогоо нэмэгдүүлэх явдал юм.

Өнөөдөр Ази, Номхон далайн бүс нутагт дэлхийн хүн амын 40% /2,7 тэрбум/, гадаад худалдааны 44% /16,8 их наяд/, бараа бүтээгдэхүүний 55% /35,8 их наяд/ орчим нь ноогддог ба асар өргөн хүрээтэй, олон боломжуудыг бий болгосон хамтын ажиллагаа эрчимжиж байна. Тухайлвал олон талт яриа хэлэлцээр идэвхитэй өрнөж, Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага /АПЕК/, Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр /АПТА/, АРФ, АСЕАН+8, АСД, АХБ, ШХАБ зэрэг засгийн газар хоорондын, бүс нутгийн ба бүс нутаг хоорондын хамтын ажиллагааны олон талт механизмууд идэвхитэй үйл ажиллагаа явуулж, бүс нутаг болон салбар бүс нутгийн хүрээнд идэвхитэй ажиллаж байна.

Иймд эдгээр бүс нутгийн байгууллагатай хамтын ажиллагаа бүх талаар хөгжүүлэх, чөлөөт худалдааны бүсүүдэд нэгдэх, гадаад худалдааг тэлэх, экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх замаар өрсөлдөх чадварыг сайжруулах, бараа тээвэрлэлт, татварын үйл ажиллагаанд нь идэвхитэй оролцон, өөрийн орны хөгжилд тус нэмэр болох чиглэлээр төрөл

бүрийн төсөл, хөнгөлөлт, хөтөлбөрүүдэд хамрагдах боломжуудыг ашиглах замаар байр сууриа бэхжүүлэх, үүрэг ролио нэмэгдүүлэхэд дөхөм болохуйц арга замуудыг олж хэрэгжүүлэх нь тус судалгааны зорилго юм.

Сэдэвт ажлын хүрээнд ном, товхимол 7, эрдэм шинжилгээний өгүүлэл 32, илтгэл 46-ийг туурвиж судалгааны эргэлтэд оруулжээ. Мөн бодлогын зөвлөмж 3-ыг шийдвэр гаргах түвшний хэрэглэгдэхүүн болгон хүргүүлснээс гадна эрдэм шинжилгээний хурал 7-г зохион байгуулж, судалгааны үр дүнг олон нийтэд түгээн сурталчлах зорилгоор хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр өгүүлэл, нийтлэл, ярилцлага өгөх, төрийн тусгай байгууллагын ажилтан албан хаагчдад лекц яриа хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны үр дүнгийн биелэлт:

Төлөвлөсөн		Биелэлт	
Ном, бүтээл	2	Ном, бүтээл	6
Эрдэм шинжилгээний өгүүлэл	28	Гадаадад- 3	30
Эрдэм шинжилгээний илтгэл	36	Гадаадад-16	37
Зөвлөмж	3	Зөвлөмж	3
		Мэдлэг түгээх, танин мэдэхүйн нийтлэл, ярилцлага	60
Эрдэм шинжилгээний хурал, семинар	1	Эрдэм шинжилгээний хурал, семинар	7
Нийт	70		143

Түлхүүр үг: Бүс нутаг, олон талт хамтын ажиллагаа, улс төр, эдийн засаг, геополитик

Сэдэвт ажлын гүйцэтгэгчид:

1. Д.Золбоо. Доктор (Ph.D) ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн захирал, сэдэвт ажлын удирдагч.
2. Л.Хайсандай. Доктор (Sc.D) ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн зөвлөх, Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан
3. Ц.Баатар. Доктор (Sc.D) ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн ажилтан, Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан
4. Б.Цэнгэллхам. Доктор (Ph.D) ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн ажилтан, Эрдэм шинжилгээний ажилтан
5. Х.Мандухай. Докторант ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан
6. З.Батчимэг. Магистр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан
7. З.Мэнд.Магистр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан

ГАРЧИГ

1. Удиртгал	8
2. Сэдвийн судалгааны тойм	10
3. Дүгнэлт	19
4. Хавсралт	
Хавсралт 1. Бүтээлийн жагсаалт.....	21
Хавсралт 2. Бодлогын судалгаа, зөвлөмжүүд.....	32
Хавсралт 3. Эрдэм шинжилгээний өгүүллүүд	45

УДИРТГАЛ

2011 онд шинэчлэн батлагдсан Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд “Азийн улсуудтай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт хамтын ажиллагаанд оролцох, Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж оролцох: олон улс, бүс нутгийн эдийн засгийн интеграц болон дэд бүтцийн сүлжээнд нэгдэхийг эрмэлзэх, далайн боомт хүрэх, дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх: гадаад худалдааг эдийн засгийн өсөлт, хүн амын эрэлт хэрэгцээг хангахад чиглүүлж, үр ашгийг нь дээшлүүлэх, гадаад худалдааны тааламжтай нөхцлүүдийг олох замаар өөрийн бараа, үйлчилгээний зах зээлийг тэлэх нөхцөл бүрдүүлэхийг зорино” гэж заасан билээ.

Түүнчлэн 2010 оны 07 сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “3.1.1.8. Ази, Номхон далайн бүс нутаг Зүүн Ази, түүний дотор Зүүн хойд Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааны механизм бий болгоход чиглэсэн бүс нутгийн орнуудын бодлого, үйл ажиллагааг идэвхтэй дэмжиж оролцоно” хэмээн заасан байдаг.

Энэхүү төслийн үзэл санаа Монгол Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Гадаад харилцааны салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний дотор “5.6.4.... олон улсын болон бүс нутгийн бусад байгууллагуудтай хамтын ажиллагааг идэвхтэй үргэлжлүүлнэ” хэмээн заасан зорилттой нягт уялдсан болно.

Эдийн засгийн эмзэг, нэг улсаас хэт хамааралтай байдлыг гэтэлгэх, Гадаад бодлогын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх гол арга нь Ази Номхон далайн бүс нутгийн хамтын ажиллагаанд нэгдэх, өөрийн оролцоогоо нэмэгдүүлэх явдал юм.

Өнөөдөр Ази, Номхон далайн бүс нутагт дэлхийн хүн амын 40% /2,7 тэрбум/, гадаад худалдааны 44% /16,8 их наяд/, бараа бүтээгдэхүүний 55% /35,8 их наяд/ орчим нь ноогддог ба асар өргөн хүрээтэй, олон боломжуудыг бий болгосон хамтын ажиллагаа явагдаж байна. Тухайлвал олон талт яриа хэлэлцээр идэвхитэй өрнөж, Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага /АПЕК/, Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр /АПТА/, АРФ, АСЕАН+8, АСД, АХБ, ШХАБ зэрэг засгийн газар хоорондын,

бүс нутгийн ба бүс нутаг хоорондын хамтын ажиллагааны олон талт механизмууд идэвхитэй үйл ажиллагаа явуулж, бүс нутаг болон салбар бүс нутгийн хүрээнд идэвхитэй ажиллаж байна.

Иймд эдгээр бүс нутгийн байгууллагатай хамтын ажиллагаа бүх талаар хөгжүүлэх, чөлөөт худалдааны бүсүүдэд нэгдэх, гадаад худалдааг тэлэх, нэр төрлийг нэмэгдүүлэх замаар өрсөлдөх чадварыг сайжруулах, бараа тээвэрлэлт, татварын үйл ажиллагаанд нь идэвхитэй оролцон, өөрийн орны хөгжилд тус нэмэр болох чиглэлээр төрөл бүрийн төсөл, хөнгөлөлт, хөтөлбөрүүдэд хамрагдах боломжуудыг ашиглах замаар байр сууриа бэхжүүлэх, үүрэг ролио нэмэгдүүлэхэд дөхөм болохуйц арга замуудыг олж хэрэгжүүлэх нь тус судалгааны зорилго юм.

СЭДВИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ

Ази Номхон Далайн бүсийн худалдаа, эдийн засгийн интеграцийн талаар Монгол Улсын шинжлэх ухааны хүрээлэн, их дээд сургууль тэр дундаа Олон улс судлалын хүрээлэн дээр хийсэн судалгаа нэлээдгүй бий. Тухайлвал: Ц.Батбаяр, С.Дашцэвэл “Ази тив, түүний салбар бүс нутгуудын хамтын ажиллагаанд Монгол Улсын оролцоо, хэтийн төлөв”, (УБ.,1997), Б.Балдоо “Монгол улс ба Зүүн хойд ази” (УБ.2002), С.Дашцэвэл “Зүүн өмнөд азийн хөгжлийн хандлага, интеграци, Монгол Улсын бодлого чиглэл” (УБ.2005), Б.Цэнгэлхам “Монгол, АСЕАН-ны харилцаа, хамтын ажиллагаа ба Вьетнам” (УБ. 2009), Ц.Баатар “Глобалчлалын эриний Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцаа” (УБ. 2007), “Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлого ба бүс нутгийн хамтын ажиллагааны механизмууд” (УБ.2014), ред. Д.Шүрхүү “Монгол Улсын олон талт дипломат үйл ажиллагаа ба бүс нутгууд” (УБ. 2014), С.Дашцэвэл “Монголчууд ба Зүүн өмнөд Азийнхан: Эртний хамаарал, эдүгээгийн хамаарал” (УБ.2018) зэрэг бүтээлүүд, цөөнгүй тооны эрдэм шинжилгээний өгүүллүүд хэвлэгдсэн байна. Ази номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа, интеграци болон бүс нутгийн байгууллагууд дахь Монголын үүрэг оролцоо, үр өгөөжийн талаар цогц дагнасан суурь судалгааг манай орны хөгжлийн эрх ашгийн үүднээс үргэлжлүүлэх хийх зайлшгүй шаардлагатай байлаа.

XXI зууны эхээр Монгол Улсын дотоод, гадаад орчинд гарсан эрс өөрчлөлтүүд, ялангуяа манай улс эрдэс баялгийн арвин нөөцөө эдийн засгийн эргэлтэнд оруулах болсноор Монгол Улс бүс нутаг, дэлхий дахины анхаарлын төвд орж эхлэв. Монгол Улсын тухайд экспортын гол зах зээл нь хоёр хөрш орон болж байгаа авч, Азид орших улс орнуудтай эдийн засаг, интеграци, аюулгүй байдлын чиглэлд хамтран ажиллах нь Монгол Улсын гуравдагч хөршийн үзэл санааг хэрэгжүүлэх, аюулгүй байдлаа хангах болон эдийн засгийн хувьд хэт нэг талын хамаарлыг багасгах арга замыг эрэлхийлэх зэрэг олон талын ач холбогдолтой юм. Өнөөдөр тус бүс нутагт Зүүн Азийн дээд хэмжээний уулзалт, АСЕАН+3/+6/, Боаогийн форум, Байгалийн форум гэх мэт эдийн засаг, улс төр, аюулгүй байдлын олон талт хамтын ажиллагааны шинэ шинэ механизмууд бүрэлдэн буй болж, АПТА, АПЕК, АСЕАН, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) зэрэг нэр нөлөө бүхий улс төр, эдийн засгийн уламжлалт бүтцүүдийн үйл ажиллагаанд нэлээн өөрчлөлт шинэчлэлт гарч байна. Энэхүү нөхцөлд тус суурь судалгааг явуулснаар газарзүйн, хүн ам зүйн зэрэг бусад сөрөг хүчин зүйлсийн нөлөөг багасгах боломжуудыг судлан, Монгол Улсын хамтран ажиллах, элсэн орох сонирхол бүхий бүс нутгийн хамтын ажиллагааны бүтэц, механизмуудын өнөөгийн бодит байдал, цаашдын чиг хандлагад цогц судалгаа явуулж, Монгол Улс Ази, Номхон далайн бүс нутгийн хамтын ажиллагааны

механизмуудад оролцох боломжуудыг судлан гаргахын зэрэгцээ өнөөгийн нөхцөлд Монгол Улсын оролцоо, гүйцэтгэж буй үүрэг, цаашдын төлөв байдалд дүн шинжилгээ хийх замаар тус бүс нутгийн эдийн засгийн интеграцид хамрагдах хөгжлийн бодлогын загвар гаргаснаар тус судалгааны үр өгөөж хэмжигдэх болно.

Сэдвийн гүйцэтгэгчдийн ихэнх нь олон жил тухайн сэдвийн дагуу судалгааны ажил хийсэн туршлагатай, онол-аргазүй, мэдлэг мэдээллийн бааз суурь сайтай байсан нь судалгааны ажлыг үр дүнтэй, чанартай гүйцэтгэхэд зохих ёсоор нөлөөлсөн болно.

Төсөл гүйцэтгэгч судлаачид Монголын болон гадаадын архивуудын баримтууд, сурвалж бичиг, судалгааны бүтээлүүд, дотоод гадаадын хэвлэмэл болон цахим эх сурвалжууд, албан ёсны статистикийн дүн мэдээнүүдэд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр судлаач бүр өөр өөрийн үнэлэлт дүгнэлтийг хийх замаар “Азийн бүс нутгийн байгууллагууд ба Монгол Улс” нэгэн сэдэвт хамтын бүтээл, “Даяаршил ба өнөөгийн Еврази: түүх, хандлага, өөрчлөлтийн сорилт”, “Бүс нутгийн интеграц ба Монгол Улс”, “Монгол-Вьетнамын харилцаа: түүх ба орчин үе”, “Хагас зууны түүх ба хөгжлийн чиг хандлага”, “Нүүдэлчид ба хувьсгалчид” номын орчуулга зэрэг нийт 7 ном бүтээл туурвижээ. Түүнээс гадна бүс нутгийн хамтын ажиллагаа, Будаа эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион байгуулжээ. Суурь судалгааны үр дүнг төр засгийн бодлого шийдвэрт тусгуулах, эрх баригчдын анхаарал, сонорт хүргэх хамгийн үр дүнтэй арга болох бодлогын судалгаа, зөвлөмж 3-ыг бэлтгэн бодлого боловсруулагчдад хүлээлгэн өгсөн байна. Сэдэвт ажлын хүрээнд гарсан дээрх ажлуудын талаар тоймлон танилцуулбал,

1. “Азийн бүс нутгийн байгууллагууд ба Монгол Улс” хамтын бүтээл (112 хуудас)
Энэхүү хамтын бүтээл нь гурван бүлгээс бүрдэж байна. Бүтээлд доктор Л.Хайсандай, “Монгол Улсын Азийн бодлого: геоэдийн засгийн хүчин зүйл”, доктор Ц.Баатар “Азийн бүс нутгийн интеграцийн үйл явц ба Монгол Улс”, доктор Д.Золбоо “Монгол Улс бүс нутгийн эдийн засгийн интеграцид оролцох боломж, сорилт”, доктор Б.Цэнгэлхам, “Монгол-Вьетнамын харилцааны уламжлал, АПЕК-д элсэхэд ашиглах нь”, докторант Х.Мандухай, “Зүүн хойд Азийн интеграц: Монгол-Хятадын хамтын ажиллагаа”, З.Батчимэг, “Монгол Улс ба олон улсын байгууллага хоорондын хамтын ажиллагаа, үүрэг хариуцлага, ач холбогдол, (Азийн бүс нутгийн олон улсын байгууллагын жишээн дээр)” хэсгүүдийг бичсэн.

2. Судалгааны үр дүнг эргэлтэд оруулах, шинжлэх ухааны мэдлэгийг нийтэд түгээн сурталчлах хамгийн сайн аргуудын нэг болох эрдэм шинжилгээний хурал,

симпозиумыг нэлээд идэвхитэй зохион байгуулсны дотор үндэсний болон олон улсын өндөр түвшинд хийгдсэн зарим хурлуудын талаар тоймолвол:

“Зүүн хойд Азийн бүс нутгийн улсуудын хамтын ажиллагааны боломж ба Монголын үүрэг” Японы Шиманэ мужийн их сургуулийн Зүүн хойд Азийн бүс нутгийг судлах төв, Японы Хүн соёлыг судлах байгууллага, БНАСАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэн болон бусад байгууллагатай хамтран 2017 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Улаанбаатар хотноо зохион байгуулав.

Уг эрдэм шинжилгээний олон улсын хурлыг зохион байгуулан гарсан үр дүнгээр бодлогын зөвлөмжийг боловсруулан Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, ГХЯ-нд хүргүүлжээ. Олон талт харилцааны Солонгосын хойгийн хурцадмал байдлыг намжаахад нөлөөлөх гарцыг эрэлхийлсэн саналуудыг боловсруулан Монгол, Орос, Хятад, Япон, Умард Солонгосын эрдэмтэн судлаачдын байр суурийг нэгтгэж хамруулж чадсанаараа шинэлэг байж, ач холбогдолтой болсон юм. Тус хуралд бүс нутгийн Япон, Монгол, БНАСАУ, БНХАУ-ын эрдэм шинжилгээний байгууллагуудын төлөөлөл хамтран оролцож, тулгамдсан асуудлаар эрдэмтдийн хүрээнд санал солилцон, эрдэм шинжилгээний байгууллагуудын цаашдын хамтын ажиллагааны эхлэлийг тавих оролдлого хийж, цаашид эл бүс нутгийн бусад орнуудын эрдэм шинжилгээний байгууллагуудын төлөөллөөр хүрээгээ тэлж, бүс нутгийн нийтийн эрх ашгийг хамарсан аливаа асуудлаар санал бодлоо солилцож байхаар тохиролцсон нь ач холбогдолтой болсон билээ. Хурлыг монгол, япон, солонгос хэлээр явуулсан болно.

“Даяаршил ба өнөөгийн Еврази: түүх, хандлага, өөрчлөлтийн сорилт, Монголын оролцоо” Суурь судалгааны сэдэвт ажлын хүрээнд төслийн гүйцэтгэгчид нь 2018 оны 6 дугаар сарын 30-наас 7 дугаар сарын 01-ний өдрүүдэд Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүхийн ивээл дор Слав, Еврази судлалын Зүүн Азийн олон улсын IX бага хурлыг амжилттай зохион байгуулав. Ингэснээр Монгол Улс Евразийн эрдэмтдийн үзэл санааны чөлөөт индэр болж, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах нь бүс нутгийн эдийн засгийн хөгжил цэцэглэлтийн үндэс суурь болно гэдэг үнэт зүйл, зарчмын дагуу судалгаагаа энэ чиглэлд хандуулж, ОХУ-ын Алс Дорнодын хөгжлийн санаачлага, Зүүн өмнөд Азийн эдийн засгийн интеграцид бодитоор оролцоход Монгол Улсын оролцоо, дуу хоолой, үзэл санааг хүргэж, төр засгийн гадаад бодлогын оновчтой шийдвэр гаргалтад зөвлөмжөөр дэмжлэг үзүүлсэн зэрэг бодит үр дүн багагүй байв.

“Солонгосын хойгийн энх тайвны үйл явц: Монгол-Солонгосын харилцааны төлөв” 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын Гадаад харилцааны яам,

БНСУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ, Солонгосын нэгдлийн төлөөх Монголын форум, Геополитик судлалын төв, MINASS, Дипломатын академи, Монголын аюулгүй байдал судлалын хүрээлэн хамтран олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Улаанбаатар хотод зохион байгуулав.

“Монголын геополитик” МУИС-ийн ОУХНУС, Засгийн газрын дэргэдэх Удирдлагын Академи, Монголын Дипломатын Академи, Аюулгүй байдлын судалгааны төв зэрэг байгууллагатай хамтран 2 дахь удаагийн Академик мэтгэлцээнийг **“Монгол Улс ШХАБ-д жинхлэх нь зөв үү?”** дэд сэдвийн хүрээнд 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулав.

Академик мэтгэлцээний зорилго нь улс төр, аюулгүй байдал, геополитик, олон улсын харилцааны чиглэлээр судалгаа хийдэг мэргэжлийн байгууллагууд болон улс төрч, эрдэмтэн судлаачид хамтран Монгол улсын хувьд тулгамдаж буй асуудлыг тодруулах, онол практикийн мэдлэгээ цэгцлэх, судалгааны аргазүйг нээх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, залуу улс төрч, судлаачдыг дэмжих, академик мэтгэлцээний соёлыг төлөвшүүлэх, Монголд геополитик судлалыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах явдал бөгөөд мэтгэлцээний үр дүнд Монгол дахь буддын шашны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд шийдвэр гаргагчдад хэрэглэгдэхүйц зөвлөмж боловсруулан хүргүүлсэн юм.

Уг арга хэмжээнд ҮАБЗ, Ерөнхийлөгчийн Тамгын Газар, Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар, УИХ-ийн АБГББХ, ГХЯ, ТЕГ, Үндэсний хөгжлийн газар, ШУА, МУИС, ҮБХИС-ийн БХЭШХ, ХСИС-ийн ЭШХ, ЗГХГ-ын дэргэдэх Удирдлагын Академи, Монголын Дипломатын Академи, Хууль сахиулахын Удирдлагын Академи, Тагнуулын Академи, Геополитик судлалын хүрээлэн, Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын судалгааны төв, Энхтайван АБС-ын хүрээлэн, Цэнхэр сүлд ТББ, ХИС-ийн ОУХНСС, Улаанбаатар судалгааны хүрээлэн, Зүүн Хойт Азийн АБСХ зэрэг мэргэжлийн байгууллагын төлөөллөөс гадна Монгол улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, ҮАБЗ гэх мэт төрийн өндөр албанд ажиллаж байсан хүмүүс, Ерөнхийлөгч болон УИХ-ын дарга, Ерөнхий сайдын Гадаад бодлогын зөвлөхүүд, Элчин Сайдууд, Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайдууд, улс төрч, ахмад дипломатч, эрдэмтэн судлаачид өргөнөөр оролцсон юм. ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн захирал, доктор Д.Золбоо, эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D) Д.Шүрхүү, К.Дэмбэрэл нарын судлаачид хэлэлцүүлэгт оролцож хэрэгжүүлж буй суурь судалгааны төслийн үр дүн, хүрээлэнгийн судлаачдын байр суурийг танилцуулж, бодлого боловсруулагч нарт хандсан Зөвлөмж гаргахад оролцсон болно.

“Монгол, Вьетнамын харилцаа: Түүх ба орчин үе” сэдэвт Монгол-Вьетнамын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлыг 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдөр ГХЯ-ны “Зөвшилцөл” танхимд амжилттай зохион байгуулав.

Тус эрдэм шинжилгээний хурлаар “Монгол-Вьетнамын харилцааны уламжлал, ирээдүй”, “Монгол-Вьетнамын эртний харилцаа”, “Монгол-Вьетнамын хүмүүнлэг, боловсролын харилцаа-65 жилд”, “Хоёр орны бизнесийн боломж”, “БНСВУ-ын жижиг дунд үйлдвэрийн хөгжлийн бодлого”, “Монгол, Вьетнамын харилцааг цаашид хөгжүүлэх боломж, арга замын асуудалд” гэсэн илтгэлүүдийг тавьж хэлэлцүүлээ.

Энэхүү эрдэм шинжилгээний хурлаар Монгол-Вьетнамын харилцааг улс төр, эдийн засаг, соёл зэрэг бүхий л талаас нь хамран ярилцаж, хоёр орны хооронд дипломат харилцаа тогтсоноос хойш 65 жилийн түүхэн замнал, ололт амжилтыг дүгнэн хэлэлцэж, хоёр талын харилцааны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийсний зэрэгцээ цаашдын хамтын ажиллагааны хэтийн төлөв, боломжийн талаар илүүтэй анхааран хэлэлцсэн нь ихээхэн ач холбогдолтой боллоо.

“Хагас зууны түүх ба хөгжлийн чиг хандлага” Олон улсын харилааны хүрээлэнгийн захирлаас ШУА-ийн Ерөнхийлөгчтэй байгуулсан 2019 оны Үр дүнгийн гэрээний Тусгай захилгат судалгааны хэрэгжилт, үр дүнг хангах ажлын хүрээнд 2019 оны 6 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг тохиолдуулан олон улсын эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион байгуулсан. Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг УИХ дахь Монгол-Туркийн Парламентын бүлэг, Гадаад харилцааны яам, Улаанбаатар дахь БНТУ-ын ЭСЯ, Анкара дахь Монгол Улсын ЭСЯ, Туркэд Төгсөгчдийн Хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”-ын нэрэмжит танхимд амжилттай зохион байгуулав.

“Бүс нутгийн интеграц ба Монгол Улс” суурь судалгааны ажлын хүрээнд 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдөр олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Монгол Улс, ОХУ, БНХАУ, Британий эрдэмтдийн оролцоотойгоор ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын хурлын танхимд амжилттай зохион байгуулав.

Бүс нутгийн интеграцийн өнөөгийн нөхцөл байдал, түүнд Монгол Улсын оролцоо, боломжийн талаар Монгол, Хятад, Орос, Британи зэрэг улсын 10 гаруй эрдэмтэн судлаачид өөрсдийн судалгааны үр дүнгээ илтгэн хэлэлцүүлээ. Хурлын үйл ажиллагаа анхнаасаа тавьсан зорилгоо бүрэн биелүүлсэн гэдгийг онцлон тэмдэглэж байна.

3. Судалгааны сэдэвт ажлын хүрээнд хийгдсэн эрдэм шинжилгээний өгүүлүүдийн заримаас тоймолвол:

Сэдэвт ажлын гүйцэтгэгч доктор Ц.Баатар, Монгол улсын сэргээгдэх эрчим хүчийг ЗХА-ийн орнуудын эрчим хүчний системтэй холбох арга зам, ач холбогдолын талаар профессор Н.Энэбиштэй хамтран “NEA: Interconnection and Energy Security” судалгааны томоохон өгүүлэл бичиж “International Journal of Science and Research” (IJSR) ISSN: 2319-7064 Шинжлэх ухаан, судалгааны олон улсын сэтгүүлийн Volume 8 Issue 3, March 2019-ны дугаарт нийтлүүлсэн.

Энэхүү судалгааны өгүүлэлд Монгол Улс дахь нар, салхины эрчим хүчний арвин их нөөцийг ЗХА-ийн эрчим хүчний системд холбох боломж, сорилт, судалгааны өнөөгийн үр дүнг нэгтгэн дүгнэж, Зүүн хойд Азийн бүс нутгийн Эрчим хүчний хамтын ажиллагааны хэтийн төлөв чиг хандлагын талаар нарийвчлан авч үзжээ. Үүнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Зүүн хойд Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээ байгуулах, Монгол Улс дахь нар, салхины эрчим хүчний арвин их нөөцийг ашиглах асуудалд бүс нутгийн орнуудын хандлага болон дэлхийн банк санхүүгийн байгууллагуудын санаачлага зэрэг өргөн цар хүрээтэй асуудлыг авч үзээд Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний судалгааны дүнгийн талаар гадны эрдэмтэн судлаачдад зориулан тодорхой авч үзсэн байна. Өгүүлэлд Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хамтарсан судалгаагаар, Монгол Улс 200 гигаватт салхины эрчим хүч, 1.2 тераватт нарны эрчим хүч үйлдвэрлэж, хөрш орнууддаа экспортлох боломжтойг цохон тэмдэглээд. Үндэсний эрчим хүчний сүлжээг системтэйгээр өргөтгөж өндөр хүчдэлийн хил дамнасан холболтыг хөгжүүлэх замаар 2036 он гэхэд 100 гигаватт хүртэл хямд өртөгтэй, цэвэр эрчим хүч экспортлох боломжтой гэж тооцоолсон судалгааны үр дүнг танилцуулжээ.

Энэхүү судалгаа нь Зүүн хойд Азийн аюулгүй байдал, эдийн засгийн хамтын ажиллагаанаас гадна эрчим хүчний асуудлыг хөндөснөөс гадна Хятад, Өмнөд Солонгос, Япон зэрэг орны эрчим хүчний эрэлт хэрэгцээг дам судалж, эрчим хүчний салбарт бүс нутгийн орнууд хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж байгааг судалгааны үр дүнгээр харуулсан байна.

Судлаачид Монгол Улсын санаачилсан Говийн бүс нутагт эрчим хүчний “Азийн супер сүлжээ” байгуулах ажлыг хэрэгжүүлэх бүрэн боломжтой болохыг олон тооны судалгааны үр дүнгээр нотолсон байна. Түүнчлэн ЗХА-д Эрчим хүчний хамтын ажиллагааг хөгжүүлсэн Европын орнуудын туршлагыг ч энд дэлгэрэнгүй авч үзжээ.

Гадны эрдэмтэдийн зүгээс ач холбогдол өгсөн энэ өгүүллийн үр дүнгээр Хятад улсад болсон олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж хэлэлцүүлжээ.

Өндөр шалгууртай сэтгүүлд нийтлэгдсэн энэхүү өгүүллийг Google research болон бусад олон улсын судалгааны сэтгүүлүүдэд байршуулжээ. www.ijsr.net линкээр орж үзэж боломжтой.

ОУХХ-гийн ЭШТА, доктор (Ph.D) Д.Алтайн "Евразийн бүс нутаг дахь харилцан хамаарал: Монголын оролцоо, (ШХАБ-ын жишээн дээр)" сэдэвт өгүүллийн товч агуулга нь:

Дэлхийн социалист систем, ЗХУ бутран унасны дараа ОХУ, БНХАУ болон Төв Азийн постсоциалист зарим орнуудын /Казахстан, Киргизстан, Тажикистан/ хамтын ажиллагаа, харилцан хамаарлын хэлбэр болонанх "Шанхайн тав" нэрээр 1996 онд үндэс суурь нь тавигдаж, 2001 онд Узбекистан Улс нэмэгдсэнээр ШХАБ нэртэй байгууллага бий болсон. Монгол Улс 2005 онд ШХАБ-д ажиглагч гишүүнээр нэгдэн орж, жил бүр зохион байгуулагддаг олон талт уулзалт, хурал зөвлөгөөнд оролцож ирсэн. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачлагаар ОХУ, БНХАУ, Монгол Улсын төрийн тэргүүн нарын гурван талт анхны уулзалт 2014 онд ШХАБ-ын гишүүн-орнуудын төр засгийн тэргүүн нарын Дээд хэмжээний уулзалтын хүрээнд болж, эдүгээ 4 удаа зохион байгуулагдаж, гурван талт хамтын ажиллагааны үр дүнтэй яриа хэлэлцээний механизм болон төлөвшив. Ийнхүү ШХАБ-ын тавцан нь Монгол Улсын Ерөнхийлөгч хөрш зэргэлдээ хоёр улсын төрийн тэргүүн нартай гурван талт уулзалт зохиогдох боломжийн талбар болов. 2016 оны 6-р сард Ташкент (Узбекистан) хотноо болсон Орос, Хятад, Монголын төрийн тэргүүн нарын гуравдах уулзалтын үеэр "Орос-Хятад-Монголын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр"-т гарын үсэг зурав. Хөтөлбөр нь гурван улсын дэд бүтцийн хөгжлийг дэмжих, дэлхийн зах зээлд эдгээр орны бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах, Евразийн интеграцийг дэмжин хөгжүүлэх зорилготой агаад тус Хөтөлбөрийн агуулгад Хятадын "Нэг Бүс, Нэг Зам" төсөл, Евразийн эдийн засгийн интеграцийг хөгжүүлэх Оросын санаачлага, Монголын "Талын зам" төслийн үзэл санаа тусгагдсан. Монголын "Талын зам" төсөл нь Орос ба Хятадын хооронд байгалийн хий, газрын тос, бусад бүтээгдэхүүнийг Монголын газар нутгийг дамжуулан тээвэрлэх үндсэн зорилготой.

Монгол Улс ба ШХАБ-ын харилцааны асуудлыг задлан шинжилсэний үндсэн дээр зохиогч Монгол Улс ба ШХАБ-ын ирээдүйн хамтын ажиллагааны боломж, тус байгууллагад жинхэнэ гишүүнээр элсэхэд тулгарах эрсдэл ба эерэг хүчин зүйлийн талаархи өөрийн санал, байр сууриа илэрхийлжээ.

ОУХХ-ийн ЭША, **магистр (М.А) З.Батчимэгийн** “Монгол Улсаас олон улсын байгууллагын өмнө хүлээх үүрэг хариуцлага, хүртэх үр ашиг: Зарим байгууллагын жишээн дээр” сэдэвт өгүүллийн товч агуулга нь:

Олон улсын байгууллагуудтай хөгжүүлж буй харилцаа нь олон талт хамтын ажиллагааны хүрээнд явагддаг. Олон талт хамтын ажиллагаа нь гурав болон түүнээс дээш тооны улс орон олон улсын харилцааны асуудлыг шийдвэрлэхээр гаргаж буй хамтын хүчин чармайлт юм. Олон талт хамтын ажиллагааг нэгдүгээрт, олон улсын гэрээ, конвенцийн дагуу байгуулсан олон улсын байгууллага, бүтэц, хоёрдугаарт, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх зорилгоор дэвшүүлсэн саналсанаачилга, үйл явц гэж хоёр ангилж үздэг. Олон талт хамтын ажиллагаанд оролцох нь хөгжиж буй орон болох Монгол Улсын хувьд гадаад бодлогын зорилтуудаа хэрэгжүүлэх чухал арга хэрэгсэл болох боломжтой юм.

Монгол Улсын гишүүнчлэл бүхий олон улсын байгууллагуудтай тогтоосон хоёр болон олон талын хамтын ажиллагааны үр ашгийг нарийвчлан судалж, үр өгөөжийг тогтоох нь нэн чухал асуудал юм. Монгол Улс гишүүнээр элссэн бөгөөд улсын төсвөөс татвар, хандив төлдөг олон улсын 75 байгууллага, албан ёсоор нэгдэн орсон олон улсын 25 гэрээ, конвенци байдаг бөгөөд үүнээс Азийн бүс нутгийн 5 байгууллагын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхийг энэ өгүүлэлд зорьж байна.

Монгол Улс нь дэлхийн хамтын нийгэмлэгийн нэгэн бүрэлдэхүүн болохын хувьд дэлхий дахины болон Азийн бүс нутгийн тулгамдсан асуудлыг олон улсын байгууллагын хүрээнд хэлэлцэж, нийтийн зөвшилцөлд тулгуурлан шийдвэр гаргахад оролцох эрх, үүрэгтэй. Энэ үүднээс авч үзэхэд, Монгол Улс олон улсын байгууллагын гишүүнчлэлээрээ дамжуулж, бүс нутагт харилцан ойлголцлыг бэхжүүлэх, улс хооронд харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, маргаантай асуудлыг шийдвэрлэхэд оролцох оролцоогоо нэмэгдүүлэх, улс орныхоо хөгжилд нэмэрлэх үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна. Тодруулбал, Монгол Улс олон талт үйл явцад оролцохдоо үндэсний ашиг сонирхлоо хамгаалах, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх, тэдгээрийн хүч бололцоог улс орныхоо хөгжилд үр дүнтэй ашиглахыг чармайн ажиллах хэрэгтэй. Чухам үүнд л олон улсын байгууллагад гишүүнчлэгдсэний гол ач холбогдол оршиж байна.

ОУХХ-ийн ЭША, **магистр (М.А) М.Болормаагийн** “Монгол, Японы худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал” сэдэвт өгүүллийн товч агуулга нь:

Шинэ мянганы эхэн үе буюу 2000 оноос хойшхи Монгол Японы худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдлыг Хөгжлийн албан ёсны тусламж

(ХАЁТ), худалдаа, хөрөнгө оруулалт, Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЕРА)-ийн хүрээнд тоймлон авч үзэх оролдлого хийлээ.

ОУХХ-ийн ЭША, **магистр (М.А) У.Загдцэсэмийн** “Тогтвортой хөгжил: Монгол, Японы хамтын ажиллагаа” өгүүлэлд дэлхий нийтийн хөгжлийн шинэ чиг хандлага болсон тогтвортой хөгжил, түүний зорилтуудыг хангахын төлөөх Япон улсын идэвхи чармайлт, Монгол улсын тогтвортой, урт хугацааны хөгжлийн зорилтуудыг хангахад Монгол, Японы хамтын ажиллагаа хэрхэн чиглэгдэж буй талаар товч өгүүлнэ.

ОУХХ-ийн ЭШТА, **доктор (Ph.D) Б.Сэржавын** “Монгол, Японы соёлын харилцааны хэлэлцээр, түүний түүхэн ач холбогдол” өгүүлэлд Япон улстай соёлын харилцааны хэлэлцээр байгуулсан түүх, нөлөөлсөн зарим хүчин зүйл, хамтын ажиллагааны эхлэл, өрнөл, түүний ач холбогдлын талаар хөндөн авч үзэхийг зорив. Соёлын харилцааны хэлэлцээрийн хүрээнд, Япон улстай хөгжүүлж ирсэн хамтын ажиллагаа нь хоёр ард түмний хооронд харилцан ойлголцол гүнзгийрэх, бүх салбарын найрсаг хамтын ажиллагаа хөгжихөд ихээхэн ач холбогдол үзүүлж, улмаар Монгол Японы харилцаа өнөөг хүртэл өргөжин тэлэх чухал суурь нөхцөлийн нэг байсаар ирсэн, цаашид ч энэ учир холбогдол буурахгүй хэмээн бодно.

ОУХХ-ийн ЭША, **доктор (Ph.D) Б.Цэнгэлхамын** “Ази, Номхон далайн бүс нутгийн геополитикийн онцлог” өгүүллийн товч агуулга нь XXI зуун гарсаар дэлхий дахинд даяаршил улам бүр тэлж, шинжлэх ухаан, мэдээллийн технологи үсрэнгүй хөгжин, улс төр, эдийн засгийн интеграци өргөжиж, улс хоорондын харилцан хамаарал гүнзгийрч байна. Олон улсын харилцаа өнгөрсөн зууны сүүлийн хагасын “хүйтэн дайн”-ы хоёр туйлт үеийнхээс олон туйлт харилцааны шинэ үед шилжин эрс өөрчлөгдлөө. Хөгжил, хамтын ажиллагааны шинэ томоохон төвүүд тодорч, тэдгээрийн хүрээн дэх харилцаа, хамтын ажиллагааны шинэ механизм бий болж, түүний олон улсын харилцааны ерөнхий үйл явцад үзүүлэх нөлөө өсөх болов.

Өнөө үед бүс нутгийн улс гүрнүүд хооронд олон талт яриа хэлцэл өрнөж, Европын Холбоо, АПЕК (АРЕС), АСЕМ (АСЕМ), АСЕАН (АСЕАН), 20-ийн бүлэг (G20), БРИКС (BRICS) зэрэг засгийн газар хоорондын хамтын ажиллагааны олон талт механизмууд идэвхитэй ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын хамтын ажиллагаа түргэн хурдацтай хөгжиж, дэлхийн улс төрийн бодлого, үйл явцад тэдгээрийн үзүүлэх жин нөлөө мэдэгдэхүйц өсөн нэмэгдэх болжээ. Харилцаа, хамтын ажиллагааны механизм ч өргөжин тэлж, шинэ агуулга, хэлбэртэй болж байна. Үүний тодорхой илрэл нь

Ази, Номхон далайн бүс нутагт төдийгүй дэлхий дахины олон улсын харилцааны механизмд хүчтэй нөлөөлөх болсон олон улсын улс төр, эдийн засгийн харилцааны томоохон институт болох АСЕАН, АПЕК юм.

АСЕАН, АПЕК бол дэлхийн улс төрийн бодлого, үйл явцын хүрээн дэх хамтын ажиллагааны том төв, бүс нутгийн харилцааны гол суурь тулгуур мөн хэмээн дүгнэжээ.

ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн дээр 3 жилийн хугацаанд хэрэгжсэн уг суурь судалгааны төслийн хэрэгжүүлэгчид дээрх олон улсын эрдэм шинжилгээний хурлын үр дүнд үндэслэн Монгол Улсаас хөрш орнууд болон бүс нутгийн хамтын ажиллагааны механизмуудын үйл ажиллагаанд оролцох боломжийн талаарх бодлогын зөвлөмжийг бэлтгэн төрийн холбогдох байгууллагад хүлээлгэн өгөөд байна.

ЭШТА, доктор (Sc.D) О.Батсайхан “Солонгосын хойгийн хурцадмал байдлыг намжаахад Монгол Улсын үүрэг, оролцоо”, ОУХХ-ийн зөвлөх, доктор (Sc.D) Л.Хайсандай “Бүс нутгийн интеграц, хамтын ажиллагаа: Монгол Улсын оролцох шаардлага, боломж”, ОУХХ-ийн ЭША, доктор (Ph.D) Б.Цэнгэлхам “АСЕАН, АПЕК-ийн үйл ажиллагаан дахь Монголын үүрэг оролцоог нэмэгдүүлэх шаардлага, боломж” сэдвээр бодлогын зөвлөмжийг 2018 оны 11-р сард Үндэсний аюулгүй байдлын ажлын алба, Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлэв.

ДУГНЭЛТ

1. Сэдэвт ажлын хүрээнд дэвшүүлсэн зорилго хийгээд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг амжилттай биелүүлж, гэрээнд тусгагдсан бүтээлүүдийг тоо чанарын хувьд давуулан биелүүлсэн үзүүлэлттэй байна.

2. Тус хүрээлэнд 2010-2012 онд хэрэгжиж дууссан “Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлого ба хүрээлэн буй бүс нутгууд дахь хамтын ажиллагааны механизмууд” сэдэвт суурь судалгааны ажлыг улируулан судалсан энэхүү судалгаа нь Азийн бүс нутгийн олон талт байгууллагуудад гарч буй хувьсал өөрчлөлт, шинэ олон талт байгууллагууд бий болж буй өнөөгийн нөхцөлд манай улсын гадаад орчны хувьсал өөрчлөлттэй уялдан олон талт хамтын ажиллагаанд оролцож ирсэн бодлого, үйл ажиллагааны өнөөгийн байдлыг шинэ гадаад орчинтой нь холбон авч үзсэнээрээ зохих ач холбогдолтой судалгаа болсон гэж үзнэ.

3. Сэдэвт ажлын хүрээнд туурвисан “Азийн бүс нутгийн байгууллагууд ба Монгол Улс” нэгэн сэдэвт хамтын бүтээл нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болох хоёр хөрш хийгээд “гуравдагч хөршийн бодлого”-той нягт харилцан уялдаатай өрнөж буй Азийн бүс нутгийн олон талт хамтын ажиллагааны байгууллагуудын өнөөгийн байдал цаашдын хөгжлийн чиг хандлага, хамтын ажиллагааны боломж, сорилтыг задлан шинжилсэн судлаачдынхаа байр суурийг нэгтгэн дүгнэж бодлогын шийдвэр гаргах түвшинд харгалзан үзэх санал дэвшүүлсэнээрээ шинэлэг ажил болсон гэж үзэж байна.

4. Ази номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа болон бүс нутгийн байгууллагууд дахь Монголын үүрэг оролцоо, үр өгөөжийн талаар цаашид ч улируулан судалж төр засгийн шийдвэр гаргах түвшний байгууллагуудад судалгааны үр дүнг тогтмол танилцуулж байх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

5. Энэхүү суурь судалгааны сэдэвт ажлын хүрээнд бодлогын судалгаа, зөвлөмжүүд хийгээд санал бэлтгэн төр засагт үйлчлэх үүргээ төлөвлөсөн хэмжээнд биелүүллээ. Бодлого боловсруулах төрийн байгууллагууд, шийдвэр гаргах эрх мэдэл бүхий хүмүүст хүргэсэн зарим зөвлөмж харьцангуй богино хугацаанд төрийн бодлого шийдвэрт тусан хэрэгжиж эхэлсэн нь уг ажлын ач холбогдолыг тодорхойлох үзүүлэлт боллоо хэмээн үзэж байна.

6. Сэдэвт ажлын үр дүнг нийгэм, олон нийтэд хүргэх талаар идэвхитэй ажиллаж, шинжлэх ухааны мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, ард иргэдийг соён гэрээрүүлэх үүргээ зохих ёсоор биелүүллээ. Судалгааны ажлын хүрээнд хамтын бүтээл, товхимол, орчуулгын ном 7-г хэвлүүлж нийтийн хүртээл болголоо. Дээрх хугацаанд эрдэм шинжилгээний бага хурал 6 удаа зохион байгуулж, төслийн гүйцэтгэгчид олон тооны өгүүлэл, илтгэл нийтлүүлж, хэвлэл

мэдээллийн хэрэгслээр нийтлэл ярилцлага, мэдээлэл, үйл явдлын тайлбар өгөх зэргээр судалгааны үр дүнг олон нийтэд сурталчилсан нь эрдэм шинжилгээ, практикийн зохих үр дүнтэй ажил болсон гэж үзэж байна.

Тайлан бичсэн:

Сэдэвт ажлын удирдагч

Д.Золбоо. Доктор (Ph.D),

дэд профессор

Хавсралт 1

**“АЗИЙН БҮС НУТГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ДАХЬ
МОНГОЛЫН ҮҮРЭГ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ”**

СЭДЭВТ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ /2017-2019/

НЭГ. НОМ, ХАМТЫН БҮТЭЭЛ

Хамтын бүтээл, өгүүллийн эмхэтгэл

1. “Азийн бүс нутгийн байгууллагууд ба Монгол Улс” УБ., 2020
2. Оуэн Латтимор, *Нүүдэлчид ба хувьсгалчид*, Нэмж засварласан хоёр дахь хэвлэл, Эрхлэн хэвлүүлсэн Д.Золбоо, Ц.Батбаяр, Хянан нягталсан Р.Төрдалай, З.Батчимэг, Улаанбаатар, 2019, 15,8 х.х.
3. “Хагас зууны түүх ба хөгжлийн чиг хандлага” олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, Монгол Улс, БНТУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд зориулав, Эмхэтгэн хэвлүүлсэн Ч.Цэрэннадмид, Хянан нягталсан Р.Төрдалай, Улаанбаатар, 2019, 11.5 х.х.
4. “Бүс нутгийн интеграц ба Монгол Улс” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Эмхэтгэн хэвлүүлсэн Б.Цэнгэллхам, З.Батчимэг, Хянан нягталсан Д.Золбоо, Р.Төрдалай, Улаанбаатар, Улаанбаатар, 2019, 9 х.х.
5. “Монгол-Вьетнамын харилцаа: Түүх ба орчин үе” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Монгол-Улс, БНСВУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ойд зориулав, Эмхэтгэн хэвлүүлсэн Б.Цэнгэллхам, З.Батчимэг, Хянан нягталсан Д.Золбоо, Р.Төрдалай, Улаанбаатар, 2019, 6.6 х.х.
6. *Даяаршил ба өнөөгийн Еврази: Түүх, хандлага, өөрчлөлтийн боломж*, Слав Еврази судлалын Зүүн Азийн олон улсын IX бага хурлын эмхэтгэл, Эмхэтгэсэн Ч.Цэрэннадмид, Хянан тохиолдуулсан Д.Алтай, УБ, Удам соёл, 2018, 31.5 х.х
7. *Европ судлал-3*, Европ судлал: Хэл, соёл, олон улс, орон судлал эрдэм шинжилгээний хоёрдугаар бага хурлын эмхэтгэл, Эмхэтгэсэн З.Батчимэг, Хянан тохиолдуулсан Д.Алтай, УБ, ШУТИС Хэвлэлийн газар, 2018, 21 х.х.

ХОЁР. БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ:

1. Ц.Баатар, “Азийн бүс нутгийн байгууллагуудын үйл ажиллагаан дахь Монголын үүрэг оролцоог нэмэгдүүлэх боломж”, 2019 он
2. Л.Хайсандай, “Бүс нутгийн итеграц, хамтын ажиллагаа: Монгол Улсын оролцох шаардлага, боломж”, ГХЯ-ны АНДОГ-т, 2018 оны 11 сар.

3. Б.Цэнгэлхам, “Азийн бүс нутгийн байгууллагуудын үйл ажиллагаан дахь Монголын үүрэг оролцоог нэмэгдүүлэх шаардлага, боломж”, ГХЯ-ны АНДОГ-т, 2018 оны 11 сар.

ГУРАВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ:

Д. Алтай

1. “Interconnectivity in the region of Eurasia: Mongolia’s presence in the SCO (Shanghai Cooperation Organization, *International Relations and Diplomacy* (ISSN 2328-2134), Volume 6, Number 6, June 2018, pp. 319-324.
2. “The European studies: Recent state and future perspectives (On example of Institute of International Affairs, Mongolian Academy of Sciences), *Central and Eastern Europe* /англи хэлээр/ ТЗЕСМХолбооны сэтгүүл, №4, 2018, 144-156-р тал.
3. “Евразийн бүс нутаг дахь харилцан хамаарал: Монголын оролцоо (ШХАБ-ын жишээн дээр)”, *Европ судлал*, Улаанбаатар, 3(2019), 8-15 дугаар тал.
4. “БНМАУ-ын талаархи ЗХУ-ын ашиг сонирхлын өөрчлөлт (1984-1990)”, *Монгол Улсын талаарх Орос, Хятадын ашиг сонирхол* хамтын бүтээл, Улаанбаатар, 2019.
5. “Trilateral cooperation of Mongolia, Russia and China in the field of environmental protection: Current state and tasks”, *Proceedings of China-Mongolia-Russia Think Tank Forum*, Ulaanbaatar, Mongolia, 2018.09.18-19, 318, pp.171-178.

Ш. Амангүл

1. 2018, “Immobile Populations as Anchors of Rural Ethnic Identity: Contemporary Kazakh Narratives of Place and Migration in Mongolia” *Population, Journal, Space & Place Special Issue*, <https://onlinelibrary.wiley.com/doi/abs/10.1002/psp.2148>, Impact factor:1.683, ISI Journal Citation Reports @ Ranking: 2016:8/26 (Demography), ISI Journal Citation Reports @ Ranking: 2016:32/79 (Geography), Online ISSN:1544-8452

Ц.Баатар

1. Монгол улсын сэргээгдэх эрчим хүчийг ЗХА-ийн орнуудын эрчим хүчний системтэй холбох арга зам, ач холбогдолын талаар Сэргээгдэх эрчим хүч судлаач, профессор Н.Энэбиштэй хамтран “Northeast Asia Interconnection and Energy Security” судалгааны өгүүлэл англиар бичиж Шинжлэх ухаан, судалгааны олон улсын сэтгүүлийн Volume 8 Issue 3, March 2019 Volume 8 Issue 3, March 2019-д нийтлүүлсэн. Өндөр шалгууртай

сэтгүүлд нийтлэгдсэн энэхүү өгүүллийг Google research болон бусад олон улсын судалгааны сэтгүүлд байршуулсан www.ijsr.net

Т.Бат-Амгалан

1. “Монгол Улсын эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлого, эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилтийн шинжилгээ”, *Pax Mongolica*, УБ, 2018, №1.
2. “Боломж, сорилтын дундах өмнийн говь”, *Pax Mongolica*, УБ, 2018, №1.
3. “Монгол Улс БНЭУ-ын харилцааны хөгжил чиг, хандлага” өгүүлэл, 2019 оны дугаар *Pax Mongolica Vol.5*

З.Батчимэг

1. "Монгол Улсаас олон улсын байгууллагын өмнө хүлээх үүрэг хариуцлага хүртэх үр ашиг: Зарим байгууллагын жишээн дээр", *Орчин цагийн Монгол Улсын гадаад харилцаа: Онол практикийн асуудлууд* сэдэвтэй эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, МУИС-ийн Олон улсын харилцааны нийтийн удирдлагын сургууль, Улаанбаатар, 2019 он, 213-220-р тал

М.Болормаа

1. “Монгол, Японы худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал” “Олон улс судлал” сэтгүүл. 2017 оны №1 (107)8 52-61-р тал.

А.Даваасүрэн

1. “Монгол Улсын эдийн засгийн бодлогын үр дүн”, *Pax Mongolica*, Улаанбаатар, 2018, №2 (7) 0,5 х.х.

У.Загдзэсэм

1. “Тогтвортой хөгжил: Монгол Японы хамтын ажиллагаа”, *Олон улс судлал*, 2017, №1(107), 36-51-р тал.

З.Мэнд

1. “АНУ, БНАСАУ-ын удирдагч нарын магадлалт уулзалт, хэлэлцээрийн нөхцөл байдал ба Монгол Улсад зохион байгуулагдах боломж”, *Pax Mongolica*, №1 (9) УБ, 2018, 90-110-р тал.
2. “БНУзбекистан Улсын хөгжлийн туршлага, аялал жуулчлал-худалдааны салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх бодит боломж”, *Олон улсын харилцаа*, 2019 №1/38 сэтгүүл.
3. “Монгол Улсын гадаад, дотоод орчны хувьслыг илтгэх зарим хүчин зүйлс” Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал: Өнөө ба ирээдүй. (хурлын эмхэтгэл) УБ.,2019.
4. “Монгол Улсын байгаль орчны хамгааллын асуудал” буюу “Environmental protection issues in Mongolia”сэдэвт өгүүлэл МУИС-ийн ОУХНУС-иас гаргадаг *World Affairs*. 2019, №1/39

Б.Саранчимэг

1. “Японы тогтвортой аялал жуулчлалын хөгжил ба Экотуризм”, “Олон улс судлал” сэтгүүл 2017, №1, 62-74-р тал.

2. “Японы аюулгүй байдлын орчин”, *Олон улс судлал*, УБ, 2018, №1.

Б.Сэржав

1. “Монгол Японы соёлын хэлэлцээрийн түүхэн ач холбогдол”, *Олон улс судлал*, Улаанбаатар, 1(2018),5-17 дугаар тал.

Б.Цэнгэлхам

1. “Ази, Номхон далайн бүс нутгийн геополитикийн онцлог”, *Олон улсын харилцаа сэтгүүл*, Улаанбаатар, 1(2019).

2. “Монгол, Вьетнамын худалдаа”, *Trade and sustainable development IV*, Улаанбаатар, 2019 он

Ч.Цэрэннадмид

1. “Туркийн дотоод улс төрийн байдал, Төв Азийн орнууд, Монгол улстай харилцахад нөлөөлөх нь”, *Олон улс судлал*, 2017, №1 (107) 131-142-р тал.

2. “Bilateral cooperation between Mongolia and the Republic of Turkey in last decades”, *Globalization and Modern Eurasia: History, Trends, Challenges for Change*, The Ninth East Asian conference on Slavic Eurasian studies, Ulaanbaatar, 2018, ”Udamsoyol” Printing company, pp. 51-60.

3. “Монгол-Туркийн хоёр талт хамтын ажиллагаа сүүлийн 20 жилд”, “*Eurasia Cultura*”, Vol. 4, March 2019, БНСУ-ын Чунаний Их сургуулийн Гадаад орон судлалын хүрээлэн, 21-41 дүгээр тал.

4. “Олон улсын харилцааны хүрээлэн ба Турк судлал”, *Монгол, БНТУ хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд зориулсан ОУЭШБХурлын эмхэтгэл*, Улаанбаатар, 2019, 106-111 дугаар тал.

И.Энхболд

1. “Монгол Улс, БНСУ-ын худалдааны харилцаа”, *Олон улс судлал*, 2017 оны №1 (107), 101-122-р тал.

2. “Монгол Улс, БНСУ-ын хоорондох худалдааг сайжруулах арга замууд”, Монгол Улсын гадаад бодлого, дипломат ажиллагааны асуудлууд, өгүүллийн эмхэтгэл, 165-177 дугаар тал.

ДӨРӨВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ:

Д.Алтай

1. “Монгол, Орос, Хятад Улсын хүмүүнлэгийн солилцооны салбарын хамтын ажиллагаа: Зорилт ба өнөөгийн байдал”, *Слав-Еврази судлалын Зүүн Азийн олон улсын X бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл*, Токио Их сургууль, 2019.06.29-30.
2. “Хүрээлэн буй орчныг хамгаалах салбар дахь Монгол, Орос, Хятадын гурван талт хамтын ажиллагаа: Өнөөгийн байдал ба цаашдын зорилт”, *Хятад, Монгол, Оросын Тинк Танкын олон улсын форумын илтгэлүүдийн эмхэтгэл*, Улаанбаатар, 2019.

Ш.Амангүл

1. “Монгол Казахстаны харилцаан дахь Казах иргэдийн шилжилт хөдөлгөөн” //Олон улсын харилцааны тулгамдсан асуудлууд одоо ба ирээдүй” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, Их засаг Олон улсын Их Сургууль, 2018.05.07.
2. “Монгол Казахстаны соёлын хамтын ажиллагааны зарим асуудлууд”, “Монгол-Казахстаны найрамдал, хамтын ажиллагааны гэрээ-25 жил: Өнгөрсөн ба Ирээдүй”, хэлэлцүүлэг МУЗГХЭГ-ын дэргэдэх Удирдлагын Академи, БНКУ-аас МУ-д суугаа Элчин сайдын яам, 2018.10.19.

Ц.Баатар

1. “Азийн бүс нутгийн интеграц ба Монгол Улс” үндсэн илтгэл англи хэлээр “Бүс нутгийн интеграц ба Монгол Улс” олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн.

З.Батчимэг

1. “ХБНГУ-ыг гадаад бодлого: Гадаад хэргийн сайдын хэлсэн үгэнд хийсэн дүн шинжилгээ, *Европ судлал: Хэл, соёл, олон улс, орон судлал-II* эрдэм шинжилгээний бага хурал, Улаанбаатар, 2018.02.07.
2. "Монгол Улсаас олон улсын байгууллагын өмнө хүлээх үүрэг хариуцлага хүртэх үр ашиг: Зарим байгууллагын жишээн дээр", *Орчин цагийн Монгол Улсын гадаад харилцаа: Онол практикийн асуудлууд* сэдэвтэй эрдэм шинжилгээний хурал, МУИС-ийн Олон улсын харилцааны нийтийн удирдлагын сургууль, Улаанбаатар, 2018.12.07.
3. “Европын Холбооны интеграцчилалыг “хоёр замаар явуулах” үзэл баримтлалын асуудалд”, Европын Холбоо Судлалын Ази Номхон Далайн Орнуудын Нийгэмлэг, Европ судлалын ээлжит хурал 2019, Шинэ Манлайлал, Шинэ Тэргүүлэх ач холбогдол, Шанхай, 2019.07.06-08.
4. “Монгол Улсаас олон улсын байгууллагын өмнө хүлээх үүрэг хариуцлага, хүртэх үр ашиг: Зарим байгууллагын жишээн дээр. Монгол Улсын гадаад бодлого, дипломат ажиллагааны асуудлууд”, Улаанбаатар, Монгол Улсын Их Сургууль, Нийтийн Удирдлагын Сургууль 2019, 213-222 дугаар тал.
5. Европ судлал эрдэм шинжилгээний сэтгүүлийн №3-д “Европын интеграци хоёр замаар өрнөх үзэл баримтлалын асуудал” сэдвээр өгүүлэл бичиж нийтлүүлэв.

М.Болормаа

1. “Япон Улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хэрэгжилтийн эхний төлөв байдал /2016-2018/”, МУИС-ийн ОУХНУС-иас зохиосон ЭШБХ, Улаанбаатар, 2018.12.07.

К.Дэмбэрэл

1. Евразийн үзэл санаа ба Монгол Улс.//Европ судлал: Хэл, соёл, олон улс, орон судлал- II” эрдэм шинжилгээний бага хурал, Улаанбаатар, ШУА, МУИС, Төв ба Зүүн Европ судлалын Монголын холбоо, 2018.02.07.

Ц.Лхам

1. “Европын Холбооны нэгдсэн гадаад бодлогын шинэчлэлийн төлөв.// Европ судлал: Хэл, соёл, олон улс, орон судлал- II” эрдэм шинжилгээний бага хурал. Улаанбаатар. 2018.2.7.

Т.Бат-Амгалан

1. “Монгол Энэтхэгийн өнөөгийн харилцаа”, *Science Diplomacy сургалт*, семинар, Дели, 2018.01.06.

А.Даваасүрэн

1. “Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудыг Монгол Улс хэрэгжүүлж байгаа туршлага”, НУБ-ын Ази, Номхон далайн салбараас зохион байгуулсан Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэлхийн улс орнууд хэрэгжүүлж байгаа байдал симпозиум, БНСУ-ын Инчён, 2018.10.23-28.

Д.Золбоо

1. “European Studies in Mongolia” *Европын холбоо судлалын Ази-Номхон далайн холбооны 2018 оны ээлжит их хурал*, Тайваний үндэсний их сургуулийн дэргэдэх Тайвань дахь Европын холбоо судлалын төв, Тайпэй, 2018.06.28-29.

2. “Are we neighbors? The relationship between Mongolia and Taiwan”, Taiwan National University, Taipei, 2018.05.04.

3. “Монгол Улсын гадаад худалдаанд чөлөөт худалдааны гэрээ хэлэлцээрийг нэвтрүүлэх асуудалд” Монгол, Орос, Хятад 3 улсын “Тинк танк-форум”, БНХАУ-ын Хөх хот, 2019 оны 7 дугаар сарын 22-25-нд оролцох илтгэлээ бичиж зохион байгуулах комисст илгээсэн.

4. “ЗХА ба Монгол Улс”, БНСУ-ийн Бусан хотод 2019 оны 12 дугаар сарын 12-13-нд зохион байгуулагдсан “Монгол, Солонгосын хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойн бэлтгэл, хөгжлийн чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурал.

5. “Монгол Улсын хил залгаа бүс нутгуудын судалгаа өнөөгийн байдал, цаашдын хандлага” сэдвээр илтгэл Үндэсний хөгжлийн газраас 2019.05.02-ны өдөр зохион байгуулагдсан “Монголчуудын үнэт зүйл” зөвлөлдөх уулзалт.

Б.Цэнгэлхам

1. “Монгол, Вьетнамын худалдаа”, Монгол Улсад худалдааны салбар үүсч хөгжсөний 98, ХҮИС-ийн 95 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан “Худалдаа ба Тогтвортой хөгжил-IV” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, Улаанбаатар, 2019.10.11.
2. “Монгол-Вьетнамын харилцааны уламжлал, ирээдүй” эрдэм шинжилгээний илтгэл, Монгол-Вьетнамын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ойд зориулсан “Монгол, Вьетнамын харилцаа: Түүх ба орчин үе” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, 2019.05.15.

Ч.Цэрэннадмид

1. Development of bilateral cooperation between Turkey and Mongolia in the last decade.// “Globalization and Modern Eurasia: History, Trends, Challenges for Change”. Ulaanbaatar. 2018.06.30.

И.Энхболд

1. “Монгол Улс, БНСУ-ын худалдааны харилцаа”, *БНСУ-ын Дангүг их сургуулиас зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурал*, Сөүл, 2018.12.14.
2. “Монгол Улс, БНСУ хоорондын харилцааны зураглал”, БНСУ-ийн Бусан хотод 2019 оны 12 дугаар сарын 12-13-нд зохион байгуулагдсан “Монгол, Солонгосын хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойн бэлтгэл, хөгжлийн чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурал.

ТАВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ, СЕМИНАР

1. “Европ судлал: Хэл, соёл, олон улс, орон судлал” эрдэм шинжилгээний хоёрдугаар бага хурал, 2018 оны 2-р сарын 7, МУИС-ийн хичээлийн I байр, Дугуй заал.
2. *Даяаршил ба өнөөгийн Еврази: Түүх, хандлага, өөрчлөлтийн боломж*, Слав Еврази судлалын Зүүн Азийн олон улсын IX бага хурал, 2018 оны 6-р сарын 30-аас 7-р сарын 1, МУИС-ийн Төв номын сан.
3. “Монгол-Вьетнамын харилцаа: Түүх ба орчин үе”, Монгол-Улс, БНСВУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал, 2019 оны 5-р сарын 15, ГХЯ-ны Зөвшилцөл танхим.
4. “Хагас зууны түүх ба хөгжлийн чиг хандлага” Монгол Улс, БНТУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, 2019 оны 6-р сарын 7, Засгийн Газрын ордны Сүхбаатар танхим

5. “Бүс нутгийн интеграц ба Монгол Улс” олон улсын эрдэм шинжилгээний хурал, 2019 оны 6-р сарын 17, ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын хурлын танхим.

ЗУРГАА. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОРЧУУЛГА

1. Д.Алтай, Слав Еврази судлалын Зүүн Азийн 10-р бага хурлын зар, бүртгэлийн материалыг англиас хөрвүүлж, ТЗЕСМХ-ны гишүүд болон сонирхогч судлаач багш нарт түгээв. Тус хуралд Монголоос 3 хүн оролцохоор бүртгүүлж илтгэлийн сэдэв, хураангуйг илгээсэн. 0.2 х.х
2. Д.Алтай, ICSEES дэлхийн Холбооноос их хуралтай (2020 оны 8 дугаар сард Канадад болох) холбоотой ирсэн мэдээллийг 2 удаа орчуулж, Холбооны УЗ-ийн гишүүд болон бусад хүмүүст түгээн илгээв. 0.2 х.х 2019 оны 5-9 дүгээр сард.
3. З.Батчимэг, ШУА-ийн Олон улсын харилцааны Хүрээлэн, МУБИС-ын урилгаар зочилсон ХБНГУ-ын профессор, доктор С.Мерлийн "ЗХУ дахь авлигын онцлог шинж ба Пост социализм" сэдэвт лекцийн орчуулга, 10 хуудас.
4. М.Болормаа, Япон хэлээр хэвлэгддэг “Япон ба Монгол” сэтгүүлийн 1990 оны дугаарыг монгол хэл рүү орчуулав.
5. М.Болормаа, МЯСН-ийн “Дайны дараах Монгол Японы харилцаан дахь ардын дипломат бодлогын үүрэг: Өнгөрсөн, одоо, ирээдүй” олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлийг орчуулж, Японы ЭСЯ-д өгөв.
У.Загдцэсэм, М.Болормаа нар ГХЯ-ны ажлын хэрэгцээнд зориулан Халхын голын дайны талаарх Японы Майничи сонин, Номон хааны дайны тухай NHK телевизийн баримтат киноны материалыг /47 хуудас/ орчуулав. 2.5 х.х
6. Ч.Цэрэннадмид, С.Ийгит, “Турк, Монголын хоёр талт харилцаа: түүхэн угсаа ба нөлөөлж буй олон улсын харилцааны хүчин зүйлс” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллийн орчуулга, *Монгол, БНТУ хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*, Улаанбаатар, 2019, 51-55 дугаар тал.
7. Ч.Цэрэннадмид, В.Чакан, “Шинэ торгоны зам ба Төв Азийн бүс нутаг дахь хүчний тэнцвэр, Туркийн дунд коридорийн төсөл” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллийн орчуулга, *Монгол, БНТУ хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*, Улаанбаатар, 2019, 96-105 дугаар тал.
8. Ч.Цэрэннадмид, Монгол Улсын ШУА, НҮБ-ын ЮНЕСКО хамтран зохион байгуулсан ЮНЕСКО-ийн нийгмийн өөрчлөлтийн удирдлага хөтөлбөрийн хүрээнд “Нийгмийн

тэгш бус байдлыг бууруулах нь: Мэдлэгээс төрийн бодлогод” семинараас гарсан зөвлөмжийн орчуулга, Улаанбаатар, 2019.11.10.

9. Ч.Цэрэннадмид, ШУА-ийн Олон улсын харилцааны Хүрээлэн, МУБИС-ын урилгаар зочилсон ХБНГУ-ын профессор, доктор С.Мерлийн "ЗХУ дахь авлигын онцлог шинж ба Пост социализм" сэдэвт лекцийн орчуулга, 10 хуудас.
10. Ч.Цэрэннадмид, Богд хаан 150: Түүх, өв, соёл олон улсын эрдэм шинжилгээний хурлын хөтөлбөрийн орчуулга, Улаанбаатар, 2019.10.11, 4 хуудас.

ДОЛОО. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ШҮҮМЖ

1. Д.Алтай, Шинжээчийн судалгааны анкет: ОХУ-ын Дорж Банзаровын нэрэмжит Буриадын ИС ба ШУА, ОУХХ “Орос-Монголын харилцаан дахь “Зөөлөн хүч”: харьцуулсан судалгаа” хэмээх хамтарсан грант төслийн хүрээнд энэхүү ажлыг гүйцэтгэв. 2019.11.15-18.
2. Д.Алтай, *Хагас зууны түүх ба хөгжлийн чиг хандлага* Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэлийн Өмнөх үгийг бичив, Улаанбаатар, 2019.11.14.
3. Ц.Лхам, К.Дэмбэрэл, *Олон улсын харилцааны онол, үйл ажиллагааны үндэс” бүтээл* (Шүүмж) Улаанбаатар, 2019.10.03.

Хавсралт 2

ХОЁР. БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ:

“АЗИЙН БҮС НУТГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ
МОНГОЛЫН ҮҮРЭГ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ”

Ц.Баатар, ОУХХ-ийн зөвлөх, доктор (Sc.D)

Дэлхий ертөнц маш хурдацтайгаар хувьсан өөрчлөгдөж, бидэнд тулгарч буй сорилт, бэрхшээлүүд нэмэгдэж, улс орнуудын харилцан хамаарал улам бүр гүнзгийрч, аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ орчин бүрэлдэж байна. Олон улсын тавцанд гарч буй эдийн засгийн хүндрэлтэй асуудлууд улс төрөөс ихээхэн хамааралтай болж байна. Нөгөө талаас дэлхий даяаршиж, шинэ шинэ боломжууд гарч ирж байна. Эдгээр хүчин зүйлс нь Монгол Улсаас олон улсын хамтын нийгэмлэгийн хүрээнд явуулах бодлого, хоёр болон олон талт дипломат үйл ажиллагаанд урьд өмнөхөөс илүү түлхүү ач холбогдол өгч ажиллах зайлшгүй шаардлага урган гарч байна. Энэ хэрээр сонгодог дипломат үйл ажиллагааны эдийн засгийн ач холбогдол ч мөн нэгэн адил улам бүр өсөн нэмэгдэж байна. Үүнээс үүдэн бид гадаад орчин, нөхцөл байдлаа тандан судалж, Азийн бүс нутгийн нэр нөлөө бүхий хүчирхэг олон талт байгууллагуудын үйл ажиллагаанд улам бүр идэвх санаачлагатай оролцох эрэлт хэрэгцээ урган гарч байна.

Бүс нутгийн аливаа нэгэн байгууллагад элсэх ч сайн муу олон талтай, элсэхгүй байх ч сайн муу олон талтай. Эдгээрийн жин банг тааруулж, шийдвэр гаргана гэдэг бол их эмзэг, туйлын зовлонтой асуудал юм. Юуны өмнө эхлээд Монгол Улсын гадаад орчны өөрчлөлт, түүний чиг хандлага, нөлөө хамаарал, гарах эерэг, сөрөг үр дагварыг олон талаас нь нягтлан судлах шаардлагатай. Ийм судалгаа байхгүй бол ямар ч шийдвэр гаргах боломжгүй, мөн алив яриа хэлэлцээр өрнүүлэх нь утга учиргүй.

Монгол улсын гадаад орчин хурдацтай хувьсан өөрчлөгдөж байгаа өнөөгийн нөхцөлд Азийн бүс нутгийн уламжлалт болон шинэ олон талт байгууллагуудын гүйцэтгэж буй үүрэг роль, цаашдын чиг хандлагын талаар ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын хийж буй судалгааны ажлын зарим үр дүнгээр товч танилцуулга, зөвлөмжийг Та бүхэнд хүргүүлж байна.

Судалгаанд суурилсан гадаад бодлогын ач холбогдол өсөн нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд бидний судалгааны үр дүнгээс бодлогын шийдвэр гаргах түвшинд санаа авахад илүүдэхгүй байх гэдэг үүднээс Азийн бүс нутгийн байгууллагуудын үйл ажиллагааны онцлог, жин нөлөө, хувьсал өөрчлөлт, түүнд Монгол улсын оролцоог нэмэгдүүлэх боломжийн талаарх судалгааны танилцуулгыг гадаад орчинтой нь холбон авч үзлээ.

Монгол улсын газар зүйн байршил. ЮНЕСКО-гийн албан ёсны тодорхойлолтоор газар зүйн утгаараа Монгол улс нь Төв Ази, Зүүн Азийн завсарт байрладаг. Гэхдээ Төв Ази тал руугаа арай илүү их шахаж байрласан орон юм. Төв Азийн бүс нутагт Монгол, Баруун хойт Хятад буюу Шинжаан, Төвд, Өвөр Монгол, Цинхай, Сичуан мужийн баруун, Ганьсу мужийн

хойт хэсэг, Оросын Азийн бүсийн тайгын бүсийн өмнөд хэсэг буюу Сибирь, мөн Казакстан болон Дундад Азийн Киргиз, Узбекистан, Туркмен, Тажикстан зэрэг 4 улс орно.

Эдгээр нутаг, улсууд бол Монголын гадаад, чингэхдээ шууд шүргэлцэх орчныг бүрдүүлдэг. Хэрэв газар зүйн ойлголт улс төр, эдийн засгийн ойлголттой тэр болгон давхцдаггүй гэдгийг харгалзвал Япон, хоёр Солонгос манай хөршүүд болох нь маргаангүй.

Бид бүс нутгийн олон талт хамтын ажиллагаанд оролцохдоо Орос болон Хятадыг ор тас орхиж, тэднийг давуулан, тэднээс огт өөр гадаад орчин бүрдүүлэх гэж зүтгэх нь үл гүйцэлдэх санаа гэдэг нь эндээс тодорхой харагдаж байна.

Монгол улсын газар зүйн онцлогийг харгалзан үзвэл лавтай бүс нутгийнхаа ОХУ, БНХАУ, Япон, Солонгостой харилцан хамааралтайгаар гадаад бодлогоо явуулах ёстой нь шууд ойлгогдоно. Дээрх гадаад орчны хүчин зүйлсээс улбаалан Монгол улс ямар орон зайд багтах, хэнтэй эвсэх, хэнийг дагах, гол нь бүс нутгийн ямар бүтэц, байгууллага, форумд элсэх, интеграцчилагдах гэхчлэн олон асуудлыг араасаа дагуулдаг.

Аль ч улс гүрэн орь ганцаараа хөгждөггүй. Эхлээд хөршүүдтэйгээ, дараа нь бүс нутагтаа, дараа нь тивдээ, дараа нь дэлхийн түвшинд интеграцид ордог зүй тогтолтой. Газар зүйн байршлыг харгалзан энэ бүс нутагт өрнөж буй олон улсын байгууллагуудын талаар цухас тоймлон авч үзье.

Төв Ази. Энэ бүс нутаг дэлхийн гол үйл явдлаас алслагдсан, Орос, Хятадаас бүрэн хамааралтай учир Монголтой төсөөтэй. Бүсийн орнууд ашиг сонирхолоо хамтын хүчээр хэрэгжүүлэхэд чиглэсэн гишүүн, ажиглагч, түнш, урилгын зочин гэх мэт олон статус бүхий Central Asian Union (CAU), Economic Cooperation Organization (ECO), Economic Cooperation Organization Secretariat, Economic Cooperation Organization Trade Agreement гэх мэт олон тооны байгууллага, форумууд бий нь бий. Монгол Улсын хувьд лалын энэ бүс нутгийн аль ч байгууллагад эвсэн нэгдэх онцгойлон үзэх ямар нэг ашиг сонирхол харахан байхгүй байна.

Энэ бүс нутагт олон улсын чанартай байгууллага гэвэл Армян, Беларус, Орос, Казахстан, Кыргыз улсуудыг нэгтгэсэн Евразийн эдийн засгийн холбоо орно. Энд Төв Азийн хоёр улс нэгдсэнийг эс тооцвол, тэдний хамтарсан өөр холбоо алга байна. Тэгээд ч энэ холбоонд орсон жижиг орны үйлдвэрлэгчид том орны гаалийн татваргүй бараанд цохигдон дампуурч байгаа мэдээлэл байна. Хятад улс Евразийн эдийн засгийн холбоотой Чөлөөт худалдааны хэлэлцээрт гарын үсэг зурсан боловч ямар ч бараа бүтээгдэхүүнд тарифын хөнгөлөлт үзүүлэхийг дэмжихгүй байна. Иран, Серби, Вьетнам бүгд Евразийн гишүүн орнуудтай ЧХХ-тэй. Манай

улсын хувьд энэ байгууллагад элсэх гэхээсээ илүү тодорхой нөхцөлтэй, хязгаарлагдмал хүрээнд ЧХХ байгуулах боломж бий.

Нэмж дурдахад Хятадын бүс ба зам санаачилга энэ бүс нутагт эрчимтэй хэрэгжиж, эдийн засаг нийгмийн хөгжилд нь зохих хувь нэмэр оруулж байгааг үгүйсгэхгүй ч зарим улс нь “залгиж чадахгүй” том төслүүд “үмхэж” байгаа нь улс төр, эдийн засгийн эрсдэл дагуулж байгааг олон улсын шинжээчид сануулсаар байгаа билээ.

Харин өнгөрсөн хугацаанд энэ бүс нутгийн хөгжилд АХБ түүний олон талт түншүүд ихээхэн анхаарал тавьж, олон тооны төсөл амжилттай хэрэгжүүлж ирснийг энд цохон тэмдэглэх нь зүйд нийцэх биз ээ.

Төв Ази ба АХБ. Төв Азийн олон талт хамтын ажиллагааг АХБ хөгжлийн түншүүдийн хамт өнөөг хүртэл ивээн тэтгэж олон тооны төсөл хөтөлбөр амжилттай хэрэгжүүлж байна. АХБ-ны Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр (CAREC) нь 2001 оноос хэрэгжиж эхэлснээс хойш тээврийн холболт, эрчим хүчний хамтын ажиллагаа, худалдааг хөнгөвчлөх санаачлагуудад нийтдээ 30 гаруй тэрбум ам. долларын хөрөнгө оруулалт хийжээ. 2017 оны 10 дугаар сард CAREC-ийн гишүүн орнуудын сайд нарын баталсан стратеги нь хамтын болон тогтвортой хөгжлийн төлөөх хөгжлийн түншүүд, хувь хүмүүс, томоохон сангуудын оролцоотойгоор төлөвлөсөн төслүүдийг бодлогоор холбон зангидах замаар бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх чиглэлээр ихээхэн хүчин чармайлт гарган амжилттай хэрэгжүүлж ирлээ.

CAREC-ийн гишүүн орны хувьд манай улс ч дээрх төсөл хөтөлбөрийн хүрээнд баруун бүс Азийн хурдны замын босоо тэнхлэгийн зорчигч, ачаа тээврийн хатуу хучилттай замаар холбогдлоо. Ингэснээр Төв, Дундаг Ази, булангийн орнууд хийгээд Оросын баруун Сибир, цаашлаад Европын орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцаагаа өргөтгөн хөгжүүлэх нэн таатай боломж бүрдлээ. Түүнчлэн төвийн босоо тэнхлэгийн Дархан-Улаанбаатар чиглэлийн замыг ч АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж эхлээд байгаа нь хөршүүдтэй байгуулсан ачаа тээвэр, хил орчмын хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрүүдийн хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Эдгээр нэн таатай боломжийг хэр зэрэг үр ашигтай, санаачлагатай ашиглах биднээс хамаарах болоод байна.

Одоо бид хоёр хөршийн олон талт хамтын ажиллагааны байгууллагуудын талаар цухас авч үзье.

ОХУ. Оросын Холбооны Улсын Азийн чиглэлд санаачилсан олон улсын чанартай байгууллагын тоо ч чамгүй олон. Эндээс тоймтойг нь авч үзэхэд Санкт-Петербургийн Олон улсын эдийн засгийн чуулганаас гадна газар нутгийнхаа 60 хувийг хамарсан 16 муж улсуудаа нэгтгэн, эдийн засгийн тусгай бүс болгох зорилт тавьж “Дорнын эдийн засгийн чуулган” гэсэн бүс хоорондын форум байгуулж маш идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү чуулга уулзалт нь Алс Дорнодын бүс нутгийн хөгжил төдийгүй Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд чухал ач холбогдолтой, нэр хүндтэй талбар, платформ болоод байна. Монгол улс энэ форумын олон талт үйл ажиллагаанд чухал ач холбогдол өгч үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцож, бүс нутгийн хэмжээний санал санаачлага дэвшүүлж, бүс нутгийн орнууд нэгдэн хамтарч ажиллахыг уриалж ирлээ. Түүнээс гадна манай улстай шууд холбогдох Оросын төвөөс алслагдсан хил орчмын бүс нутгийн хэмжээнд Чита муж, Буриад, Алтай, Тува улсуудыг нэгтгэсэн “Байгаль нуурын Эдийн засгийн хамтын нөхөрлөл” гэх мэт олон талт эвслүүд бий. Бид ОХУ-ын Алс Дорнод ба Байгаль нуурын бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрт түншлэн оролцож, хил орчмын бүс нутгуудтай нь хатуу, зөөлөн дэд бүтцээр холбогдож харилцан хамааралтай хөгжих, улмаар ЗХА-ийн олон талт интеграцид оролцох боломжийг судалж үзэх зайлшгүй шаардлага урган гарч байна.

Хятад. Хятад улс өнөөдөр бүс нутаг төдийгүй тив, дэлхийн хэмжээний олон талт байгууллага үүсгэн санаачилж томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, бүс нутагтаа голлон тоглогчийн нэг болон хүчирхэгжиж байна.

“Бүс ба Зам санаачлага” нь үндсэндээ Хятад улсын эдийн засаг, гадаад хийгээд аюулгүй байдлын бодлогын ашиг сонирхлыг хэд хэдэн томоохон төслөөр дамжуулан хэрэгжүүлэхэд чиглэсэн Евразийн ирээдүйн бүс нутгийн интеграцын талаархи Хятадын үзэл баримтлал юм. BRI нь гео-улс төрийн болон гео-эдийн засгийн хүчтэй хэмжигдэхүүн бүхий хөгжлийн санаачлагын хувьд Евразийн орнуудын хооронд дэд бүтэц, бодлого, худалдаа, санхүү, соёлын харилцан холболт, хамтын ажиллагааг дэмжихэд чиглэж байна. BRI-ийн хэрэгжилтэд өөрсдийнх нь санаачлан байгуулсан Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк (АИВ), Хөгжлийн шинэ банк (NDB) зэрэг тив, дэлхийн ихэнхи улс орнуудыг хамарсан гишүүнчлэлтэй, олон тооны түншлэлтэй банк санхүүгийн шинэ байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэж байна. Сүүлийн үед BRI төсөл хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, улс төр, эдийн засаг, нийгмийн болзошгүй эрсдлийн талаар олон түвшинд яригдаж, улс орнууд болгоомжтой хандахад хүргэж байгаа хэдий ч төсөл хөтөлбөр зогсолтгүй ургашилсаар байна. Хятад улс дээрх нөхцөл байдалд дүгнэлт хийж төслийн хүрээнд хэрэгжүүлж буй хөрөнгө

оруулалтын гэрээг хамгаалах, учирч болзошгүй эрсдлийг бууруулах арга хэмжээ авч аль аль талын ашиг сонирхолыг тэнцвэржүүлэх бодлого явуулж хэрэгжилтэнд нь хяналт тавьж эхэллээ. Ийнхүү Хятад улс газарзүйн хамрах хүрээгээ тэлэн өргөжүүлж, хөрөнгө оруулалтын асар их нөөц боломжоо ашиглан BRI санаачлагаа Евразид бүс нутгийн болон олон талт байгууллагын хамтын ажиллагааны стратеги болгон хувиргаж чадаж байна. Бүс нутгийн чөлөөт худалдаа, олон талт харилцаа, хамтын ажиллагааных нь стратегид Боао форум ч зохих үүргээ гүйцэтгэж байна.

Бүс ба Зам санаачлагын төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор байгуулсан олон улсын чанартай байгууллагын нэг бол яахын аргагүй Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк (АИВ) юм. Энэ банкыг Олон улсын байгууллагууд ч хүлээн зөвшөөрч Олон талт байгууллагын Ёс зүйн сүлжээ (ENMO)-нд 2019 оны сүүлчээр гишүүнээр элсүүлэн авлаа.

НҮБ-ын хүрээний уламжлалт хөгжлийн банкууд Хятадын тэргүүлсэн хөгжлийн шинэ банкуудын хооронд функциональ нэгдэл, хамтын ажиллагаа бий болж төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд түншлэн оролцож чухал үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал, Дэлхийн банк, АХБ тус тусдаа хамтын ажиллагааны болон хамтарсан санхүүжилтийн гэрээг АИВ, NDB-тэй байгуулсан бөгөөд түншлэн оролцож санхүүжүүлсэн төслүүд хэдийнэ хэрэгжиж эхлээд байна.

Монгол-Хятад-Оросын олон талт хамтын ажиллагаа. Гурван улсын Төрийн тэргүүнүүдийн хүрээнд хэлэлцэж тогтсон гурвалсан хамтын ажиллагааны хүрээнд Эдийн засгийн коридор байгуулах төсөл хөтөлбөр бидний хувьд хамгийн чухал шийдвэрлэх ач холбогдолтой төдийгүй бүс нутгийн интеграцид хатуу зөөлөн дэд бүтцээр холбогдох гарцыг нээж өгөх юм.

Орос, Хятадын Төрийн тэргүүнүүд хоёр улсын харилцааны статусаа өөрчилж “Шинэ эрин дэх Орос, Хятадын иж бүрэн стратегийн хамтын ажиллагааны харилцан итгэлцсэн түнш” болсноо зарлан тунхаглалаа. Бид ч хоёр хөрштэйгөө Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаатай боллоо. Ийнхүү гурван улсын олон талт хамтын ажиллагааны хүрээнд нэн тааламжтай орчин бүрдсэн энэ цаг үед бид хөгжлийн олон талт түншүүдтэйгээ хамтарч дээрх төсөл хөтөлбөрийн эхний ээлжийн зорилт болох гурван улсын транзит тээврийн өндөр хурдны авто зам, төмөр замын бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрүүдэд түлхүү ач холбогдол өгч, илүү их идэвхи санаачлагатай оролцож, боломжит бүх суваг, гуравдагч хөршүүдийг ч энд татан оролцуулж хугацаа алдалгүй хэрэгжүүлж эхэлмээр байна.

Энд нэмж өгүүлэхэд гурван талт хамтын ажиллагааны хүрээнд ОХУ Курагино-Кызыл чиглэлийн төмөр замын магистралыг богино хугацаанд барьж дуусгахыг зорьж байна. Энэ нь

Тувагийн Бүгд Найрамдах Улсын нийслэлээс үргэлжлүүлэн Монгол Улс, БНХАУ-ын төмөр замын сүлжээнүүдэд нэвтэрч, цаашлаад бүс нутгийн бусад улсын төмөр замын сүлжээнд холбогдох Евразийн хэмжээний ач холбогдолтой тул энэхүү төсөлд сонирхогч бүх түншүүд хамтран ажиллахыг Оросын тал уриалж байна. Манай улс бүтээн байгуулалтанд олон талт түншлэлийн хүрээнд хамтран ажиллаж байна

Энд нэмж тэмдэглэхэд хоёр хөршийн төрийн тэргүүнүүд манайд хандах хандлагад ч сүүлийн үед нааштай өөрчлөлт гарч тэд зарим томоохон төсөл дээр харилцан тохиролцож нягт хамтран ажиллахаа илэрхийлж байгаа билээ.

Хятадын Төрийн тэргүүн “танайд ашигтай, манайд хохиролгүй бол” бүх талаар туслан дэмжиж, томоохон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана гэсэн амлалт өглөө. ОХУ-ын Төрийн тэргүүн өнгөрсөн онд айлчлахдаа бүх салбарт итгэлцэлд түшиглэсэн хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлнэ гэдгээ илэрхийллээ. Түүнчлэн хоёр хөршийн Төрийн тэргүүнүүд манай нутгаар хийн хоолой тавих талаар тохиролцоонд хүрч, Оросын тал олон хувилбараар судалж эхэллээ. Тэр бүр олдохгүй энэ “алтан боломж” хэр удаан үргэлжлэхийг таашгүй. Гагцхүү бүх түвшинд идэвхи санаачлага, хүчин зүтгэл гарган тэдний итгэлийг дааж, үүрэг хариуцлага хүлээж, нягт хамтран ажиллаж чадах эсэх нь одоо зөвхөн монголчууд биднээс л шалтгаалах болоод байна.

Монгол Улс Азийн бүс нутагт эзлэх байр сууриа бататгаж, өөрийн харьцангуй давуу тал, уламжлалт харилцааны сувгуудыг сэргээн ашиглах замаар улс төр, эдийн засгийн интеграцид оролцох эхний алхам нь хоёр хөрштэй байгуулсан эдийн засгийн коридорын төсөл, хөтөлбөрүүд болж байна. Түүнийг хэрэгжүүлж чадах эсэх нь Монгол төрийн бодлого, үйл ажиллагаа хийгээд монголчууд биднээс ихээхэн шалтгаалах болно.

Тиймээс Монгол улсад тулгараад буй нарийн түвэгтэй, олон талт зорилтуудыг цогцоор нь шийдвэрлэхэд Азийн бүс нутгийн байгууллагуудтай харилцах харилцаа нь тэргүүн зэргийн ач холбогдолтой юм. Нэн тэргүүнд Оросын Сибирь, Алс Дорнод, БНХАУ-ын Зүүн хойд Азийн бүс нутагтай харилцан хамааралд орж улмаар Япон, Солонгостой нягт хамтран ажиллах нь бидний гол зорилт байх болов уу. Энэ чиглэлээр олон талт хамтын ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах нь аль аль талын стратегийн ач холбогдолтой юм.

Азийн бүс нутгийн шинэ олон талт байгууллагад элсэх асуудал нь манай улсын хүртэх үр өгөөж гарах зардал хийгээд бидний хүлээх үүрэг хариуцлага юу болох зэргийг олон талаас нь нягтлан судалж байж шийдэх нь зүйн хэрэг. Тэрнээс биш урилга ирүүлсэн байгууллага болгонд орно гэвэл эрсдэл, үргүй зардлын үүд хаалга л нэмэгдэх нь мэдээж хэрэг.

Энд нэмж хэлэхэд одоохондоо бүрэн бүрэлдээгүй олон туйлт шинэ дэг журмын нөхцөлд дэлхийн улс орнууд дахин бүлэглэгдэх нь гарцаагүй. Ямар ч гэсэн Орос, Хятад хоёр стратегийн нэгэн тал болж АНУ-ыг сөрөн зогсож байгаа нь зайлшгүй харгалзан үзэх бодит байдал болж байна.

Азийн бүс нутгийн интеграци ба Монгол Улс. Монгол Улсын хувьд гео-улс төр хийгээд гео-эдийн засгийн байршлын хувьд Азийн бүс нутагт хандах гол баримжаа болгож Ази, Номхон далайн бүс нутагт, тэр дундаа АСЕАН-нд төвлөрч, АСЕАН-ыг энэ бүс нутаг болон цаашлаад олон улсын хэмжээнд улам бүр чухал үүрэг гүйцэтгэх нөлөө бүхий хүчирхэг байгууллага гэж үзээд Гадаад бодлогынхоо үзэл баримтлалд тусган энэ чиглэлд идэвх санаачлага гарган ажиллаж ирсэн боловч дотоод гадаад орчны олон хүчин зүйлийн улмаас төдийлөн дорвитой ахиц өөрчлөлт гаргаж чадалгүй өнөөг хүрлээ. Бид алсаас зоримог эхэлсэн ч байж болох юм. Гэвч Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл нь энэ бүс нутаг болох нь гарцаагүй. Тийм ч учраас АСЕАН-ны төрөлжсөн байгууллагууд, түүний гишүүн орнууд, түншүүдтэй нь олон талт хамтын ажиллагаагаа өргөтгөн хөгжүүлэх чиглэлд ултай судалгаа хийж, гарах зардал, олох үр өгөөж, боломж нөхцөлөө нарийн тооцоолж, өнөөгийн хүрсэн түвшинг шат ахиулах чиглэлд санаачлагатай ажиллах шаардлага хэвээр байна.

Бүс нутгийн байгууллагууд бий болсон үндэслэлийг судалж үзэхэд бүсийн орнууд аюулгүй байдал, тогтвортой хөгжилд хүрэхийн тулд хамтын хүчин чармайлтаа нэгтгэх зорилго агуулдаг хэдий ч тэд ихэвчлэн хүчирхэг гүрнүүдийн аль нэгнийх нь шүхэрт орж, аль нэг талын ашиг сонирхолын хүрээнд л өмнөө тавьсан зорилго, зорилтоо хэрэгжүүлж ирсэн байдаг. Тухайлбал, АНУ ба түүний холбоотнууд энэ бүс нутагт эзэлж ирсэн нэр нөлөө, байр сууриа хадгалахын тулд өөрсдийн өргөн цар хүрээтэй стратегийн нэг хэсэг болгон ашиглахын тулд тухайн бүс нутгийн байгууллагад нэгдэж тэдний олон талт асуудалд шийдвэрлэх үүрэг рольтой оролцдог. Хятад улс мөн л өөрийн олон талт үзэл баримтлал, ашиг сонирхолыг хэрэгжүүлэх хэрэгсэл болгон бүс нутгийн байгууллагуудад нэгдэж манлайлах үүрэг гүйцэтгэх хүчин чармайлтынхаа нэг хэсэг болгон ашиглаж байна. Энэ бүхнээс харахад Азийн бүсийн байгууллагууд нь хүчирхэг гүрнүүдийн зүгээс баримталж буй олон улсын дэг журмын нэг хэлбэр, үйл ажиллагааны талаархи өрсөлдөөний дэд хэлбэр гэж үзэж болох юм. Дашрамд дурдахад нийгмийн чиг баримжаатай Азийн бүсийн байгууллагуудын үйл ажиллагаа нь үзэл баримтлал, итгэл үнэмшил, олон талын түншлэлд түшиглэн тэгш бус байдал, ил тод байдал, хүрээлэн буй орчин гэх мэт бүс нутаг, дэлхийн нийтийг хамарсан тулгамдсан асуудлуудад дуу хоолойгоо хүргэдэг нөлөө бүхий чухал шинэ суваг болж байгаа хэдий ч шийдвэр гаргах түвшинд хүртэлх нөлөө хамаарал сулавтар хэвээр байна.

АСЕАН нь өнгөрсөн 53 жилийн хугацаанд бүс нутагтаа Европын Холбоотой төстэй, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөрөнгө, ажиллах хүчний чөлөөтэй хөрвөх тийм орчинг бий болгох гол зорилго тавьж, тавьсан зорилгоо амжилттай хэрэгжүүлж, бүс нутгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж ирсэн нэр хүндтэй хүчирхэг байгууллага болсон юм. Энэ байгууллага 2019 онд урд өмнө тавьж ирсэн зорилго, зорилтоо нэгтгэн дүгнэж, үйл ажиллагааны цаашдын чиглэл болох “ASEAN Vision 2040”-ийг АСЕАН, Зүүн Азийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн (ERIA) 60 гаруй эрдэмтэн судлаачдын оролцоотойгоор боловсруулж, шат дараалан хэлэлцэж дараагийн хоёр арван жилийн алсын хараагаа тодорхойлоод байна.

Тэрхүү төсөлд 2040 он гэхэд АСЕАН бүс нутаг, дэлхийн хэмжээнд илүү хүчирхэг байр суурь эзлэхийн тулд улс төрийн эв нэгдэл, эдийн засгийн интеграци, нийгмийн хариуцлага бүхий эдийн засгийн хүчирхэг хамтын нийгэмлэг болох зорилт тавьж, хэрэгжүүлэх арга замаа үе шаттайгаар нарийвчлан тодорхойлжээ.

Түүнчлэн бүс нутаг болон дэлхийн гео-эдийн засаг, гео-улс төрд гарч буй томоохон хувьсал өөрчлөлт, дижитал технологийн эрин дэх аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал, түүний эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөө, тулгарч болзошгүй эрсдэл зэрэг олон талт асуудлыг цогц байдлаар судалж, бүс нутаг хэрхэн дасан зохицож, хамтын аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн зорилтоо хэрэгжүүлэхэд чиглэсэн нийгэм эдийн засгийн олон талт асуудлуудыг энэхүү төсөлд нарийвчлан тусгасан байна.

Дээрх зорилго зорилтоо амжилттай хэрэгжүүлснээр АСЕАН 2040 он гэхэд Европын холбоог давсан үлэмж том эдийн засаг бүхий нэгдсэн удирдлага, зохицуулалт бүхий НҮБ-ын хүрээнд тогтсон дэг журмыг хангасан бүс нутгийн ЕХ маягийн хүчирхэг төв болох аж.

Бүс нутгийн хэмжээнд АСЕАН-нд түшиглэсэн нэр нөлөө бүхий хүчирхэг олон талт хамтын ажиллагааны форум бол ASEAN+6 механизмд суурилсан Зүүн Азийн Саммит (EAS) юм. Энэ форум Зүүн Хойт Ази, Зүүн Ази, Зүүн Өмнөд Ази, Өмнөд Азийн бүс нутгийн 16 орны удирдагчдын жил бүр зохион байгуулдаг бүс нутгийн форум бөгөөд 2011 онд ОХУ, АНУ нэгдэн орж 18 улс болж өргөжснөөр бүс нутгийн хийгээд дэлхийн бодлогод нөлөө бүхий хүчирхэг чуулганы нэг болсон юм.

Аюулгүй байдлын салбарт Азийн интеграцлал, олон талт хамтын ажиллагаа маш хязгаарлагдмал хэвээр байна, Гэхдээ түүнд 27 гишүүн орнуудыг эгнээндээ нэгтгэсэн АСЕАН-ы бүс нутгийн форум (ARF) маш чухал үүрэг гүйцэтгэх хандлагатай байна

Монгол Улсын хувьд АСЕАН-ны бүс нутгийн форум (ARF)-ын гишүүн орны хувьд үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох замаар Зүүн Азийн олон талт хамтын ажиллагааны гол түншийн нэг болох зорилт тавьж, боломжит бүх сувгийг ашиглан АПЕК-т чухал байр суурь эзэлдэг АСЕАН түүний төрөлжсөн байгууллагууд, гишүүн орнууд, түншүүдтэй нь нягт хамтран ажиллах нь АРЕС гэж явснаас ч илүү үр өгөөжтэй байж болох магадлалтай.

Дашрамд дурдахад АСЕАН, АСЕМ хоёр нягт хамтран ажилладаг. АСЕМ-ыг бүрдүүлэгч Европ тивийн орнууд хөгжлийн хувьд харьцангуй хоцрогдож буй Азийн орнуудад хөгжлийн туслалцаа үзүүлдэг бөгөөд Европын Холбоо тусламжийн хөтөлбөртөө Ази тивийн 19 орон, түүний дотор Монгол Улсыг хамруулж олон улсын байгууллагуудын зүгээс хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд идэвхтэй түншлэн оролцож ирлээ. Бид ч түүнийг угтуулан томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхдээ олон талт түншийн хүрээнд татан оролцуулж үр өгөөжтэй хамтран ажиллах боломж бий.

АСЕМ нь улстөр, эдийн засаг, соёлын гэсэн гурван чиглэлийг нэгтгэн хамруулдаг үйл явц учраас Ази, Европын орнуудтай энэ гурван салбарын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож хамтран ажиллах замаар Ази-Европын интеграцид бололцооны хэрээр оролцож, хамтын ажиллагааны үр өгөөжийг хүртэх, хоёр тивийн ард түмнүүдийн хооронд гүүр болж дэд бүтцээрээ холбогдох, тэдний хөгжлийн туршлагаас суралцах боломж нээгдсэн билээ.

Манай улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг болсон Зүүн Азийн дэд бүс болох ЗХА-д ч олон талт хамтын ажиллагааны механизм бүрэлдэн бий болох үйл явц өрнөн хөгжих чиг хандлатай болж ирлээ. Энэ үйл явцыг ургашлуулахад НҮБ-ын Ази Номхон Далайн Эдийн Засаг, Нийгмийн Комисс (ESCAP)-ын Зүүн ба Зүүн хойд Азийн газар (SOENEA) ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал, энэ хүрээнд Зүүн хойт Азийн зургаан улс болох Хятад, ОХУ, Япон, Монгол, хоёр Солонгосыг хамарсан бүс нутгийн олон талт хамтын ажиллагааны платформыг байгуулсан. Гол зорилго нь бүс нутгийг тээвэр, эрчим хүчний дэд бүтцээр холбож, худалдааг хөнгөвчлөх, хүрээлэн буй орчны тогтвортой байдлын талаархи дэд бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, нэгдсэн зохион байгуулалтаар хангаж уялдуулан зохицуулахад үйл ажиллагаа нь чиглэж байна. Энэ байгууллага тус бүс нутагт хэрэгжих төсөл хөтөлбөрүүдэд түншлэн оролцогч талуудыг нэгтгэн зангидаж хөдөлгөгч хүчин нь болж, олон улсын банк санхүүгийн байгууллага, бизнесийн бүлэглэл, хувийн томоохон сангууд, бүсийн орнуудын орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгмийн хийгээд бусад төрөжсөн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж байгаа нь бүс нутгийн олон талт

хамтын ажиллагааны шинэ хэлбэр болж, НҮБ-ын ТХЗ 30 зорилтыг хэрэгжүүлэхэд чухал хөшүүргийн үүрэг гүйцэтгэж байна.

Зүүн хойд Азийн орнуудад албан ёсны олон талт механизм байдаггүй нь бүсийн чадавхийг нэмэгдүүлэхэд сөрөг нөлөө үзүүлдэг гол хүчин зүйлийн нэг болж ирснийг бүсийн орнууд хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ Зүүн хойд Азид өөр өөр гишүүнчлэлийг хамарсан, өөр өөр түвшний (үндэсний, үндэстэн дамнасан, бизнесийн, мэргэжлийн холбоодын, орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгэм гэх мэт) оролцоотой одоо байгаа механизмыг "функциональ хамтын ажиллагаа ба интеграци" гэж тодорхойлж болох юм. Ийм функциональ хамтын ажиллагаа, интеграцчлалын механизмд манай улсын идэвхтэй оролцоотой явж ирсэн Зүүн ба Зүүн хойд Азийн бүсийн газар (SOENEA), Гурвалсан хамтын ажиллагааны нарийн бичгийн дарга нарын газар (TCS), Их Түмэн санаачилга (GTI) багтдаг.

Дээрх байгууллагуудын уялдаа холбоог нэгтгэснээр Зүүн хойд Азид хамтын ажиллагааны албан ёсны олон талт механизм бий болох чиглэлд алхам алхамаар ойртож буйн нэгэн илэрэл юм. Хятад улс дээрх гурвалсан хамтын ажиллагаа болон “Бүс ба Зам” санаачлагын хүрээнд төсөл хөтөлбөрүүд санаачлан хэрэгжүүлж, Зүүн хойд Азийн чөлөөт худалдааны бүс байгуулах талаар олон талыг хамарсан иж бүрэн өргөн цар хүрээтэй судалгаа хийж, бүс нутагт тэргүүлэх байр суурь эзэлж байна.

Ийнхүү Зүүн хойд Азид НҮБ-ын уламжлалт олон талт үзэл, дүрэм журамд суурилсан хамтын ажиллагааны шинэ хэлбэр бий болж, иргэний нийгэмтэй уялдаа холбоотой ажиллаж, олон талт түншлэгчдийг түүнд татан оролцуулж байгаа нь төлөвлөсөн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж байна. Энэ бүхэн манай улсын хувьд уламжлалт хамтын ажиллагаагаа өргөтгөх, бүс нутгийн эрчим хүчний сүлжээнд нэгдэх шинэ санал санаачлагыг ажил хэрэг болгоход шийдвэрлэх ач холбогдолтой юм. Энэ байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, өөрийн байр сууриа эзэлж, нягт хамтран ажиллах нь хөгжлийн нэгэн хөшүүрэг болно гэж үзэж байна.

АПЕК Эдийн засгийн хамтын ажиллагааны энэ байгууллага гурван аравныг ардаа үдэж буй энэ цаг үед дэлхий, бүс нутагт гарч буй ээдрээ түвэгтэй, асар хурдацтай хувьсал өөрчлөлтийн улмаас нөлөө бүхий хүчнүүдийнх нь хоорондын өрсөлдөөн, ашиг сонирхол, үзэл баримтлалын зөрөөний улмаас өнөөдөр урд өмнө үзэгдээгүй хүнд сорилттой тулгарч байна.

Эдийн засгийн жигд бус өсөлт, дэлхийн худалдааны уналт, протекционист чиг хандлага улам бүр нэмэгдэхийн хэрээр гишүүн эдийн засгуудынх нь нийгэм дэх тэгш бус байдал улам бүр нэмэгдэж, хамтын ажиллагаанд нь сөргөөр нөлөөлөх хандлага ч гарч байна.

Энэ мэт олон хүчин зүйлийн улмаас гишүүн орнуудыг хамарсан чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах санал санаачлага нэгдсэн тохиролцоонд хүрч чадалгүй хэд хэдэн бүлэглэл болон задарлаа. Энэ бүхнээс үүдэн АНУ саяханаас Ази-Номхон далайн бүс нутаг гэдэг газар зүйн ойлголтыг баруун зүг тэлж “Энэтхэг-Номхон далайн стратеги” гэсэн өргөн уудам орон зайд бүх талыг хамарсан чөлөөтэй, нээлттэй бүс нутгийн хамтын нийгэмлэг байгуулах тухай Үндэсний аюулгүй байдлын стратеги хэмээх баримт бичигтээ тусгалаа. Түүнийг Америкийн энэ бүс нутгийн түншүүд нь дэмжиж “Чөлөөт, нээлттэй Энэтхэг, Номхон далай” гэсэн бүс нутгийн орнуудыг хамарсан олон талт хамтын ажиллагааны бүлэглэл үүсгэн байгуулах тухай яриа хэлэлцээ өрнүүлж эхэллээ. Манай улсын гурав дахь түншүүд болох АНУ, Япон зэрэг улсууд ч энэ шинэ бүтцэдээ биднийг татан оролцуулах сонирхолоо илэрхийлсээр байна.

Бид 27 жилийн турш элсэхийг хүсэж элдэв арга хэрэглэж, олон төрлийн арга хэмжээнд нь оролцож заримыг нь эх орондоо зохион байгуулж, хөрөнгө хүч зарж, идэвхий хүчин зүтгэл гарган ажиллаж ирсэн боловч амжилт олсонгүй. Гол нь тэдний шалгуур үзүүлэлтүүдийн хаана нь ч бид хүрэхгүй байгаатай холбоотой. Тийм учраас бид давын өмнө ASEAN+3+ARF гэсэн хамтын ажиллагаанд аль болох боломжийн хэмжээнд түншлэн оролцоог хичээж, дотоододоо бэлтгэлээ хангаж, эдийн засгаа томруулж өгөх, авах юмтай болсны дараа л ярих асуудал болов уу.

Ази, Номхон далайн орнуудын эдийн засгийн интеграцид бодитой оролцоход Монгол Улсын хувьд бизнесийн, судалгааны, төрийн бус байгууллага болон төр засгийн байгууллагууд нь зэрэг хамтран оролцож болох ганц цонх бол Номхон Далайн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Зөвлөл (PECC) хэвээрээ байна. PECC нь 1980 онд байгуулагдсан. Өнөөгийн байдлаар 26 гишүүн хороотой бөгөөд үүнд нэг хараат гишүүн, хоёр байгууллагын гишүүн багтдаг. PECC Ази, Номхон далайн бүс нутгийн өмнө тулгарч буй хамгийн чухал тулгамдсан асуудлуудын талаар албан бус орчинд төр, нөлөө бүхий бизнесменүүд, тэргүүлэх судлаачдын оролцоотойгоор бодлого боловсруулж, бүс нутгийн эдийн засгийн тогтвортой хөгжилд чухал хувь нэмэр оруулж ирсэн байгууллага юм. PECC-ийн санаачлагаар 1989 онд APES байгуулагдсан. Зөвлөл нь АПЕК-ийн үйл явцын албан ёсны гурван ажиглагчдын нэг.

Манай улс 1998 онд дэд гишүүнээр элсэн орж, 2008 онд (Бангкок) жинхэнэ гишүүн болсон. Энэ чиглэлд Монголын Үндэсний Хороо (MONPECC)-нд ач холбогдол өгч үйл ажиллагааг нь идэвхжүүлж ажиллавал дээрх байгууллагаас хүртэх өгөөж нэн арвин.

Төр засгийн хийгээд судалгааны байгууллагууд болон бизнесийн төлөөлөл оролцсон төр-олон нийтийн ийм байгууллага гишүүн орон бүрт бий. Тэд PECC-ийн хүрээнд хамтран

ажиллаж маш идэвхтэй үйл ажиллагаа явуулж, бүс нутгийн хөгжилд бодит үр нөлөө үзүүлж байна.

РЕСС-ийн зохион байгуулж байгаа төсөл хөтөлбөрт Шинжлэх ухааны хүрээлэнгүүд, их дээд сургуулиуд, Засгийн газрын холбогдох агентлагууд болон тодорхой салбарын бизнесийн төлөөллийг идэвхтэй оролцуулж, РЕСС болон түүний гишүүн орнуудтай бүх сувгийг ашиглан оролцож олон талт хамтын ажиллагааны үр шимийг хүртэх өргөн боломж бий.

РЕСС нь бодлогын чиг баримжаатай, нэр хүндтэй байгууллага бөгөөд бүс нутгийн орнуудын хооронд түншлэл, шударга байдал, хүндлэл, итгэлцэлд түшиглэсэн харилцан хамааралтай ажил хэрэгч хамтын ажиллагааны уур амьсгалыг бий болгож, худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлт, нийгмийн дэвшил, шинжлэх ухаан, технологийн хөгжил, хүрээлэн буй орчин зэрэг олон талт хамтын ажиллагааг өрнүүлэн хөгжүүлэх гарцыг тодорхойлж, бодлогын уялдаа холбоог нэгтгэн зангидахад үйл ажиллагаа нь голлон төвлөрч байна. Дээрх зорилго, зорилтын хүрээнд АПЕК-ийн туулж ирсэн өнгөрсөн 30 жилийн үйл ажиллагааг нэгтгэн дүгнэж, ирэх хоёр аравны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр *People and Prosperity: An APEC Vision to 2040* боловсруулж, гишүүн эдийн засгуудын ажлын хэсгийн болон сайд нарын уулзалтуудаар шат дараалан хэлэлцүүлэх ажил ид өрнөж байна. Түүнийг энэ оны 11 дүгээр сард Малайзад болох чуулганаараа хэлэлцэн батлах төлөвтэй байна.

“Хүн ард, хөгжил цэцэглэлт: АПЕК 2040 алсын хараа”-нд АПЕК-ийн өвөрмөц, хамтын ёс зүйд суурилсан энэ форумд учирч буй өнөөгийн нэн шинэ тулгамдсан асуудлууд түүнийг даван туулах арга замыг тодорхойлж, ирэх хоёр арван жилд бүс нутгийн хүн ардын амьдралыг тэгш хүрээмжтэй дээшлүүлж, аюулгүй байдлаа баталгаажуулсан, хөгжил дэвшилд хүрсэн, харилцан уялдаатай, өргөн хүрээнд шинэчлэгдсэн АПЕК болсон байх зорилт дэвшүүлжээ. Энэ зорилгодоо хүрэхийн тулд чөлөөт, нээлттэй худалдаа, хөрөнгө оруулалт, бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграцийг үргэлжлүүлэн хөгжүүлэхийн зэрэгцээ шинэлэг, хүртээмжтэй, тогтвортой, тэнцвэртэй, аюулгүй, уян хатан чанартай, хүн ардын амьдрал, эдийн засгийн өсөлтийг хангахад үйл ажиллагаа нь чиглэх аж. Түүнчлэн бүсийн хүн амын боловсрол, амьдралын нөхцлийг сайжруулахад чиглэсэн бодлого явуулж, бүтцийн шинэчлэл хийж, шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлж, харилцан уялдаа холбоог сайжруулах замаар сайн засаглалыг хэрэгжүүлснээр технологийн хурдацтай хөгжлийн эрин үед дижитал өөрчлөлтийн үр өгөөжийг хүн ард, бизнесийн аль алинд нь нээлттэй байлгаж зах зээлд нэвтрүүлэх таатай орчинг бий болгох юм байна.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлснээр АРЕС дэлхийн хамгийн их нэр нөлөө бүхий шинэчлэгдсэн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүчирхэг форум болох аж.

Бидний хувьд давын өмнө энэ бүс нутгийн худалдааны хэлэлцээрт оролцох эхний гарц нь Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр /АРТА/ юм. Монгол Улс 2013 онд гишүүнээр элсэж, 2019 оны 12 дугаар сарын 12-нд УИХ-аар соёрхон баталсан. АРТА нь Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжиж буй орнууд зах зээлийн хүрээгээ тэлэх, үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх, дотооддоо үйлдвэрлэх боломжгүй, эсхүл үйлдвэрлэхэд өндөр өртөгтэй бараа бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй нөхцөлөөр авах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, Өмнөд өмнөдийн худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих, SDG-30 хэрэгжилтэнд туслах зорилго агуулдаг. Монгол улс АПТА-д элссэнээр цаашид бүс нутгийн худалдааны гэрээ хэлэлцээрт оролцоход туршлага сургамж ч болох ач холбогдолтой юм. Энэ хэлэлцээрт хэлэлцээрт Бангладеш, БНХАУ, Энэтхэг, Лаос, БНСУ, Шри Ланка, Монгол гэсэн 6 улс нэгдэн орсон. АРТА гишүүн орнууд өөр хоорондын экспорт, импортын бараанд тусгай хөнгөлөлтийг олгож, барааны болон үйлчилгээний худалдаан дахь саад тотгорыг арилгах, хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх чиглэлд хамтын ажиллагааны механизмыг бий болгож байгаа нь чухал ач холбогдолтой юм.

Манай Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 64,7 хувь, экспортын 90 хувь, импортын 30 хувийг АРТА-ийн гишүүн орнууд тус тус эзэлдэг. Уг хэлэлцээрт нэгдэн орсноор гадаад худалдааны зах зээлийг тэлэх таатай орчин бий болж байгаа хэдий ч хараахан хүчин төгөлдөр үйлчилж эхлээгүй, хөнгөлөлт, чөлөөлөлтийн нарийн ширийн асуудлаа нэг мөр болгох тал дээр ажиллаж байна. Хэрэв нэгдсэн тохиролцоонд хүрч гэрээ хэрэгжиж эхэлсэн тохиолдолд манай экспортын бараа, бүтээгдэхүүн БНХАУ, БНСУ-ын зах зээлд дунджаар 40%-ийн хөнгөлөлт эдлэх боломж бүрдэх юм. Түүнчлэн, Монгол Улс БНХАУ, БНСУ- тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судалж байгаа энэ үед эхний ээлжинд хөнгөлөлттэй тарифыг хэрэглэж, үр дүнд суурилсан шийдвэр гаргахад таатай боломж бүрдэж байна.

Бүс нутгуудын олон талт байгууллагуудаас манай улс ач холбогдол өгч харилцан хамааралтай ажиллаж ирсэн байгууллагууд болон шинэ олон талт байгууллагуудын үйл ажиллагааны өнөөгийн байдлыг тоймлон танилцуулахад ийм байна.

Өнөөдөр олон талт байгууллагын үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллагуудыг (бизнес, иргэний нийгэм, хувийн сан, банк санхүүгийн институц, түншлэн оролцогчид гэх мэт) татан оролцуулах шинэ хандлага бий болж, хөгжлийн түншүүд нь

катализаторын үүрэг гүйцэтгэж батлагдсан төсвөөс гадна нэмэлт санхүүжилтийн эх үүсвэртэй болж төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжих нөхцөл боломжийг бүрдүүлж байна. Ингэснээр бүс нутгийн байгууллагууд бүтэц зохион байгуулалтын хувьд бэхжиж, нэр хүнд, хүлээх үүрэг хариуцлага нь өсөн нэмэгдэж, бүс нутгийн тогтвортой хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж байна.

Монгол Улс олон тулгуурт бие даасан прагматик гадаад бодлогоо хадгалж, хоёр хөршийн болон бүс нутгийн нэр нөлөө бүхий хүчирхэг олон талт байгууллагуудын үйл ажиллагаанд идэхтэй оролцохын тулд гурав дахь хөрш, хөгжлийн олон талт түншүүдийн дэмжлэг авч тэдний итгэлийг хүлээж, харилцан хамааралтай, нягт хамтран ажиллах нь өнөөгийн тулгамдсан асуудлуудыг эрсдэл багатай даван туулах нэгэн гарц байх болов уу гэж үзэж байна.

Монгол Улс Азийн бүс нутгийн байгууллагуудын хүрээнд баримтлах бодлого, үндсэн чиглэлийг шинээр тодорхойлоход анхаарахад илүүдэхгүй болов уу гэх үүднээс дараах зөвлөмжийг бид санал болгож байна.

1. Манай улсын Бүс нутгийн олон талт байгууллагуудын үйл ажилгаанд оролцож ирсэн байдалд дүн шинжилгээ хийж, үр нөлөө багатай, зардал чирэгдэл ихтэй, олон шат дамжлагатай “яриа хэлэлцээний дэлгүүрүүд”-ийн тоог цөөлөх;
2. Дээрх чиглэлээр урд өмнө гаргасан олон төсөл хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг эргэн харж шинэчлэх;
3. Гурван улсын Эдийн засгийн коридор байгуулах төсөл хөтөлбөр + гурав дахь хөрш + хөгжлийн түншүүд + олон талт байгууллагууд гэх мэт боломжит бүх сувгийг татан оролцуулах талаар санал санаачлага гаргах;
4. ШХАБ-д шат ахиж оролцох эсэхийг мэргэшсэн тэргүүлэх байгууллага, судлаачдаас бүрдсэн шинжээчдийн баг ажиллуулж олон талыг хамарсан судалгаа хийж асуудлыг (массад түшиглэхгүйгээр) нэг мөр шийдвэрлэх;
5. НҮБ болон олон улс, бүс нутгийн засгийн газар хоорондын байгууллагын хүрээнд баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлж, харилцаа, хамтын ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх;
6. Өнөөгийн даяаршсан, харилцан хамааралтай дэлхийд элдэв өвчин, гамшиг, санхүүгийн, эдийн засгийн хямрал, эрсдэлд өртөмтгий байдал нэмэгдэж байгаа энэ цаг үед НҮБ-ын Ази Номхон Далайн Эдийн Засаг, Нийгмийн Комисс (ESCAP)-ын Зүүн ба Зүүн хойд Азийн газар (SOENEA), Гурвалсан хамтын ажиллагааны нарийн

бичгийн дарга нарын газар (TCS), Их Түмэн санаачилга (GTI)-тай нягт хамтран ажиллаж, үүрэг оролцоогоо бүх түвшинд нэмэгдүүлэх;

7. PECC-ийн гишүүн орны хувьд энэ байгууллагын олон талт үйл ажиллагаанд идэвх санаачлагтай оролцох;
8. Монголын Үндэсний Хороо (MONPECC)-нд ач холбогдол өгч үйл ажиллагааг нь идэвхжүүлж олон талт оролцоог хангаж ажиллах;
9. Зүүн хойд Азийн шинэ хүртээмжтэй олон талт байдлын чиг хандлага, эдийн засаг, нийгэм, байгаль орчин, улс төрийн хүрээнд хамтын ажиллагаа, интеграцийн механизм, бүтэц зохион байгуулалтын төлөв байдлыг улируулан судлах;
10. Зүүн хойд Азийн Эрчим хүчний нэгдсэн сүлжээ байгуулах ажлыг уялдуулан зохицуулах олон талт институцыг Монгол улсад байгуулахад бүсийн орнуудын Төрийн тэргүүн нарын улс төрийн зөвшилцөлд хүрэх. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд улс төр, дипломатын бүх сувгийг ашиглаж, үйл ажиллагааг нь хурдасгахад дэмжлэг үзүүлэх;
11. Интернет, социал медиа нь бидний уламжлалт харилцааны хэлбэрийг өөрчилсөөр байгаа өнөөгийн нөхцөлд гадаад орчны мэдээлэл цуглуулж, анализ хийдэг, замын зураг гаргадаг бодлогын судалгааны “Think Tank”-Төв байгуулах;
12. Өнөөдөр манайд гадаад орчны чиглэлээр судалгаа явуулж буй төрийн, их дээд сургуулийн дэргэд болон төрийн бус байгууллагын статустай 20 гаруй судалгааны төв, хүрээлэн үйл ажиллагаа явуулж байна. Дээрх байгууллагуудын судалгааны үр дүнг хэлэлцдэг, санал солилцдог дугуй ширээний уулзалт, онол практикийн бага хурал зэрэг арга хэмжээг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулж тэдний судалгааны үр дүн, зөвлөмжийг ойшоон үзэж, бодлогын шийдвэр гаргах явцад тусган хэрэгжүүлэх

ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн “Азийн бүс нутгийн байгууллагуудын үйл ажиллагаа дахь монголын үүрэг оролцоог нэмэгдүүлэх боломж” судалгааны төслийн баг

2019 оны 12 дугаар сар

“БҮС НУТГИЙН ИНТЕГРАЦ, ХАМТЫН АЖИЛЛАГАА:
МОНГОЛ УЛСЫН ОРОЛЦОХ ШААРДЛАГА, БОЛОМЖ”

Л.Хайсандай, ОУХХ-ийн зөвлөх, доктор (Sc.D)

Тив дэлхий, бүс нутгийн хэмжээний их, бага, хөгжингүй ба хөгжиж байгаа улс орнуудын хоорондын харилцаа хамаарал улам бүр гүнзгийрч байна. Үүнээс үүдэн бүс дундын хэлхээ холбоог бүх талаар хөгжүүлэх, орон бүрийн ашиг сонирхол, хүч бололцоог нэгтгэн, ялангуяа эдийн засгийн тогтвортой, эрчимтэй хөгжлийг хангах явдал нэн чухал юм. Өөрөөр хэлвэл хөгжлийн асуудлыг өнөөдөр зөвхөн нэг улсын хүрээнд биш, дэлхийн түвшинд, бүс нутгийн хүрээнд гагцхүү хамтын ажиллагаагаар л шийдэх боломжтой болж байна. Ийм нөхцөлд манай улс хөгжлийн үзэл номлолоо шинээр авч үзэж, шинэ цаг үеийн чиг хандлага, зорилт стратегид нийцүүлсэн, үндэснийхээ язгуур эрх ашигт тулгуурласан бодлого боловсруулж хэрэгжүүлэх зүй ёсны шаардлага гарч байна.

Иймд өөрийн оршин, харъяалагдаж байгаа бүс нутгийнхаа интеграц, хамтын ажиллагаанд манай улсын оролцох боломж, төлвийн талаар оновчтой үр дүнтэй зохих судалгаа хийх хэрэгтэй нь мэдээж. Энэ талаар би зарим нэгэн санаа бодлоо илэрхийлье.

1. Монгол Улсын Их Хурал “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” баримт бичгийг 2016 оны 2 дугаар сард баталж, үндэсний түвшний зорилтуудаа тодорхойлсон. 2030 он гэхэд Монгол Улс ардчилсан засаглалаа бэхжүүлж, экологийн тэнцвэрт байдлыг ханган, ядуурлын бүх хэлбэрийг устгаж, дээд эрэмбийн дундаж орлоготой улс орны эгнээнд шилжих зорилт дэвшүүлсэн билээ. Мөн засгийн газраас тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дунд болон богино хугацаанд үе шаттай хэрэгжүүлэх бодлогын хөтөлбөр боловсруулсан. Энэ дагуу хөгжлийн санхүүжилтийг бүрэлдүүлэхэд улсын төсвөөс гадна хөрөнгө оруулагчдын оролцоог хангах, идэвхижүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийг дэмжихэд онцгой анхаарах ёстой. Үүний хамт зүүн хойд Азид оршдог, далайд гарцгүй манай улсын хувьд олон улс, бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхитэй оролцох нь дээр дурдсан тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх нэг гол чухал арга хэрэгсэл юм.

Тиймээс манай улс АСЕАН-ны бүсийн чуулга уулзалт, Ази-Европын уулзалт, Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх бага хурал, Азийн хамтын ажиллагааны Яриа хэлэлцээ зэрэг хурал, чуулганы үйл ажиллагаанд оролцоогоо улам идэвхижүүлж, тодорхой үр дүнтэй болмоор байгаа юм.

Мөн АСЕАН-ы яриа хэлэлцээний түнш болох эрмэлзлээ бодитой болгох тодорхой алхам хийх, Ази Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэх асуудлаа эрчимжүүлэх асуудлаа шаардлагатай байна. Зүүн хойд Азийн яриа хэлэлцээний механизмын хөгжилд хувь нэмрээ оруулахын тулд манай Улс 2013 онд “Улаанбаатрын Яриа хэлэлцээ”-г санаачилж,

жил бүр хуралдааныг зохион байгуулж байгаа. Өдгөө бүс нутгийн аюулгүй байдал, эрчим хүч, дэд бүтцийн сүлжээ, ногоон хөгжил, хамтын ажиллагааны боломж зэргийг хэлэлцдэг, дэд бүсийн бүх улсын оролцоог хангасан нээлттэй механизм болон төлөвшиж байгаа.

Гэвч түүний шинжлэх ухааны үндэслэлийг бататгаж, үр дүнг дээшлүүлэх шаардлагатай. Түүнчлэн Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа (АПЕК) нь бүс нутгийн эдийн засгуудыг интеграцид нэгтгэх үндсэн бүтэц болж байгаа бөгөөд бүс нутагт чөлөөт худалдааны бүс байгуулах үндсэн зорилно тавьж байгаагаа 2015 оны дээд уулзалтаасаа албан ёсоор зарлалаа. Монгол Улс АПЕК-т элсэх нь манай эдийн засаг, нийгмийн амьдралд үнэхээр нааштай нөлөө үзүүлэхээр байгаа юм. Гэвч манай улс 2020-ооноос нааш элсэх боломж байхгүй байгаа. Гэхдээ АПЕК-т элсэх нь олон талын ач холбогдолтойг харгалзан энэ чиглэлээр үргэлжлүүлэн ажиллавал зохино гэдэг нь судалгаа шинжилгээгээр батлагдаж байна.

Үүний тулд АПЕК-т элсэх бэлтгэлээ хангах өөрийн үйл ажиллагааны хөтөлбөрөө шинэчлэн боловсруулж батлуулах, мөн элсэхтэй холбогдсон чиглэлээр тууштай ажиллах АПЕК-ийн ажлын хэсгүүдэд ажиглагчийн хувьд үргэлжлүүлэн оролцож, мэдээлэл авч байх, тэндээс суралцах; ПЕКК-ийн үйл ажиллагаанд гишүүний хувьд идэвхи санаачлагатай оролцож байх хэрэгтэй байна.

2. Аливаа улс орны хөгжлийн болон ард иргэдийн амьдралын түвшинг эдийн засгийн суурь бүтцийн салбарын хөгжлөөр тодорхойлдог түүхэн жамтай. Хөгжингүй орны тоонд асар богино хугацаанд орсон орнуудын туршлагаас харахад тэдний гол зорилго дэд бүтцийг эдийн засгийн суурь болгон хөгжүүлэхэд доривтой, шийдвэртэй арга хэмжээ авч чадсанаар амжилт олж, түүнийг нь дагаж эдийн засаг, ард түмний аж амьдрал сайжирч хөгжсөн байдаг. Тиймд манай улсын дотооддоо болон дамжин өнгөрүүлэх тээврийн дэд бүтцийн хөгжлийн асуудал өнөөгийн манай хамгийн тулгамдсан асуудлын нэг болж байна. Чухамдаа манай улс хоёр том хөршийнхөө тэг дунд нь оршиж, Зүүн Азийг Европтой, Зүүн хойд Азийг төв Азитай холбогч “гүүр” болж, тэдгээртэй хамаатаж харьяалагдаж байдаг өвөрмөц онцлог бүхий орон гэдгийг хэн хүнгүй мэднэ. Энэхүү геополитикийн байрлал нь тухайн бүс болон бусад улс орнуудын сонирхлын төвд байдаг билээ.

Нөгөөтэйгүүр өдгөө манай хоёр хөршийн хоорондох худалдаа 100 хол давсан ам.долларт хүрээд байна. 2020 он гэхэд хоёр дахин өсөх төлөвтэй байна. Түүнчлэн Зүүн Ази, Европын улсуудын хоорондын худалдааны ба бусад солилцоо асар их нэмэгдэж байна. Энэ бүхнээс үзвэл манайх транзит худалдаа хийх бодит боломж өсөх магадлалтай байна. Ийм нөхцөлд 2016 оны зургадугаар сард Ташкент хотноо болсон Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын уулзалтаар “Монгол-Орос-Хятад-ын” “эдийн засгийн коридор”

хөтөлбөрийг баталсан. Монголын “хөгжлийн зам”, Хятадын “Торгоны замын эдийн засгийн бүс”, ОХУ-ын “Евразийн эдийн засгийн холбоо-г” уялдуулсан уг хөтөлбөрт гурван улсын хамтын ажиллагааны олон чухал зорилт туссан. Тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх асуудал энд гол байр суурийг эзэлж, түүнийг дагуулсан чөлөөт бүс байгуулах, эко аялал жуулчлалын маршрут бий болгохоор төлөвлөсөн. Хөтөлбөрт гурван тал хамтран хэрэгжүүлэх дэд бүтцийн бүтээн байгуулалт буюу авто болон төмөр замын коридорууд, дамжин өнгөрөх тээвэр, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр 32 төсөл тусгагдсан байгаа. Тэдгээрийг 5 жилийн дотор барьж байгуулах учиртай. Тэгвэл эдгээр төсөл Монголын геополитикийн орчинд хэрхэн нөлөөлөх вэ, ер нь энэ гурван улсын эдийн засгийн коридор манай улсад ямар ашигтай вэ, хэрхэн яаж хэрэгжих вэ мэтийн олон асуудалд шинжлэх ухааны үндэслэлтэй хариулт өгөх шаардлагатай.

Гурван улсын эдийн засгийн коридорт манай улс холбоочийн үүрэг гүйцэтгэнэ гэж байгаа. Энэ дэд бүтэц бол манай улсын хувьзаяатай шууд холбоотой. Тиймээс бид бүх эрсдэлийг тооцож аль ч тохиолдолд төмөр зам, автозамтын сүлжээнүүдийг тэд нарт бүрэн даатгаж болохгүй. Бас Орос, Хятад хоёрын одоогийн нэгдмэл ашиг сонирхол урт удаан байж чадах боловуу? Хэзээ нэгэн цагт эрх ашиг нь зөрчигдөх болвол тэр үед манай улс яах вэ гэдэг асуудал гарах болно гах мэтийн олон юм байгаа. Гэхдээ хөрш гүрнүүдтэйгаа аж ахуйн хэлхээ холбоогоо энэхүү коридорын төслөөр дамжуулан эрчимжүүлэх үндсэн дээр хөгжил дэвшлээ түргэтгэх нөхцөл бүрдэж байна гэж итгэл дүүрэн харж болно. Үүний хамт бүс нутгийн хэмжээнд БНСУ-ын дэвшүүлсэн “Евразийн санаачилга” гэдэг төсөл биелэлээ олж эхлээд байна. Энэ төслийн хүрээнд хоёр Солонгос-Оросын гурван талт хамтын ажиллагаа хөгжих боломжтой гэж байгаа бөгөөд түүнд манайх нэгдэх нөхцөл байдал бий болохыг үгүйсгэхгүй. Бас “сайш хөрш, сайн түнш, сайн хандлага,” гэсэн эрхэм зорилго бүхий төв Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны (CAREK) хэрэгжиж байна. Түүнчлэн интеграц нэлээд их урагшлан хөгжчихсэн АСЕАН-ыг манай улс сүүлийн үед их сонирхох болсон. Газарзүйн байрлалаараа бол манай улс бол Зүүн Өмнөд Азийн орон биш ч гэсэн түүний хувьд АСЕАН+томьёоллын дараагийн орон болж нэгдэх боломжийг сүвэгчлэн хайж, нухацтай авч үзэхийг бодож боловсруулах хэрэгтэй байна. Тийнхүү бүс нутгийн интеграц, хамтын ажиллагаанд Монгол Улсын оролцох боломж төлөв их байна. Харин энэ бүхний талаар манайхан судалгаа сайтай, хоорондын уялдаа холбоог сайтар зангидаж баймаар байна. Мэдээж хэрэг жижиг улс учраас их гүрнүүдэд хандаж санаачлага гаргалаа гэхэд дэмжих бололцоо нь тун бага. Тиймд хамгийн гол маш сайн судалгаатай байж зохих ёсны байр суурийг хадгалж чаддаг байх ёстой. Үүний тулд энэ чиглэлээр ёудалгаа хийж байгаа эрдэстэн судлаачид, тэдгээрийн судлалын ажлыгбүх талаар нь уялдуулж дэмжих, тухайлан сэдэвт

ажлыг төрийн түвшинд анхааран үзэж, зохих санхүүжилтээр хангаж, бодит хэлбэрээр тэтгэх, үр дүнгий нь төрийн бодлогод тусган хэрэгжүүлж баймаар байна. Үүнд бас хөрөнгө хүчийг боловсруулж, аливаа нэгдмэл ойлголттой, нэгдмэл бодлоготойгоор бүс нутгийн хэмжээнд хамтран ажилламааар байнг зориуд зөвлөж, онцлон тэмдэглэж байна.

АСЕАН, АПЕК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ МОНГОЛЫН ҮҮРЭГ
Олон улсын байгууллагуудтай хөгжүүлж буй харилцаа нь олон талт хамтын ажиллагааны хүрээнд явагддаг. Олон талт хамтын ажиллагаа нь гурав болон түүнээс дээш тооны улс орон олон улсын харилцааны асуудлыг шийдвэрлэхээр гаргаж буй хамтын хүчин чармайлт юм. Олон талт хамтын ажиллагаагнэгдүгээрт, олон улсын гэрээ, конвенцийн дагуу байгуулсан олон улсын байгууллага, бүтэц, хоёрдугаарт, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх зорилгоор дэвшүүлсэн саналсанаачилга, үйл явц гэж хоёр ангилж үздэг. Олон талт хамтын ажиллагаанд оролцох нь хөгжиж буй орон болох Монгол Улсын хувьд гадаад бодлогын зорилтуудаа хэрэгжүүлэх чухал арга хэрэгсэл болох боломжтой юм.

Монгол Улсын гишүүнчлэл бүхий олон улсын байгууллагуудтай тогтоосон хоёр болон олон талын хамтын ажиллагааны үр ашгийг нарийвчлан судалж, үр өгөөжийг тогтоох нь нэн чухал асуудал юм. Монгол Улс гишүүнээр элссэн бөгөөд улсын төсвөөс татвар, хандив төлдөг олон улсын 75 байгууллага, албан ёсоор нэгдэн орсон олон улсын 25 гэрээ, конвенци байдаг бөгөөд үүнээс Азийн бүс нутгийн 5 байгууллагын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхийг энэ өгүүлэлд зорьж байна.

Олон улсын байгууллагад гишүүнчлэгдэх бодит шаардлага, ач холбогдол

Монгол Улс нь дэлхийн хамтын нийгэмлэгийн нэгэн бүрэлдэхүүн болохын хувьд дэлхий дахины болон Азийн бүс нутгийн тулгамдсан асуудлыг олон улсын байгууллагын хүрээнд хэлэлцэж, нийтийн зөвшилцөлд тулгуурлан шийдвэр гаргахад оролцох эрх, үүрэгтэй. Энэ үүднээс авч үзэхэд, Монгол Улс олон улсын байгууллагын гишүүнчлэлээрээ дамжуулж, бүс нутагт харилцан ойлголцлыг бэхжүүлэх, улс хооронд харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, маргаантай асуудлыг шийдвэрлэхэд оролцох оролцоогоо нэмэгдүүлэх, улс орныхоо хөгжилд нэмэрлэх үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна. Тодруулбал, Монгол Улс олон талт үйл явцад оролцоходоо үндэсний ашиг сонирхлоо хамгаалах, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх, тэдгээрийн хүч бололцоог улс орныхоо хөгжилд үр дүнтэй ашиглахыг чармайн ажиллах хэрэгтэй. Чухам үүнд л олон улсын байгууллагад гишүүнчлэгдсэний гол ач холбогдол оршиж байна.

Азийн бүс нутгийн олон улсын байгууллагад Монгол Улсын гишүүнчлэгдсэн байдал

Монгол Улсын төсвөөс татвар төлж байгаа 75 олон улсын байгууллага, нэгдэн орсон 25гэрээ ковенци, үүнд 18 олон талт хамтын ажиллагаа нь Азийн бүс нутгийн хүрээнд явагдаж байна.ЭдгээрээсАзийн бүс нутгийг хамран үйл ажиллагаа явуулж буй5 байгууллагыг сонгон авлаа. Үүнд:

1. Азийн Хөгжлийн Банк(АХБ),
2. Азийн Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалтын Банк(АДБХОБ),
3. Төв Азийн Бүс Нутгийн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хөтөлбөрийн Институт (КАПЕК-ийн институт),
4. Номхон Далайн Итгэмжлэлийн Хамтын Ажиллагааны Байгууллага(ПАК),
5. Ази-Номхон Далайн Бүсийн Статистикийн Институт

орж байна.

Азийн Хөгжлийн Банк

Монгол Улс АХБ-д1991 онд элсэн орсноосхойш нийт 774.7 сая ам доллартай тэнцэх 44 зээл авсан. Мөн Азийн Хөгжлийн Сангаас санхүүжилт авах эрхтэй болсон 2007 оноос хойш 172.2 сая ам.доллартай тэнцэхбуцалтгүй тусламжийг хүртсэн байна. АХБ нь Монгол Улсын төрд хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхэд туслах, хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг дэмжих, орон нутаг, хот хоорондын хөгжлийн ялгааг багасгахад үйл ажиллагаагаа чиглүүлж байна. 2012 оноос АХБ-ны буцалтгүй тусламжийн хүрээндУлаанбаатар хотын гэр хорооллын нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулах, бага орлоготой өрхүүдэд зориулсан санхүүгийн үйлчилгээг оновчтой болгох ажлыг Монгол Улсын Сангийн яамтай хамтран хэрэгжүүлж байна.

Азийн Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалтын Банк

Монгол Улс АДХОБ-т 2014 оноос буюу байгуулагдсан үеэс нэгдэн орсон. Тус байгууллагад өдгөөБангладеш, Бруней, Камбож, Энэтхэг, Индонез, Казахстан, Кувейт, Лаос, Малайз, Мьянмар, Непал, Оман, Пакистан, Филиппин, Катар, Хятад, Сингапур, Шри Ланк, Тайланд, Узбекистан, Вьетнам гэсэн улсууд гишүүнээр элссэн байна.

Монгол Улсын хувьд АДХОБ-ны хөтөлбөрт гишүүнээр элсэх болзол нь нийт хувьцааны 0,05 хувь, анхны захиалсан хувьцааны 0,09 хувь буюу 45,45 сая ам.долларын хувьцааг эзэмших ёстойн 20 хувь буюу 9,09 сая ам.долларыг хувь нийлүүлэн төлж барагдуулах явдал байв. АДХОБ-ны баталгаажсан хувьцаа 100 тэрбум ам.доллар бөгөөд анхны захиалсан хувьцаа 50 тэрбум ам.доллар байхаар тооцож үүсгэн байгуулагч орнууд анхны захиалсан хувьцааны 20 хувь буюу 10 тэрбум ам.долларын хувь нийлүүлэхээр болжээ. Хувь нийлүүлэх хөрөнгийн хэмжээг гишүүн орнуудын ДНБ-д суурилж тооцсон ба Монгол Улсын хувьдэнэ ньбусад оронтой харьцуулахад хамаагүй бага буюу ДНБ-ний 2%-той дүйцэх хэмжээний хувь хөрөнгөнийлүүлэх ажээ. АХБ-ны шинжээчдийн судалснаар Ази-Номхон далайн орнууд дэд бүтцийн хөгжилд жилд ойролцоогоор 800 тэрбум ам.доллар зарцуулдаг байна.

Төв Азийн Бүс Нутгийн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны

Хөтөлбөрийн Институт

Төв Азийн Бүс Нутгийн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хөтөлбөр(КАПЕК) нь бүс нутагт ядуурлыг бууруулж, эдийн засгийн өсөлтийг хангах зорилгоор 2001 онд бий болсон ба үүнд Монгол Улс 2003 онд гишүүнээр элсэн орсон.

КАПЕК нь гишүүн орнуудад ирэх үр өгөөжийг сайжруулахын тулд институтээ байгуулах хэлэлцээрийг 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан. Монгол Улс уг хэлэлцээрт 2017 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр гарын үсэг зурж, улсаар 7 дугаар сарын 6-ны өдөр УИХ соёрхон баталснаар албан ёсны гишүүн болсон. Афганистан, Азербайжан, БНХАУ, Казакстан, Кыргызстан, Монгол, Пакистан, Тажикстан, Туркменистан, Узбекистан зэрэг улсууд гишүүнээр элсээд байна. КАПЕК-ийн институт нь олон улсын байгууллагын статустайгаар 2017 оны 9 дүгээр сарын 7-ны өдрөөс үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд тодорхой салбар чиглэлийн хүрээнд гишүүн орнуудын чадавхийг бэхжүүлэх сургалт, семинар зохион байгуулах, шаардлагатай судалгааг хийх арга хэлбэрийг үйл ажиллагаандаа түлхүү ашигладаг

Номхон Далайн Итгэмжлэлийн Хамтын Ажиллагааны Байгууллага

Монгол Улсын Засгийн газраас олон улсын байгууллагад гишүүнээр элсэхийг дэмжсэн 2003 оны 253 дугаар тогтоолын дагуу Стандарт, Хэмжил Зүйн Газар нь Номхон Далайн Итгэмжлэлийн Хамтын Ажиллагааны Байгууллага (РАС), Ази, Номхон Далайн Лаборатори Итгэмжлэлийн Хамтын Ажиллагааны Байгууллага (APLAC), Олон Улсын

Лаборатори Итгэмжлэлийн Хамтын Ажиллагааны Байгууллага (ИЛАС)-д тус тус элсэн орж, улмаар лаборатори, хяналтын байгууллагын үр дүнг олон улсын хэмжээнд харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрт 2012 оноос нэгдсэн байна.

Ази-Номхон Далайн Бүсийн Статистикийн Институт

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн 1990 оноос статистикийн албаны гадаад харилцаанд шинэ үе эхэлж, хоёр ба олон талт хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлэн, олон шинэ төсөл хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн байна. НҮБ-ын Ази, Номхон Далайн Статистикийн Институт /АНДОСИ/ болон Япон улсын ЖАЙКА байгууллагын дэмжлэгтэй статистикийн салбарын боловсон хүчнийг мэргэшүүлэн давтан сургах, төв ба орон нутгийн статистикийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд олон талт хамтын ажиллагааг түлхүү ашиглаж байна. Статистикийн мэдээллийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын жишиг стандартад нийцүүлэх, үндэсний тооцооны системийг нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж байна.

Монгол Улсаас олон улсын байгууллагын өмнө хүлээсэн үүрэг хариуцлага, хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх нь

Монгол Улс нь олон улсын байгууллагын өмнө гэрээгээ хэрэгжүүлэх гол шалгуур нь гишүүнчлэлийн татвараа цаг тухайд нь төлөх, тухайн байгууллагаас манайд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны бүхийл хэлбэрийг дэмжиж ажиллах явдал болно. Үүний дагуу Монгол Улсын Засгийн газраас олон улсын байгууллага, гэрээ, конвенцийн итгэмжит санд төлөх татвар, хандивын тухай хуулийг УИХ-ын 2007 оны 60 дугаар тогтоолоор батлан гаргасан.

Олон улсын байгууллагын татвар, хандивыг холбогдох газрын нэхэмжлэлийг үндэслэн улсын төсөвт батлагдсан төсвийн дагуу санхүүжүүлж байхаар заасан байдаг.

**Монгол Улсаас Азийн бүс нутгийн олон улсын Байгууллагад (сонгож авсан)
татвар төлсөн байдал**

Хүснэгт № 1

№	Байгууллагын нэр	Төлбөрийг хариуцсан газар	2017 /2018 гүйц.	2019 онд төлсөн. (мян.төгрөг)
1	Азийн Хөгжлийн Банк	СЯ	-----	-----
2	Азийн Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалтын Банк	СЯ	1.640.000,00 ам.доллар	4.428.000,0 төг
3	Төв Азийн бүс Нутгийн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хөтөлбөрийн Институтийн гишүүнчлэлийн төлбөр		-----	50.000,00 ам.долл
4	Номхон далайн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага	СХЗТ	63.574,0	63.574,0төг
5	Ази-Номхон далайн бүсийн статистикийн институт	ҮСГ	18.635,2	18.635,2төг

Нэгдүгээрт: Монгол Улс ба АХБ-ны хамтын ажиллагааны хувьдодоогийнбайдлаар Ядуурлыг Бууруулах Японы Сангаас (ЯБЯС) 6,2 сая ам.доллартай тэнцэх техникийн буцалтгүй туслалцааг баталж, АХБ-аар дамжуулан хэрэгжүүлсэн. Үүнээс гадна 31,49 сая ам.долларын ЯБЯС-ийн 16 буцалтгүй тусламжийн төслийг АХБ баталсан бөгөөд үүнээс үзэхэд Монгол Улс нь АХБ-ны хөгжиж буй гишүүн орнуудын дунд ЯБЯС-гийн буцалтгүй тусламжийг хамгийн их хүртсэн орон болж байна.Хүснэгтээс харахад АХБ-д төлөх 2019 оны төлбөр төлөвлөгдөөгүй байна.Гишүүний төлбөрөө төлөхгүй байх нь тус байгууллагаас хүртэх үр ашгийг саатуулах хор уршигтай гэдгийг харгалзан үзэх шаардлагатай юм.

Хоёрдугаарт: АДХОБ-ны хөтөлбөрийн хүрээнд 2017-2018 оны байдлаар 1.640.000,00 ам.доллар буюу 4.428.000,0 төгрөгний татварыг Монгол Улстөлсөн байна.Сангийн сайдын 2019 онытөсвийн багцаас АДХОБ-д төлөх гишүүнчлэлийн төлбөрийг 1.640.000,00 ам.доллараар тооцож, улсын төсвөөс жил бүрийн эхний улиралд төлдөг болж байна.

Монгол Улсын дэд бүтцийн хөгжлийг сайжруулах, төслүүдийг санхүүжүүлэх хэрэгцээ асар их байна. Тус хөтөлбөрт хамрагдсанаартөслүүдийгсанхүүжүүлэх эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг нээж өгсөн гэж үзэж болно. Одоогоор дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хийх төрөлжсөн санхүүгийн эх үүсвэр бүхий байгууллага байдаггүй тул томоохон хэмжээний төслийг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдаж байна. АДХОБ нь дэд бүтцийн хөгжлийг сайжруулах асуудлыг дагнасан олон улсын банк тул түүгээр дамжуулж бүс нутгийн дэд бүтцийн интеграцид ороход гишүүн орнуудтай хамтарч ажиллах, санхүүжилтийг хамтарч шийдвэрлэх боломж Монгол Улсад нээгдэж байна. АДХОБ-ны хөтөлбөрийн зорилго зорилтыг “Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал-2030”-тай уялдуулан хэрэгжүүлснээр тогтвортой хөгжлийн зорилтод хүрэхэд дөхөм болно.

Гуравдугаарт: КАПЕК-ийн Институт нь одоогийн байдлаар БНХАУ-ын Засгийн газар болон АХБ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд гишүүнчлэлийн төлбөр заавал төлөх шаардлагыг тавиагүй байгаа боловчцаашид өөрөө өөрийгөө санхүүжүүлэх механизмыг бий болгох болно. Институтийн захирлыг гишүүн орнууд 2 жилийн хугацаатай ээлжлэн томилох бөгөөд 2017 оны 8 сарын 1-нээс Монгол Улсаас томилогдон ажиллаж байна. Иймд Институтийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүгийн дэмжлэг, гишүүнчлэлийн төлбөрийг гишүүн улсуудаас гаргуулах саналыг Монгол Улс дэвшүүлж байна. Энэ нь эхний удаад 50 мянган ам.доллараас доош байж болох ажээ.

Дөрөвдүгээрт: Монгол Улс ПАК-д63.574,0 сая орчим төгрөгийн татвар жил бүр төлж, тус байгууллагаас манайд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны бүхийл хэлбэрийг авч байна. Жишээлбэл, ПАК-ын гишүүн 27 орны бүтээгдэхүүн тогтолцооны байгууллагын итгэмжлэлийн үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх гэрээнд Монгол Улс нэгдэж гарын үсэг зурсан. “Энэ нь манай бизнесийн байгууллагуудын гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой” хэмээн Стандарт хэмжил зүйн газраас онцлоод байна. Мөн Стандарт, Хэмжил Зүйн Итгэмжлэлийн Газар 2016 оны 8 дугаар сарын 22-26-нд ПАК-ын үнэлгээнд давтан амжилттай хамрагдсан.

Тавдугаарт: Монгол Улс гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу Ази-Номхон Далайн Бүсийн Статистикийн ИнститутийнБайгууллагад ойролцоогоор 18.635,2мян.төгрөгийн татвар төлж байна, харин тухайн байгууллагаас Монгол Улсын Статистикийн салбарын үйл ажиллагааг сайжруулах олон төсөл хэрэгжүүлж, техникийн

тусламжзүүлээд байна. Тухайлбал, Ази-Номхон Далайн Бүсийн Статистикийн Институтийн гишүүн болсноор хүн ам, нийгмийн статистикийн чиглэлээр төрөл бүрийн түүвэр судалгаа явуулж буйн зэрэгцээ статистикийн боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх тухайд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүн амын сан, Хүүхдийн сан, Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк, Олон Улсын Валютын Сан, Эдийн Засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага болон Евростат зэрэг олон улсын байгууллагатай өргөн хүрээтэй хамтран ажиллаж байна.

Хүн ам, орон сууцны 2000, 2010 оны тооллого, цаг ашиглалт, ажиллах хүчний түүвэр судалгааг дээрх олон улсын байгууллагын санхүүжилт, техникийн тусламжтайявуулж ирсэн. Түүнчлэн олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр мэргэжил дээшлүүлэх сургалт семинарт статистикийн төв, орон нутгийн байгууллагын олон арван хүнийг хамруулж, боловсон хүчнийхээ чадавхийг дээшлүүлж байна.

Дүгнэлт

“Азийн хөгжлийн банк, түүний зээлдэгч зөвлөх үйлчилгээ авахад мөрдөх журам” 2007 онд шинээргарсан бөгөөд Монгол Улс уг байгууллагаас хүртэх үр ашгийг нэмэгдүүлэхий тулд дүрэм журмыг нь дагахын зэрэгцээ гишүүнчлэлийн татвараа цаг тухайд нь төлөх, манай улсад хэрэгжүүлэх хамтын ажиллагааны бүхийл хэлбэрийг дэмжиж ажиллах шаардлагатай байна.

АДБХОБ нь Азийн бүсийн нутгийн дэд бүтцийн салбарт тулгарч буй хөрөнгийн санхүүгийн асуудлыг шийдвэрлэх, хөрөнгө мөнгөний урсгалыг зөв зохистой хуваарилах, бүс нутгийн хөгжилд чухал түлхэц өгч чадахуйц ихээхэн ач холбогдолтой, хөрөнгийн их сантай хөтөлбөр юм. Жишээлбэл, АДХОБ-ны хөтөлбөр нь Пакистаны хурдны замын төслийн санхүүжилтэндзориулж АХБ-тай хамтран тус тус 100 сая ам.долларын зээлийг 2016 онд олгохоор зөвшөөрсөн. Хөтөлбөрийн хүрээндтээврийн 6 корридорт хамаарах 8592 километр авто зам, 5103 километр төмөр замыг шинээр барьж байгуулах буюу сэргээн засварласан нь бүс нутгийн орнуудыг хооронд нь бусадтай холбоход тусалж, худалдааны эргэлтийг нэмэгдүүлсэн. Мөн 9041 километр үргэлжлэх эрчим хүчний дамжуулах шугамыг суурилуулсан нь эрчим хүчний илүүдэлтэй Төв Азийн орнуудаас эрчим хүчний хомсдолтой Афганистан, Пакистан зэрэг Зүүн Азийн орнуудад эрчим хүч

нийлүүлж, худалдааны харилцааг дэмжсэн бүтээн байгуулалт болсон юм. Үүнээс харахад АДБХОБ нь Монгол Улсын хөгжилд чухал түлхэц үзүүлэх боломжтой юм.

КАРЕК-ийн Институтийн хувьд Монгол Улс нь гишүүнчлэлийн төлбөрийн санаачлага гаргах эс бөгөөс нэг удаагийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх нь бүс нутгийн хэмжээнд Монгол Улсын нэрийг гаргах, Институтийн шийдвэрт нөлөөлөх боломжийг нэмэгдүүлийн зэрэгцээ чухал арга хэмжээнд оролцох боломжийг олгохболно.

Эцэст нь дүгнэхэд, Монгол Улс олон улсын байгууллагад нэгдэн орсноор статус квогоо баталгаажуулах, олон улсын хамтын нийгэмлэгээс зохих дэмжлэг авч байх бүрэн боломжтой юм. Энэ утгаараа улс төрийн болон эдийн засгийн давхар ач холбогдолтой гэж судлаачийн хувьд үзэж байна. Монгол Улс нь олон талт хамтын ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх өөрийн гэсэн тодорхой менежменттэй байх нь чухал юм.

Ашигласан материал

1. Гадаад Харилцааны Яам, Гадаад бодогын хөх ном 2017
2. К.Дэмбэрэл, Олон улсын харилцааны онол, үйл ажиллагааны үндэс УБ., 2018, 280-281
3. Сангийн сайдын олон улсын байгууллага, гэрээ, конвенцийн итгэмжит санд төлөх татвар, хандивын багцын жагсаалт 2018

Цахим хуудас

1. <https://www.adb.org/mn/news/adb-mongolia-sign-agreements-support-ger-areas-development-and-deepen-financial-services>
2. <https://www.aiib.org/en/index.html>
3. <https://www.nso.gov.mn/content/231#.XE4BiUzbIU>
4. <https://www.legalinfo.mn/annex/details/1594?lawid=7830>
5. <https://www.carecprogramm.org>
6. <https://www.legalinfo.mn/law/details/12004>

МОНГОЛ, ЯПОНЫ ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

М.Болормаа

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд шинэ мянганы эхэн үе буюу 2000 оноос хойшхи Монгол Японы худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдлыг Хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ), худалдаа, хөрөнгө оруулалт, Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЕРА)-ийн хүрээнд тоймлон авч үзэх оролдлого хийлээ.

Түлхүүр үгс: Хөгжлийн албан ёсны тусламж, худалдаа, хөрөнгө оруулалт, Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр

Монгол улсад үзүүлж ирсэн Япон улсын тусламж

Япон улсын Засгийн газар Хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ) үзүүлэх орны тоонд Монгол улсыг 1990 онд оруулсан юм. ХАЁТ нь дотроо буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, техникийн хамтын ажиллагаа гэсэн 3 төрөлтэй. Японы ХАЁТ-ийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд нь Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжих үеийн хүндрэлийг даван туулах, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт хийх, нийгмийн олон талын асуудлыг шийдвэрлэх, хүний нөөцийг хөгжүүлэх зэрэг өргөн цар хүрээтэй асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсаар ирсэн. Тусламжийн төслүүд хэрэгжсэнээр манай улс бүтэцийн суурь өөрчлөлтөө амжилттай хийж, эдийн засгийн хүндрэлээс гарч, хөрөнгө оруулалт идэвхжиж, ядуурлыг бууруулж, ажлын байрыг нэмэгдүүлэн, ард Олон Улс Судлал №1, 2017 он: 51-59 хуудас ОЛОН УЛС СУДЛАЛ 52 2017/№1 түмний аж амьдрал дээшлэхэд маш чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. 2014 оны байдлаар Япон улсаас Монгол улсад жилд дунджаар 45-50 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, 30-35 сая ам.долларын буцалтгүй тусламж, 10 гаруй сая ам.долларын техникийн хамтын ажиллагааны тусламж олгосоор ирсэн нь манай улсад үзүүлж буй гадаадын зээл тусламжийн гуравны нэгийг эзэлж байв.¹ Японы Засгийн газраас манай улсад үзүүлсэн тусламж нь мал аж ахуй, газар тариалан, аж үйлдвэр (үүний дотор уул уурхай, эрчим хүч, дулааны үйлдвэрлэл, усан хангамж, хог хаягдлын үйлчилгээ), барилга, холбоо мэдээлэл, тээвэр ложистик, нийтийн үйлчилгээ, худалдаа, байгаль орчны хамгаалал зэрэг манай эдийн засаг, дэд бүтцийн бараг бүх салбарыг хамарч байна. 2000 оноос 2015 оны хооронд 65 тэрбум 985 сая иэний буцалтгүй тусламж, 95 тэрбум 957 сая иэний хөнгөлөлттэй зээл, 28 тэрбум 662 сая иэний техникийн хамтын ажиллагааны тусламжийг² өгчээ. Япон улсаас Монгол улсад суугаа Элчин сайдын яамны сайтад Япон улсаас Монголд өгөх ХАЁТ-ийн чиглэлийн талаар бичихдээ, “Монгол улсын эдийн засаг Япон зэрэг хандивлагч орнуудын дэмжлэгтэйгээр, мөн урд хөрш болох БНХАУ-ын эдийн засгийн хөгжлийн нөлөө болон дотоодын уул уурхайн салбарын хөгжлийг даган хурдацтай өсөж байна. Гэвч Монгол улсын эдийн засаг нь эрдэс баялгийн экспортоос ихээхэн хамааралтай тул цаашид аж үйлдвэрийг төрөлжүүлэх асуудал тулгамдаж байна. Мөн эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгоход макро эдийн засгийн тогтвортой менежмент шаардагдаж байна. Нөгөө талаар, эдийн засгийн хурдацтай өсөлтийн үр шим нийгмийн ядуу давхаргад хангалттай хүрэхгүй байгаа тул ядуурал ба ажилгүйдлийн түвшин урьдын адил өндөр, ялангуяа залуу ажиллах хүчнийг ажлын байраар хангах асуудал тулгамдсан хэвээр байна. Нийслэл Улаанбаатар хотод хүн ам хэт төвлөрч буйгаас үүдэн суурь дэд бүтцийн дутмаг байдал, 1 Монгол улсаас Япон улсад суугаа элчин сайдын яамны сайт, “Худалдаа, эдийн

засгийн харилцаа” <http://www.tokyo.embassy.mn/index.php?moduls=14> 2 Япон улсаас Монгол улсад суугаа элчин сайдын яамны сайт, “Япон улсаас Монгол улсад үзүүлсэн зээл тусламжийн нэгдсэн дүн”, http://www.mn.emb-japan.go.jp/mn/bi_relation/econ_coop/econcoop-list.html 2017/№1 53 Монгол, Японы дипломат харилцаа: Гүнзгийрэл, чиг хандлага орчны бохирдол зэрэг асуудлууд урган гарсаар байна. Дээрх нөхцөл байдлыг харгалзан Япон улсын Засгийн газрын зүгээс Монгол улсын эдийн засгийн өсөлтийн үр шимийг нийгмийн бүх давхаргад жигд хүртээмжтэй болгох, Мянганы хөгжлийн зорилт зэрэг хөгжлийн цогц бодлого зорилтыг хэрэгжүүлэх, эдийн засгийн тогтвортой, тэнцвэртэй өсөлтийг бий болгоход чиглэсэн Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр 1. Уул уурхайн тогтвортой хөгжлийг хангах, засаглалыг бэхжүүлэх, 2. Бүх хүнд өгөөжтэй өсөлтийг бэхжүүлэх, 3. Улаанбаатар хотын чадавхийг бэхжүүлэх гэсэн гурван үндсэн чиглэлд ХАЁТ-аа чиглүүлж байна”³ гэжээ. Сүүлийн үед Монгол улсын эдийн засаг тэлэн өргөжихийн хэрээр Японы Улсын ХАЁТ-ийн хэлбэр, агуулгад өөрчлөлт гарч байна. Монгол улсын эдийн засаг эрчимтэй өссөнөөр Монголын нэг хүнд оногдох ДНБ-ий хэмжээ Дэлхийн банкнаас тогтоосон IDA стандартаас даваад байна. Тийм учраас цаашид Япон улсаас Монгол улсад үзүүлэх эдийн засгийн дэмжлэг дотор буцалтгүй тусламжийн хэмжээ ихээхэн багасах хандлагатай байгаа бөгөөд үүний оронд бага хүүтэй, урт хугацааны иэний хөнгөлөлттэй зээлийн хамтын ажиллагаа өргөжих хандлагатай байна. Монгол, Японы худалдааны харилцааны өнөөгийн байдал Монгол улсын Засгийн газрын тэргүүн Д.Содном 1990 оны 2 дугаар сард Япон улсад айлчлах үед хоёр улсын хооронд худалдааны хэлэлцээр байгуулсан юм. Японы талын статистикийн мэдээнээс үзвэл, Монгол Японы хооронд хийгдсэн худалдааны дүн 2014 оны байдлаар ойролцоогоор 36 тэрбум 400 сая иэн байжээ. Үүнээс Японоос Монголд гаргасан экспортын барааны дүн 34 тэрбум 570 сая орчим иэн байна. Харин Монголоос Японд оруулсан импортын барааны дүн 1 тэрбум 810 сая орчим иэн байна.⁴ Японы Сангийн 3 “Япон-Монголын хөгжлийн хамтын ажиллагааны тухай”, http://www.mn.emb-japan.go.jp/mn/bi_relation/econ_coop/econcoop-guideline.html 4 『最近のモンゴル情勢と日・モンゴル関係』平成 28 年 1 月、 (“Монголын сүүлийн үеийн нөхцөл байдал ба Япон, Монголын харилцаа”, 2016 он, 1 дүгээр сар) <http://www.mofa.go.jp/mofaj/files/000047765.pdf> ОЛОН УЛС СУДЛАЛ 54 2017/№1 яамны статистикийн мэдээнээс үзвэл, Монгол Японы хоорондын худалдааны дүн 2015 оны байдлаар 36 тэрбум 926 сая орчим иэн болжээ. Үүнд Монголоос Япон руу хийгдсэн экспортын дүн 6 тэрбум 574 сая орчим иэн болсон ба Японоос Монгол руу хийгдсэн импортын дүн 30 тэрбум 351 сая орчим иэн болсон байна. Японоос Монгол руу экспортолдог гол бараа бүтээгдэхүүн нь автомашин, ердийн техник хэрэгсэл, барилгын техник хэрэгсэл, уул уурхайн техник хэрэгсэл юм. Мөн сүүлийн үед хүнс, эрүүл мэнд, гоо сайхны бүтээгдэхүүн ч оруулж байна. Монголоос Япон руу экспортолдог гол бараа бүтээгдэхүүн нь ашигт малтмал (нүүрс, хайлуур жонш), ноос ноолууран бүтээгдэхүүн ажээ.⁵ Мөн хүнс (давс, чацаргана, цагаан идээ) экспортолж байна. 2000 оноос хойш Япон улстай хийсэн худалдааны дүнг он тус бүрээр үзүүлвэл дараах байдалтай байна. Хүснэгт 1. 2000-2015 онд Япон улстай хийсэн худалдааны дүнб /сая ам.доллар/ онууд Нийт эргэлт Экспорт Импорт 2000 81.4 8.1 73.3 2001 71.7 15.7 56.0 2002 49.1 6.3 42.8 2003 71.9 8.5 63.4 2004 108.4 33.4 75.0 2005 81.3 5.8 75.5 2006 104.7 7.1 97.6 2007 155.3 15.1 140.2 2008 266.1 27.6 238.5 2009 101.6 4.6 97.0 5 『モンゴル国、基礎データ』、 (“Монгол улс, үндсэн мэдээлэл”), <http://www.mofa.go.jp/mofaj/area/mongolia/data.html> 6 “Монгол улсын статистикийн эмхэтгэл”

2000-2015 2017/№1 55 Монгол, Японы дипломат харилцаа: Гүнзгийрэл, чиг хандлага онууд Нийт эргэлт Экспорт Импорт 2010 199.2 2.7 196.5 2011 501.2 11.0 490.2 2012 507.2 5.6 501.6 2013 454.7 10.5 444.2 2014 392.2 24.5 367.8 2015 295.0 20.3 274.6 Эх сурвалж: “Монгол улсын статистикийн эмхэтгэл” 2000-2015 Дээрх хүснэгтээс харвал худалдааны алдагдал их байна. Япон руу гаргадаг экспортын барааны хэмжээ бага, Японоос оруулдаг импортын барааны хэмжээ хэд дахин их байна. Энэ алдагдлыг багасгах шаардлагатай. Ингэхийн тулд дотоодын үйлдвэрлэлээ нэмэгдүүлж, экспортын барааны хэмжээг нэмэх хэрэгтэй юм. Мөн Японы техник технологийг нэвтрүүлж, бараа бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулан, Японы зах зээлд борлогдох түвшний бүтээгдэхүүн үйлдвэрлэх хэрэгтэй гэж үзэж байна. Монгол, Японы хооронд ЕРА байгуулах хэлэлцээг 2012 оны 6 дугаар сараас 2014 оны 7 дугаар сар хүртэл нийт 7 удаа хийж, зарчмын тохиролцоонд хүрсэн. “Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол улс, Япон улсын хоорондын хэлэлцээр”-т хоёр орны Ерөнхий сайд нар 2015 оны 2 дугаар сарын 10-нд гарын үсэг зурсан билээ. Энэ хэлэлцээр нь 2016 оны 6 дугаар сарын 7-нд хүчин төгөлдөр болсон юм. Хэлэлцээр нь дотроо 13-14 чиглэлтэй, худалдааны тариф, саад болоод бусад тотгорыг арилгах, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах, оюуны өмч, гаалийн горим, хамтын ажиллагаа, цахим худалдаа гэх мэт өргөн цар хүрээтэй хамтын ажиллагааны асуудлуудыг хамарч байна. Бизнес эрхлэгчдэд очих шууд нөлөөлөл нь барааны гаалийн татварыг чөлөөлөх явдал юм. Дэлхийн худалдааны байгууллагад бүртгэгдсэн, гаалийн кодлолоор 9000 орчим барааны татварыг чөлөөлж байгаа бөгөөд хоёр орны бизнес эрхлэгчдийн экспорт, импортын зардал буурах үр дүн гарна гэж хэлж болно. Монгол улс юуны түрүүнд Японы ОЛОН УЛС СУДЛАЛ 56 2017/№1 өндөр технологи, техник, менежмент, ажлын арга барилыг эдийн засагтаа нэвтрүүлэхийг сонирхож байгаа бол Япон улс нүүрс, зэс, цайр болон бусад эрдсийн түүхий эд, монгол малын мах, ноос зэрэг ХАА-н бүтээгдэхүүнийг худалдан авахыг сонирхож байгаа билээ. Хоёр тал хөдөө аж ахуй, аж үйлдвэр, дэд бүтэц, уул уурхай, аялал жуулчлалын салбарт өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх, Улаанбаатар болон аймгуудад эмнэлгийн сургалт-оношлогооны төвүүд, нефть боловсруулах үйлдвэр, Хөшигтийн хөндийн олон улсын нисэх буудал байгуулах, Тавантолгойн зүүн чиглэлийн төмөр зам зэрэг томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд санхүү, техникийн талаар хамтран ажиллах юм. “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр” хүчин төгөлдөр болсны дараа байгуулагдсан Монгол улсын Засгийн газар хэлэлцээрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх талаар түншлэгч талтай идэвхитэй хамтран ажиллахаа мэдэгдсэн бөгөөд Монгол улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын 2016 оны 10 дугаар сард Япон улсад хийсэн айлчлалын үеэр хоёр тал хөдөө аж ахуй, хүрээлэн буй орчин, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлд хамтын ажиллагааг үргэлжүүлэх, 2015-2017 онд хэрэгжиж байгаа Дунд хугацааны хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэх хамтын ажиллагааны шинэ төлөвлөгөө боловсруулахаар тохиролцсон билээ. Японоос Монголд оруулсан шууд хөрөнгө оруулалт Монголд оруулсан Японы шууд хөрөнгө оруулалт өнөөгийн байдлаар манай хөнгөн үйлдвэр, соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, хэвлэл, харилцаа холбоо, тээвэр, худалдаа, нийтийн хоол, геологи уул уурхайн эрэл хайгуул, судалгаа, олборлолт, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалт, инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, аялал жуулчлал, банк санхүүгийн үйл ажиллагаа, эрүүл мэнд, гоо сайхны үйлчилгээ, худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээ, мал аж ахуй, газар тариалан, эрчим хүч, мебель модон эдлэл, цахилгаан хэрэгслийн үйлдвэрлэлийн салбарт тодорхой хэмжээний хөрөнгө

оруулалт хийжээ. Японы хөрөнгө оруулалтын дийлэнх хувь буюу 48% нь худалдаа, нийтийн хоол, 18% 2017/№1 57 Монгол, Японы дипломат харилцаа: Гүнзгийрэл, чиг хандлага нь хөнгөн үйлдвэр, 6% мэдээлэл, холбооны технологи, 7.3% нь банк санхүүгийн салбарт ногдож байна. Харин геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолтын салбарт 2.7%, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын салбарт 1.1% ногдож байна.7 1990-2016 он хүртэл Монголд орсон Японы хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 262 сая ам.доллар байна. Энэ нь Монголд хөрөнгө оруулсан орнуудын дотор 11 дүгээр байранд жагсаж байна. 2014 оны 10 дугаар сарын 1-ний байдлаар Монголд салбараа нээсэн Японы 31 компани, Монголын компанитай хамтарсан 194 компани байсан ба эдгээрийн ихэнх нь жижиг дунд аж ахуйн нэгжүүд байжээ. Хоёр орны хооронд байгуулагдсан Япон, Монголын хөрөнгө оруулалтын хэлэлцээр 2002 оны 3 дугаар сараас хэрэгжсэн юм.8 Монголд орох Японы хөрөнгө оруулалтын хэмжээ, компанийн тоо өнөөдрийг хүртэл буурч ирсэн үзүүлэлттэй байна. Үүнд Монголын улс төрийн тогтворгүй байдал, хууль эрх зүйн орчин, авлигал, хүнд суртал, төрийн албан хаагчдын ёс зүйгүй байдал нөлөөлжээ.9 Цаашид Японы хөрөнгө оруулалтын хэмжээ, компанийн тоог нэмэгдүүлэхийн тулд улс төрөө тогтвортой байлгаж, хууль эрх зүйн орчноо сайжруулан, авлигал, хүнд суртал, төрийн албан хаагчдынхаа ёс зүйгүй байдлыг арилгах шаардлагатай байна. Дүгнэлт Япон улсын Засгийн газарМонгол улсад 2000-2015 он хүртэлх хугацаанд нийтдээ 190 тэрбум 604 сая иэний тусламж, хөнгөлөлтэй зээл олгосон байна. Өөрөөр хэлбэл, 65 тэрбум 985 сая иэний буцалтгүй тусламж, 95 тэрбум 957 сая иэний хөнгөлөлттэй зээл, 28 тэрбум 662 сая иэний техникийн хамтын ажиллагааны тусламж үзүүлжээ. Уг тусламж нь Монголын нийгэм, эдийн засгийн 7 “Монгол Японы худалдаа, эдийн засгийн харилцааны товч лавлах”, <http://tokyo.mfa.gov.mn/index.php?option=com> 8 『最近のモンゴル情勢と日・モンゴル関係』平成28年1月、“Монголын сүүлийн үеийн нөхцөл байдал ба Япон, Монголын харилцаа”, 2016 он, 1 дүгээр сар) <http://www.mofa.go.jp/mofaj/files/000047765.pdf> 9 “Японы хөрөнгө оруулалт, зээл, тусламж, түүний үр ашиг” ШУА-ийн ОУСХ, УБ, 2004, 56 дугаар тал ОЛОН УЛС СУДЛАЛ 58 2017/№1 хүндрэлийг даван туулах, зах зээлийн эдийн засагт шилжих, Монгол улсын шинэ хөгжлийн суурийг тавихад үлэмж хувь нэмэр болсон билээ. Монгол, Японы Стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр 2013 оноос амжилттай хэрэгжиж эхэлсэн бөгөөд эхний хэсэг энэ онд дууссан юм. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хамгийн том ажил бол Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгон хэрэгжүүлж эхэлсэн явдал зүй ёсоор орно. Өнгөрсөн оны 6 дугаар сард Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болж, хэрэгжүүлж эхэлснээс энэ оны хоёрдугаар сарын байдлаар нийт 320 ширхэг, нийт 8.2 сая ам.долларын үнэ бүхий Монголд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг гаалийн тарифын хөнгөлөлттэй нөхцөлөөр Япон улсад экспортлож, 300 гаруй бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ олгоод буй аж. Энэ бүхнээс үзэхэд манай засаг төр хууль эрх зүйн орчноо тогтворжуулж, хэлсэндээ хүрч, итгэл олж, хувийн хэвшлийн бизнес эрхлэгчдийг бодлогоор дэмжвэл өрсөлдөх чадвартай, стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг Японы зах зээлд гаргах, хөрөнгө оруулалт татах, хамтарсан үйлдвэрлэл эрхлэх өргөн боломжтой болохыг харуулж байна. Хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг улам бүр тэлэн өргөжүүлэхэд энэ оны эхний хагасаас хүчин төгөлдөр болсон Монгол, Японы Стратегийн түншлэлийн дунд хугацааны 2017-2021 он хүртэлх хамтын ажиллагааны хөтөлбөр жинтэй хувь нэмэр оруулах нь

дамжиггүй. Ном зүй: 1. “Японы хөрөнгө оруулалт, зээл, тусламж, түүний үр ашиг” ШУА-ийн ОУСХ, УБ, 2004 2. “Монгол улсын статистикийн эмхэтгэл” 2000-2015 3. Монгол улсаас Япон улсад суугаа элчин сайдын яамны сайт, “Худалдаа, эдийнзасгийн харилцаа” <http://www.tokyo.embassy.mn/index.php?moduls=14> 2017/№1 59 Монгол, Японы дипломат харилцаа: Гүнзгийрэл, чиг хандлага 4. Япон улсаас Монгол улсад суугаа элчин сайдын яамны сайт, “Япон улсаас Монголулсад үзүүлсэн зээл тусламжийн нэгдсэн дүн”, http://www.mn.emb-japan.go.jp/mn/bi_relation/econ_coop/econcoop-list.html 5. “Япон-Монголын хөгжлийн хамтын ажиллагааны тухай”, http://www.mn.emb-japan.go.jp/mn/bi_relation/econ_coop/econcoop-guideline.html 6. “Одоо хэрэгжиж буй болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй техникийн хамтын ажиллагааны төслүүд” http://www.mn.emb-japan.go.jp/mn/bi_relation/econ_coop/TC.mon.pdf 7. “Монгол Японы худалдаа, эдийн засгийн харилцааны товч лавлах”, <http://tokyo.mfa.gov.mn/index.php?option=com> 8. 『モンゴル国、基礎データ』、 (“Монгол улс, үндсэн мэдээлэл”), <http://www.mofa.go.jp/mofaj/area/mongolia/data.html> 9. 『最近のモンゴル情勢と日・モンゴル関係』平成 28 年 1 月、 (“Монголын сүүлийнүеийн нөхцөл байдал ба Япон, Монголын харилцаа”, 2016 он, 1 дүгээр сар) <http://www.mofa.go.jp/mofaj/files/000047765.pdf> 10. 『最近のモンゴル情勢と日・モンゴル関係』平成 28 年 1 月、 (“Монголын сүүлийнүеийн нөхцөл байдал ба Япон, Монголын харилцаа”, 2016 он, 1 дүгээр

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: МОНГОЛ, ЯПОНЫ ХАМТЫН АЖИЛЛАГАА

У.Загдцэсэм

Энэхүү өгүүлэлд дэлхий нийтийн хөгжлийн шинэ чиг хандлага болсон тогтвортой хөгжил, түүний зорилтуудыг хангахын төлөөх Япон улсын идэвхи чармайлт, Монгол улсын тогтвортой, урт хугацааны хөгжлийн зорилтуудыг хангахад Монгол, Японы хамтын ажиллагаа хэрхэн чиглэгдэж буй талаар товч өгүүлнэ.

Түлхүүр үгс: Тогтвортой хөгжил, тогтвортой хөгжлийн хөтөлбөр, тогтвортой хөгжлийн зорилт, хөгжлийн төлөөх түншлэл, Монгол, Японы хамтын ажиллагаа

1960-аад оны сүүлчээр олон улсын тавцанд аж үйлдвэржилтийн сөрөг нөлөө, баялагийн зүй бус ашиглалт, хүн амын хэт их өсөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас байгаль экологийн тэнцвэр алдагдаж, цөлжилт, нөөц баялагийн хомсдол, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшгийн давтамж нэмэгдэх зэрэг дэлхий нийтийг хамарсан асуудлууд улам ноцтой болж, хүн төрөлхтөн эдийн засаг, нийгэм, байгаль орчны томоохон эрсдэлтэй тулгарах талаар олон улсын тавцанд хурцаар хэлэлцэгдэж эхэлжээ. Дээрх асуудлуудыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэн НҮБаас 1972, 1987, 1992, 1997, 2000, 2002, 2012 онд хуралдсан чуулгануудаараа байгаль орчны доройтолд хариу өгөх зайлшгүй шаардлага тулгарсныг хүлээн зөвшөөрч, “Байгаль орчин, эдийн засаг, нийгмийг хэрхэн яаж зөв зохистой хослуулан хөгжих вэ” гэдэг асуултыг дэлхий нийтийн хэмжээнд гарган тавьж, “Хүний хүрээлэн буй орчны тунхаглал”, “Байгаль орчин хөгжлийн талаарх Риогийн Олон Улс Судлал №1, 2017 он: 35-49 хуудас ОЛОН УЛС СУДЛАЛ 36 2017/№1 тунхаглал”, “XXI зууны хөгжлийн хөтөлбөр”, “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай конвенци”, “Киотогийн протокол” зэрэг олон чухал цуврал баримт бичгийг батлан гаргаж, шинэ зуунд дэлхийн улс орнууд тогтвортой хөгжлийн загвараар хөгжих ёстой гэсэн нэгдсэн ойлголтод хүрсэн байна. 2015 оны 9 дүгээр сард НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 70 дугаар чуулган “Transforming Our World: The 2030 Agenda for Sustainable Development” буюу “Эх дэлхийгээ өөрчлөх нь: Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030” сэдвээр хуралдаж, НҮБ-ын гишүүн орнууд “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийг баталсан билээ. НҮБ-аас энэхүү хөтөлбөрөөр дамжуулан хөгжиж буй орнууд төдийгүй хөгжингүй улс орнуудад ч “шударга ёс, хүний эрхийг дээдэлсэн, тэгш хүртээмжтэй хөгжлийг бий болгохыг эрмэлзэж, тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, хэнийг ч орхигдуулахгүй бүхнийг хамарсан нийгмийн хөгжлийн төлөө хамтран ажиллах үүрэг хариуцлага”-ыг ногдуулсан юм. “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр” нь 2001 онд батлагдсан “Мянганы хөгжлийн зорилт”-ын үргэлжлэл бөгөөд 2016-2030 он хүртэл хэрэгжүүлэх 17 зорилтыг дэвшүүлж, дэлхийн улс орнууд энэ зорилтод нийцүүлэн үндэсний хөгжлийн бодлогоо сайжруулж, нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудлуудыг цогцоор шийдвэрлэх тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн төлөөх түншлэлийг хөгжүүлэхэд гол анхаарлаа хандуулж байна. “Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030” хөтөлбөрийн зорилтууд нь: 1. Ядуурлыг устгах; 2. Тогтвортой хөдөө аж ахуйг дэмжин хүнсний тэгжээллэг чанар, аюулгүй байдлыг хангах, өлсгөлөнг зогсоох; 3. Бүх насны хүмүүсийн эрүүл аж төрөх байдлыг хангах; 4. Боловсрол эзэмшилт, боловсролын чанарыг нэмэгдүүлэх; 5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах; 6. Цэвэр усны хангамжийг дээшлүүлэх, ариун цэврийн байгууламжаар хангах; 7. Найдвартай, тогтвортой, сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх; 8. Эдийн засгийн өсөлтийг дэмжих, баталгаат ажлын байрыг бий болгох; 9. Тогтвортой

дэд бүтэц, үйлдвэрлэл, инновацийг хөгжүүлэх; 2017/№1 37 Монгол, Японы дипломат харилцаа: Гүнзгийрэл, чиг хандлага 10. Тэгш бус байдлыг бууруулах; 11. Хотуудыг аюулгүй, амар амгалан, тогтвортой байдлаар хангах; 12. Хариуцлагатай хэрэглээг дэмжих; 13. Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах; 14. Далай тэнгисийн нөөцийг хамгаалах; 15. Хуурай газрын экосистемийг хамгаалах; 16. Энх тайван, шударга ёсыг цогцлоох; 17. Тогтвортой хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх¹ зэрэгт чиглэжээ. Япон улсын Засгийн газар дэлхийн өндөр хөгжилтэй, тэргүүлэгч орны хувьд дэлхий нийтийн хөгжилд хувь нэмэр оруулахыг зорьж ирсэн нь 1954 оноос хөгжиж буй орнуудад үзүүлж эхэлсэн Засгийн газрын Хөгжлийн Албан Ёсны Тусламж (Official Development Assistance ODA, ХАЁТ)-аас нь харагддаг. “Япон улсын Засгийн газрын ХАЁТ нь өнөөдөр шинэ тулгар хөгжиж буй 190 улс орон, бүс нутгийг хамарч”² тэдгээр орнуудын хөгжлийн явц дахь тулгамдсан хүнд хэцүү асуудлыг шийдэхэд ихээхэн хувь нэмэр оруулж байна. Нөгөө талаар бүс нутгийн тогтвортой байдал, хөгжил нь Япон улсын аюулгүй байдлыг хангахад чухал нөлөөтэй хүчин зүйлийн нэг хэмээн үзэж, тусламж дэмжлэгийг үзүүлж ирсэн. 2013 оны 12 дугаар сард байгуулагдсан Японы “Үндэсний аюулгүй байдлын зөвлөл”-ийн баримтлах ерөнхий чиглэлд “Олон улсын улс төр, эдийн засгийн хүрээнд чухал үүрэг гүйцэтгэгч улсын хувьд олон улсын тавцанд хамтран ажиллах зарчмын үндсэн дээр энх тайвныг идэвхтэй сахин хамгаалах үүднээс эх орныхоо аюулгүй байдал болон Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, тогтвортой байдал, хөгжлийг хангахад улам идэвхтэй хувь нэмэр оруулах нь манай үндэсний аюулгүй байдлын нэг гол үндсэн чиглэл юм”³ хэмээн заасан байдаг. 1 <http://www.un.org/en/sections/what-we-do/promote-sustainable-development/index.html> 2 http://www.mofa.go.jp/mofaj/ic/ap_m/page3_001019.html (Япон улсын Гадаад хэргийн яамны цахим хуудас.) 3 “Олон улсын харилцаа” сэтгүүл, УБ., 2015 №1/435, 9-р тал., 『2015 年版 開発協力白書』 (“2015 оны хэвлэл Хөгжлийн хамтын ажиллагааны Цагаан ном”) 外務省、2015 年 ОЛОН УЛС СУДЛАЛ 38 2017/№1 Япон улс нь тогтвортой хөгжлийн сэдвээр зохион байгуулагдсан олон улсын хурлуудын зохион байгуулалт болон хэлэлцүүлэгт санал, санаачилга⁴ гарган идэвхитэй оролцож ирсэн. Ялангуяа “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийн хэлэлцүүлэг, яриа хэлэлцээрт идэвхитэй хувь нэмрээ оруулж ирсэн⁵ орны хувьд энэхүү түүхэн хөтөлбөр батлагдсанд талархаж, Японы хөгжлийн хамтын ажиллагааны дүрэм, хүний аюулгүй байдлыг хамгаалах үзэл баримтлалдаа тулгуурлан дэлхийн улс орнуудтай хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахын тулд давуу талаа ашиглан, хүчин чармайлт гаргаж ажиллахаа мэдэгдсэн. Япон улсын Ерөнхий сайд Абэ Шинзо НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганд хийсэн мэдэгдэлдээ “Тогтвортой хөгжлийг бодитой болгохын төлөөх бидний урт хугацааны хүчин чармайлтын үр дүнд түүхэн хөтөлбөрийг баталлаа. Шинэ хөтөлбөрт Япон улс анхааран авч үзсээр ирсэн хүн, дэлхий, хөгжил цэцэглэлт, энх тайван, түншлэл болон эмэгтэйчүүд, эрүүл мэнд, боловсрол, гамшгаас хамгаалах, өндөр чанартай өсөлт гэсэн хүчин зүйлүүдийг гол цөмд нь тавьсан. 2030 он гэхэд дэлхий даяар ядуурлыг устгаж, 4 1984 онд Япон улсын санаачлагаар НҮБ-ын дэргэд “Байгаль орчин, хөгжлийн асуудлаарх дэлхийн хороо” байгуулагдаж, 1987 онд тус хорооноос “Бидний нийтлэг ирээдүй” (Our Common Future) тайлан гаргасан. Тайланд “Тогтвортой хөгжил” гэсэн нэр томъёо анх хэрэглэгдэж, “Ирээдүй хойч үеийнхний хэрэгцээг хангах нөөц баялгийг устгахгүйгээр өнөө үеийнхний хэрэглээг хангаж чадах хөгжил” гэж тодорхойлон улс орнууд төрийн бодлогодоо байгаль орчин, эдийн засгийн асуудлыг нэгдмэл байдлаар авч үзэхийг уриалсан. - 2002 онд Өмнөд Африкийн Иоханнесбург

хотноо хуралдсан НҮБ-ын “Даян дэлхийн тогтвортой хөгжлийн чуулган”-д Япон улс 2005 оноос эхлэн дараагийн 10 жилийг “НҮБ, тогтвортой хөгжлийн төлөөх боловсролын 10 жил” болгон үйл ажиллагаа явуулах санал дэвшүүлж дэмжигдсэн.平成 26 年版「環境白書—我が国が歩むグリーン経済の道」(Хэйсэйгийн 26 оны хэвлэл “Байгаль орчны цагаан ном -Манай улсын ногоон эдийн засгийн замнал-”) 環境省編、2014 年、p. 53。 5 2011оны 6 дугаар сарын 2-3-нд Токио хотод “Мянганы зорилтын дараах дэмжлэг үзүүлэх уулзалт” (MDGs フォローアップ会合) -ыг зохион байгуулсан нь 2015 онд дуусах Хөгжлийн зорилтын дараа дэвшүүлэх Шинэ зорилт (“Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөр”) -ын талаар хэлэлцүүлгийг эхлүүлэх гараа болсон. Мөн “2015 онд дуусах Хөгжлийн зорилтын дараагийн зорилтын талаар хэлэлцэх оролцогч талуудын хуралдаан” (ポスト 2015 年開発目標に関するコンタクト・グループの主催)-ыг 2011-2013 онд нийт 5 удаа зохион байгуулж даргалан удирдсан. http://www.mofa.go.jp/mofaj/ic/ap_m/page3_001019.html(Япон улсын Гадаад хэргийн яамны цахим хуудас.) 2017/№1 39 Монгол, Японы дипломат харилцаа: Гүнзгийрэл, чиг хандлага тогтвортой дэлхийг бодит болгохын төлөө бидний үйл ажиллагаа энд туссан. 1990-ээд онд олон улсын хөгжлийн зорилтыг дэвшүүлж, түүний төлөөх үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулж ирсэн Япон улс нь “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр” батлагдсаныг баяртайгаар хүлээн авч, хүчин зүтгэж ирсэн бүх хамтрагчдад талархал илэрхийлье. Энэ хөтөлбөрийн хэрэгжилтэд хуучны “өмнөд умард”-ын үзэл ойлголтыг даван туулах, бүх улс орон, хувийн хэвшил, хотын иргэд зэрэг оролцогч талуудын гүйцэтгэх үүрэг, шинэ глобал түншлэл зайлшгүй хэрэгтэй. Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуус ч оролцох механизм хэрэгтэй. Япон улс нь тэдгээрийн нэгэн гишүүний хувьд олон улсын хамтын нийгэмлэгтэй хамтдаа хөтөлбөрийг бодит болгохын тулд давуу талаа ашиглан хүчин чармайлт гаргахаа илэрхийлье. Япон улс нь өнөөг хүртэл 60 гаруй жилийн хугацаанд хөгжиж буй орнуудад 330 тэрбум ам.долларын Засгийн газрын ХАЁТ-ийг олгож, 560 мянган хүний мэргэжлийг дээшлүүлж, 190 мянган мэргэжилтэн болон сайн дурын ажилтан илгээх зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан олон улсын хамтын нийгэмлэгийн тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтэнд хувь нэмрээ оруулсаар ирлээ. Цаашид ч “Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030”-ийг дэмжиж ажиллана. 2015 онд шинэчлэн баталсан Япон улсын хөгжлийн хамтын ажиллагааны дүрмэнд ч энэ талаар заасан. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахын тулд нэгдүгээрт, ядуурлыг бууруулахыг зорьж, хүртээмжтэй, тогтвортой, “чанартай өсөлт”-ийг бий болгох хэрэгтэй. Үүний тулд түүний суурь болсон өндөр чанартай дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг Ази, Африк болон дэлхийн бүс нутаг бүрт оруулахыг дэмжих болно. Ингэхдээ хөгжлийн хамтын ажиллагааны хурдасгуур болсон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, технологийн харилцан түншлэлийг өргөжүүлнэ. Мөн Японы давуу тал болох боловсрол, технологийн өндөр чадавхийг ашиглан аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих болно. Хоёрдугаарт, хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх бодлогын үүднээс хөгжил дорой хүмүүсийг хамгаалах, тэдний чадварыг нэмэгдүүлэхийг дэмжих бодлогыг баримтална. Үүний тулд зайлшгүй хэрэгтэй нийгмийн хамгааллын салбарт анхаарч, эрүүл мэндийн тогтолцоог сайжруулснаар эвола вирус зэрэг халдварт өвчний ОЛОН УЛС СУДЛАЛ 40 2017/№1 тархалтын эсрэг болон бүх нийтийн эрүүл мэндийг хамгаалахыг (Universal Health Coverage) зорьсон хамтын ажиллагааны шинэ чиг бодлогыг дэвшүүлэн тавьсан. Боловсролын салбарт чанартай сургалт, аж үйлдвэрлэл, шинжлэх ухаан технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх хамтын ажиллагааны шинэ чиг бодлогыг тусгасан “Энх тайван, эдийн засгийн өсөлтийн төлөөх сургалтын

стратеги”-ийг зарлалаа. Гамшгаас хамгаалах талаар 2015 оны 3 дугаар сард батлагдсан “Сэндайн Гамшгаас хамгаалах баримт бичиг 2015-2030”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд анхаарлаа хандуулна. Мөн цунамигийн талаарх зөв ойлголтыг түгээхийн тулд НҮБ-ын “Цунамигийн эсрэг дэлхийн өдөр” –ийг бий болгохыг улс орнуудад уриална. Гуравдугаарт, Япон улс хүрээлэн буй орчин, нийгмийн тогтвортой байдлыг бодит болгоход чиглэж, илүү хүчин чармайлт гаргаж ажиллана. Уур амьсгалын өөрчлөлтийн салбарт ялангуяа хөгжиж буй буурай орнуудад бодит тусламж дэмжлэгийг үзүүлэхийн хамт COP21-ийн орнуудыг бүгдийг оролцуулсан олон улсын тэгш, үр ашигтай механизмийг бий болгоход идэвхитэй хувь нэмэр оруулна. Мөн хог хаягдлын гаралтыг багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах гэсэн 3R (reduce, reuse, recycle)6 -аас эхлээд манай улсын бахархал болсон хязгаартай нөөц баялагийг үр дүнтэй ашиглаж дахин үйлдвэрлэл явуулдаг, нөөц баялагийг тогтвортой дахин ашигладаг нийгэм (循環型社会)7 -ийг байгуулах мэдлэг туршлагыг дэлхийн улс орнуудтай хамтран хуваалцана. Дөрөвдүгээрт, энэ удаад дэлхийн хамгийн томд орох 1 триллион ам.долларын хөрөнгөтэй Японы Тэтгэврийн сангийн хөрөнгийн хуримтлалын үйл ажиллагааг эрхлэн явуулах эрх бүхий төрийн байгууллага (年金積立金管理運用独 6 2004 оны 6 дугаар сард хуралдсан G8-ын уулзалтаар Койзүми Ерөнхий сайд 3R (reduce, reuse, recycle)-ын талаар уриалга гаргаж, 2005 оны 4 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн. 2008 онд хуралдсан G8-ын Байгаль орчны сайд нарын уулзалтаар “Кообэгийн 3R-ын үйл ажиллагааны төлөвлөгөө” батлагдсан. 7 循環型社会 循環型社会形成推進基本法 Хог хаягдал түүнийг дахин ашиглахтай холбогдуулж 2000 онд баталсан “Хязгаартай нөөц баялагийг үр дүнтэй ашиглаж дахин үйлдвэрлэл явуулдаг, нөөц баялагийг тогтвортой дахин ашигладаг нийгмийг дэмжих суурь хууль”. Энэхүү хууль нь хог хаягдлын гаралтыг бууруулж, дахин ашиглах, дахин боловсруулж хэрэглэх, дахин ашиглах боломжгүй хаягдлыг энерги болгон ашиглаж зохистойгоор устгах талаарх бодлогын зарчмыг анхлан тогтоосон. Мөн хог хаягдал гаргагчийн хариуцлагыг тодорхой болгож, үйлдвэр эрхлэгчдэд тавигдах шаардлагыг тогтоосон. 2017/№1 41 Монгол, Японы дипломат харилцаа: Гүнзгийрэл, чиг хандлага 立行政法人 GPIF) нь НҮБ-ын Хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмын баримт бичигт гарын үсэг зурсан. Энэ Тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалт нь тогтвортой хөгжлийг цогцлооход хувь нэмрээ оруулах байх аа гэж бодож байна.”8 хэмээн тогтвортой хөгжлийн төлөө өнөөг хүртэл Япон улсын хэрэгжүүлж ирсэн үйл ажиллагаа, цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааныхаа талаар дүгнэн мэдэгдсэн. Япон улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлд Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлыг хангах, хамтын хөгжлийн төлөө түнш улс орнуудтайгаа хамтран ажиллахыг чухалчлан үзэж тус бүс нутагт идэвхитэй гадаад бодлого явуулдаг. Энэ утгаараа Ази тивд байрладаг Монгол улсын эрх чөлөө, ардчилал, шинэчлэлтийн төлөөх хүчин чармайлтыг анхааран дэмжиж ирсэн. Монгол улсад үзүүлэх Япон улсын Засгийн Газрын ХАЁТ нь 1977 онд хэрэгжсэн Говь ноолуурын үйлдвэрийг байгуулах буцалтгүй тусламжаар эхэлж 1989 оныг хүртэл монгол мэргэжилтнүүдийг Японд сургалтанд хамруулах, япон мэргэжилтэн Монголд илгээх, тоног төхөөрөмж нийлүүлэх зэрэг техникийн хамтын ажиллагаа, соёлын буцалтгүй тусламжаар хязгаарлагдаж байв. Харин манай улс ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээс хойш Монгол Японы эдийн засгийн хамтын ажиллагаа өргөн утгаар хэрэгжиж эхэлсэн. Ялангуяа манай улсын эдийн засаг хямралд орсон 1991-1993 онд Япон улсын Засгийн газрын ХАЁТ гол үүрэг гүйцэтгэж, нийгмийн шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээлийг даван туулахад үнэтэй хувь нэмэр оруулсан юм. Монгол

улсын Засгийн газар, УИХ-аас ногоон эдийн засгийг хөгжүүлэх талаар 1998 онд “Монгол улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр” (МХ-21), 2008 онд “Монгол улсыг хөгжүүлэх Үндэсний хөгжлийн цогц бодлого 2008-2021”, 2014 онд “Ногоон хөгжлийн бодлого” зэрэг баримт бичгүүдийг тус тус батлан гаргасан. Дээрх бодлогын баримт бичгүүдэд суурилсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийг УИХ-ын 19 дүгээр тогтоолоор, “Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2016-2030)”-ийг Монгол улсын Засгийн 8 <http://www.mofa.go.jp/mofaj/gaiko/oda/files/000101403.pdf> (Япон улсын Гадаад хэргийн яамны цахим хуудас) ОЛОН УЛС СУДЛАЛ 42 2017/№1 газрын 35 дугаар тогтоолоор 2016 онд тус тус батлан хөгжлийн урт хугацааны стратеги төлөвлөгөө болгон нийт 255 үйл ажиллагааг 2030 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхээр зорьж байна. “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Монгол улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно” гэсэн зорилгыг дэвшүүлж, 14 чиглэлээр хэрэгжүүлэх 44 зорилгыг тодорхойлсон. Энэ зорилгод хүрч чадсанаар: - Монгол улсын эдийн засгийн дундаж өсөлт тогтвортой 6.6%- иас доошгүй байж, - Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 17500 ам долларт хүрч, - Ядуурлын бүх төрлийг эцэс болгон, - Орлогын тэгш бус байдлыг бууруулж, нийт хүн амын 80% нь дундаж болон чинээлэг дундаж ангилалд багтаж, - Суурь болон мэргэжлийн боловсролд хамрагдалтын түвшинг 100%-д хүргэж, насан туршийн боловсролын тогтолцоо бүрдэн, - Монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцөл хангагдан, дундаж наслалт 78-д хүрч, - Хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий эхний 70 орны нэг болж, - Экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийн эхний 30 оронд багтсан, - Бизнес эрхлэлтийн түвшнээр дэлхийн эхний 40, өрсөлдөх чадварын үзүүлэлтээр дэлхийн улс орнуудаас эхний 70-д орох хөгжилтэй, - Хөгжлийн бодлогоо бүх түвшинд хэрэгжүүлэх чадвартай, авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэжсэн тогтвортой засаглал төлөвшсөн орон болно” хэмээн хүрэх үр дүнг тодорхойлжээ. Мөн 2016 оны 9 дүгээр сарын 1-нд Монгол улс Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрийг соёрхон баталж, дэлхийн 2017/№1 43 Монгол, Японы дипломат харилцаа: Гүнзгийрэл, чиг хандлага хамтын нийгэмлэгийн улс орнуудын адилаар Монгол улс уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад оруулах хувь нэмрээ /NDC/ тодорхойлсноор 2030 он гэхэд хүлэмжийн хийг 14%-иар бууруулах үүрэг хүлээгээд байна. Дээрх “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” үндэсний хөгжлийн бодлого, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад оруулах хувь нэмэр, үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд Монгол улсын Засгийн Газрын үйл ажиллагаа, хүчин чармайлтаас гадна монгол иргэн бүрийн хувь нэмэр маш чухал. Япон улсын Засгийн газраас манай улсад үзүүлэх ХАЁТийн тухай Хамтарсан протоколд 1997 онд хоёр улсын засгийн газрын тэргүүн нар гарын үсэг зурж, тусламжийн чиглэлийг 1.Аж үйлдвэрийн дэд бүтцийг хөгжүүлэх (эрчим хүч, тээвэр, холбоо), 2.Оюуны дэмжлэг үзүүлэх, зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг хангах хүний нөөцийг бэлтгэх, 3.Газар тариалан, мал аж ахуйг сэргээн хөгжүүлэх, 4.Амьжиргааны үндсэн эрэлт хэрэгцээг хангах (боловсрол, эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээ, усан хангамж) хэмээн тогтоож байсан бол Япон улсын засгийн газраас 2004 оны 11 дүгээр сард Монгол улсад үзүүлэх “Тусламжийн тусгай хөтөлбөр”- ийг баталсан нь манай улсын хөгжлийг дэмжиж ирсний бодит жишээ болсон юм. Энэхүү тусламжийн

хөтөлбөр нь 1.Зах зээлийн эдийн засгийн тогтолцоог хөхиүлэн дэмжих, боловсон хүчин бэлтгэхэд үзүүлэх тусламж; 2.Хөдөө орон нутгийг хөгжүүлэх тусламж; 3.Байгаль орчныг хамгаалахад чиглэсэн тусламж; 4.Эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн дэд бүтцийг буй болгоход үзүүлэх тусламжид чиглэгдэж, эдгээр салбарт үзүүлсэн тусламжаараа Монгол улсын эдийн засгийн өсөлтийн үр шим бүх давхаргад жигд хүртээмжтэй байх бодлогыг бодитой дэмжсэн юм. Япон улсын Засгийн газраас манай улсад үзүүлэх тусламжийн чиглэлийг 2012 онд дахин тодотгож, Тогтвортой хөгжлийн зорилт зэрэг хөгжлийн бүх бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, мөн эдийн засгийн тогтвортой өсөлт, тэнцвэртэй байдлыг хангасан эдийн засгийн өсөлтөд чиглэсэн Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр 1. Уул уурхайн тогтвортой хөгжлийг хангах, засаглалыг бэхжүүлэх, ОЛОН УЛС СУДЛАЛ 44 2017/№1 2. Бүх хүнд өгөөжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгоход чиглэсэн тусламж, 3. Улаанбаатар хотын чадавхыг бэхжүүлэх гэсэн гурван үндсэн чиглэлд ХАЁТ-аа чиглүүлж байна. Өнгөрсөн хугацаанд хоёр улсын Засгийн газарМонгол улсад үзүүлж буй тусламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хамтын ажиллагааны бодлогын зөвлөлдөх уулзалтуудыг тогтмол зохион байгуулж хамтран ажиллаж ирлээ. Япон улсын Засгийн газраас манай улсад үзүүлэх тусламжийн чиглэл, хамрах салбар, хэрэгжүүлэх хугацаа зэрэг нь хоёр орны харилцааны үндсэн баримт бичгүүд⁹, засгийн газрын хамтарсан мэдэгдлүүдэд¹⁰ тодорхой туссан байдаг. Ардчилсан тогтолцоонд шилжсэний дараа буцалтгүй тусламжийг олон улсын хандивлагч байгууллагуудтай уялдаа холбоотойгоор дэд бүтэц (цахилгаан станц, харилцаа холбоо, тээвэр), хөдөө, аж ахуйн салбар (мах боловсруулах байгууламж, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх байгууламж, үр тариа хадгалах байгууламж, хүнсний тусламж, хөдөө, аж ахуйн тоног төхөөрөмж нийлүүлэх)-т тусламж үзүүлж, зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үед монголын ард түмний ахуй амьдралд тусламж дэмжлэг үзүүлсэн. Боловсролын орчинг сайжруулах зорилгоор бага, дунд сургуулийн барилга барих 9 “Иж бүрэн түншлэлийн харилцааны баримт бичиг” 1997.02 сар, “Монгол, Японы Хамтын ажиллагааны цаашдын 10 жилийн үндсэн хөтөлбөр” 2007.02 сар, “Монгол, Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2013-2017)” 2013.09 сар, “Монгол, Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2017-2021)” 2017.03.29. 10 “Монгол, Японы Хамтарсан мэдээ” (Монгол улсын Ерөнхий сайд П.Жасрай, Япон улсын Ерөнхий сайд М.Хосокава) 1993.11.26, “Монгол, Японы Хамтарсан мэдэгдэл” (Монгол улсын Ерөнхий сайд М.Энхсайхан, Япон улсын Ерөнхий сайд Хашимото Рютаро) 1997.02 сар, “Стратегийн түншлэл байгуулахад чиглэсэн Монгол, Японы Хамтарсан мэдэгдэл” (Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Япон улсын Ерөнхий сайд Наото Кан), 2010.11.19. Токио, “Монгол улс, Япон улсын Засгийн газрын хэвлэлийн Хамтарсан мэдэгдэл” (Монгол улсын Ерөнхий сайд С.Батболд, Япон улсын Ерөнхий сайд Ё.Нода), 2012.03.12. Токио, “Стратегийн түншлэлийг бэхжүүлэх тухай Монгол улс, Япон улсын Хамтарсан мэдэгдэл” (Монгол улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг, Япон улсын Ерөнхий сайд Ш.Абэ), 2013.09.13. Токио. 2017/№1 45 Монгол, Японы дипломат харилцаа: Гүнзгийрэл, чиг хандлага буцалтгүй тусламжаар 55 сургуулийн байр, 668 анги танхим шинээр байгуулсан ба эдгээр сургуулиуд нийт 24,000 хүүхэд суралцаж байна.11 Мөн эрүүл мэнд, эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх, гал унтраах машин, хогны машин зэрэг гамшиг, эрүүл ахуйн зориулалт бүхий автомашин нийлүүлэх, япон-монголын сургалтын эмнэлэг барьж байгуулах төслүүд буцалтгүй тусламжаар хэрэгжиж, Улаанбаатар хотын нийтийн тээврийг сайжруулах, авто зам тавих, цэвэр, бохир усны шугам сүлжээг сайжруулах зэрэг төслүүдээрээ хотын иргэдэд

зайлшгүй шаардлагатай дэд бүтцийг мөн бүтээн байгуулж байна. Мөн 1990 оноос “Өвсний үндэс” буцалтгүй тусламжийн хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн ба энэ хүрээнд манай орны аймаг бүрт сургууль, эмнэлгийн барилгыг засварлах, өргөтгөх, шинээр барих зэргээр оршин суугчдын хэрэгцээг хангахад дэмжлэг үзүүлэх төслүүд хэрэгжиж ирсэн ба 2017 оны 3 дугаар сарын байдлаар нийт 504 төслийг хэрэгжүүлээд байна.¹² Сүүлийн жилүүдэд нийслэл Улаанбаатар хот дахь хүн амын төвлөрөл ихэссэний улмаас агаарын бохирдол зэрэг байгаль орчны асуудал хотын нэн тулгамдсан асуудал болсон. Энэ асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2010 оноос “Агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж, агаарын бохирдлын хэмжилтийн техник, технологийг сайжруулж, японы байгаль орчны бодлого, тогтолцоотой холбоо бүхий туршлагаасаа хуваалцан техникийн зөвлөгөө өгч байгаа нь цаг үеэ олсон тусламж болж байна. Иенийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд бага хүүтэй, урт хугацааны зээл олгож, нүүрсний уурхайн байгууламжийг засварлах, холбогдох сэлбэг хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, ДЦС-д засвар үйлчилгээг тогтмол хийх, Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг барих зэрэг дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлж байна. Мөн уул уурхайгаас хэт хамааралтай эдийн засгийн тогтолцоог өөрчилж, хувийн хэвшлийн идэвхтэй оролцоотойгоор аж үйлдвэрийн салбарыг төрөлжүүлэх зорилтыг дэмжин жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд бага хүүтэй, урт хугацаатай “ЖДҮ-ийг дэмжих, байгаль орчныг хамгаалах 2 үе 11 <http://www.mn.emb-japan.go.jp> 12 <http://www.mn.emb-japan.go.jp> ОЛОН УЛС СУДЛАЛ 46 2017/№1 шаттай зээл”-ийн төслийг (нийт дүн 8 тэрбум иен)¹³ 2005, 2010 онд хэрэгжүүлсэн. Эдгээрээс гадна манай улсад нэн шаардлагатай аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, техник, технологийн салбарын боловсон хүчинг бэлтгэх хүчин чадлыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор иенийн хөнгөлөлттэй зээлээр “Инженер, технологийн дээд боловсрол” төслийг хэрэгжүүлж, монгол залуусыг Японд сургаж байгаа бөгөөд энэ хөтөлбөрөөр боловсрол эзэмшсэн залуучууд улс орныхоо ирээдүйн хөгжилд хувь нэмрээ оруулах нь дамжиггүй. Япон улсын Засгийн газар нь Монгол улстай дипломат харилцаа тогтоосноос хойш өнөөг хүртэл олон салбарт манай улсын Засгийн газрын үйл ажиллагааг тууштай дэмжин ажиллаж, эдийн засгийн тусламж дэмжлэгийг үзүүлж ирсэн бөгөөд 2017 оны 3 дугаар сарын байдлаар нийт тусламжийн дүн 289 тэрбум 400 сая иенд хүрээд байна.¹⁴ Ийнхүү Япон улсын Засгийн газрын ХАЁТ нь манай улсын ардчилсан нийгэмд шилжих явцад тулгарсан эдийн засаг, санхүүгийн хүндрэлтэй он жилүүдэд томоохон үүргийг гүйцэтгэж, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин, дэд бүтцийн салбарт үзүүлж ирсэн тусламж нь хүн бүрт хүртээмжтэй байж, ялангуяа улс орны ирээдүйг залгамжлах боловсон хүчинг бэлтгэхэд хувь нэмрээ оруулж, Монгол улсын тогтвортой хөгжлийг дэмжин, хамтран ажиллаж ирлээ. Дүгнэлт 1. Япон улсын Засгийн газрын ХАЁТ-ийн гол үзэл санаа нь тогтвортой хөгжлийг хэрэгжүүлэхэд зайлшгүй харилцан хамааралтай байх эдийн засаг, нийгэм, байгаль орчны салбарын тэнцвэрт хөгжлийг хангахад төвлөрч ирснээрээ онцлогтой. Манай улсын Засгийн газраас хэрэгжүүлж ирсэн урт хугацааны хөгжлийн бодлого, ялангуяа тогтвортой хөгжлийн бодлогыг Япон улс нь залгамж чанартай, ирээдүйд чиглэсэн ХАЁТ-ийн бодлогоороо идэвхтэй дэмжиж, хамтран ажиллаж ирсэн. ¹³ <http://www.mn.emb-japan.go.jp> ¹⁴ <http://www.mn.emb-japan.go.jp> 2017/№1 47 Монгол, Японы дипломат харилцаа: Гүнзгийрэл, чиг хандлага 2. Япон улсын Засгийн газрын ХАЁТ нь НҮБ-аас дэвшүүлсэн “Мянганы тунхаглал”-д тогтвортой хөгжлийн зорилгод хүрэхэд хөгжиж буй оронд хөгжингүй орнуудын Засгийн газрын ХАЁТ, нэмэлт нөөц

хэрэгтэй гэсэн заалттай нийцэж, дэлхий нийтээрээ зорьж буй ногоон хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд зохих хувь нэмэр оруулсаар байна. 3. Япон улсын Засгийн газар Монгол улсад үзүүлж ирсэн тусламжийн үндсэн чиглэлийг “Монгол улсын иргэн бүр үр шимийг нь хүртэж чадах эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн” хэмээн тодорхойлж ирсэн. Энэ үзэл баримтлал нь тухайлбал, боловсролын салбарт төвлөрч, нийгмийн суурь үйлчилгээг бэхжүүлж, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын орчин нөхцлийг сайжруулах замаар хүний нөөцийг хөгжүүлэхэд чиглэж байгаа нь алсыг харсан, хөгжил дэвшилд нэн шаардлагатай, мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжгүй үнэ цэнэтэй хөрөнгө оруулалт болж байна. 4. Япон улсын Засгийн газрын ХАЁТ-ийн нэгэн хэлбэр болох иенийн хөнгөлөлттэй зээлийг Монгол улсын цаашдын хөгжилд нэн шаардлагатай, богино хугацаанд үр ашгаа өгөх, ТЭЗҮ сайтай томоохон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд ашиглах боломж бий. 5. Дэлхий нийтэд ногоон хөгжлийн шилдэг тушлага хэмээн хүлээн зөвшөөрөгдөж, түгэн дэлгэрч буй Японы ногоон хөгжлийн стратегийг судлан, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд тусган нутагшуулах талаар санаачлагатай ажиллаж, Япон улстай энэ чиглэлийн хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэх өргөн боломжтой. ОЛОН УЛС СУДЛАЛ 48 2017/№1 Ном зүй 1. УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралт “Ногоон хөгжлийн бодлого” 2. УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолын хавсралт “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” 3. Монгол улсын Засгийн газрын 2016 оны 35 дугаар тогтоолын хавсралт “Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2016-2030)” 4. Ред. Ц.Баатар “Японы хөрөнгө оруулалт, зээл тусламж, түүний үр ашиг” УБ.2004 5. “Ногоон хөгжлийн бодлого” УБ., 2015 6. “Тогтвортой хөгжлийн боловсрол” УБ. 2004 7. “Монгол улсын ногоон эдийн засгийн төлөв байдлын судалгаа” 2014. 8. “Эдийн засгийн гол салбаруудыг ногоон эдийн засагт шилжүүлэх боломж, үндэслэлийн судалгаа” ТЭЗУС, “Ногоон Хөгжил” зөвлөх баг УБ., 2012.10.31 9. “Стратегийн түншлэл ба Монгол улсын гадаад орчны өөрчлөлт” УБ., 2015 10. “Олон улсын харилцаа” сэтгүүл, УБ., 2015 №1/435 11. 『平成 26 年版 環境白書－我が国が歩むグリーン経済の道』 (Хэйсэйгийн 26 оны хэвлэл “Байгаль орчны цагаан ном -Манай улсын ногоон эдийн засгийн замнал-”)環境省編、2014年 12. 『2015年版 開発協力白書』 (“2015 оны хэвлэл Хөгжлийн хамтын ажиллагааны Цагаан ном”) 外務省、2015 13. http://www.mofa.go.jp/mofaj/gaiko/oda/shiryo/hakusyo/14_hakusho_pdf/index.html 14. <http://www.mn.emb-japan.go.jp> 15. <http://www.un.org/en/sections/what-we-do/promote-sustainabledevelopment/index.html> 16. “Иж бүрэн түншлэлийн харилцааны баримт бичиг”, Токио, 1997 оны 2 дугаар сар. 2017/№1 49 Монгол, Японы дипломат харилцаа: Гүнзгийрэл, чиг хандлага 17. “Монгол, Японы Хамтын ажиллагааны цаашдын 10 жилийн үндсэн хөтөлбөр” 2007.02. 18. “Монгол, Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2013-2017)” 2013.09 сар 19. “Монгол, Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2017-2021)” 2017.03.29. Токио. 20. “Монгол, Японы Хамтарсан мэдэгдэл” (Монгол улсын Ерөнхий сайд М.Энхсайхан, Япон улсын Ерөнхий сайд Хашимото Рютаро) 1997.02. 21. “Стратегийн түншлэл байгуулахад чиглэсэн Монгол, Японы Хамтарсан мэдэгдэл” (Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Япон улсын Ерөнхий сайд Наото Кан), 2010.11.19. Токио, 22. “Монгол улс, Япон улсын Засгийн Газрын хэвлэлийн Хамтарсан мэдэгдэл” (Монгол улсын Ерөнхий сайд С.Батболд, Япон улсын Ерөнхий сайд Ё.Нода), 23. “Стратегийн түншлэлийг бэхжүүлэх тухай Монгол улс, Япон улсын Хамтарсан мэдэгдэл” (Монгол улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг, Япон улсын Ерөнхий сайд Ш.Абэ), 2013.09.13. Токио.

МОНГОЛ ЯПОНЫ СОЁЛЫН ХАРИЛЦААНЫ ХЭЛЭЛЦЭЭР, ТҮҮНИЙ ТҮҮХЭН АЧ ХОЛБОГДОЛ

Б.Сэржав, ШУА-ийн ОУХХ-ийн ЭШТА, доктор (Ph.D).

Хураангуй: Энэ өгүүлэлд Япон улстай соёлын харилцааны хэлэлцээр байгуулсан түүх, нөлөөлсөн зарим хүчин зүйл, хамтын ажиллагааны эхлэл, өрнөл, түүний ач холбогдлын талаар хөндөн авч үзэхийг зорив. Соёлын харилцааны хэлэлцээрийн хүрээнд, Япон улстай хөгжүүлж ирсэн хамтын ажиллагаа нь хоёр ард түмний хооронд харилцан ойлголцол гүнзгийрэх, бүх салбарын найрсаг хамтын ажиллагаа хөгжихөд ихээхэн ач холбогдол үзүүлж, улмаар Монгол Японы харилцаа өнөөг хүртэл өргөжин тэлэх чухал суурь нөхцөлийн нэг байсаар ирсэн, цаашид ч энэ учир холбогдол буурахгүй хэмээн бодно.

Түлхүүр үг: Монгол Японы харилцаа, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр, ард түмний бие биеэ танин мэдэх явдал, харилцан ойлголцол, итгэлцэл

Монгол, Японы дипломатчдын нөр их хүчин зүтгэлийн үр дүнд 1972 оны 2 дугаар сарын 24-нд Монгол Улс, Япон улсын хооронд дипломат харилцаа байгуулсан билээ. Хоёр улсын харилцаанд түүхэн эргэлтийг авч ирсэн энэ үйл явдал нь тус хоёр орны бүх талын харилцаа, хамтын ажиллагаа өргөжин хөгжих таатай боломжийг нээж, тэр дундаа энд өгүүлэх гэж буй Соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулагдаж хэрэгжих суурь нөхцөлийг бүрдүүлсэн юм. Монгол Улс Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосноос хоёрхон жилийн дараа хоёр орны Соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулагдаад, энэ 2019 он хүртэл тус салбарын хамтын ажиллагаа 45 жилийн түүхийг бүтээн хөгжиж ирлээ. Энэ өгүүлэлд Япон улстай соёлын харилцааны хэлэлцээр байгуулсан түүх, нөлөөлсөн зарим хүчин зүйл, хамтын ажиллагааны эхлэл, өрнөл, түүний ач холбогдлын талаар хөндөн авч үзэхийг зорив.

Дипломат харилцаа тогтоосны дараа хоёр тал боломжтой бүх хэлбэрийн хамтын ажиллагааг хөгжүүлэхээр хүчин чармайлт гаргаж ажилласны дотор соёлын салбарын хамтын ажиллагаа чухал байр эзэлж байжээ. Соёлын харилцааны тухай хэлэлцээрийн төслийг 1972 оноос боловсруулж эхэлсэн талаар Монгол улсын анхны Элчин сайд С.Дамбадаржаа дурдсан¹⁵ нь бий. Япон Улсаас манай улсад суух анхны Элчин сайд К.Нийсэки 1972 оны 8 дугаар сарын 25-нд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн нэгдүгээр орлогч дарга С.Лувсанд Итгэмжлэх жуух бичгээ барьж, тус

¹⁵ С.Дамбадаржаа Соёлын харилцааны 25 жил “Ниппон ньюс” сонин, 1999 оны 8, 9-р сар, № 6,7 /18,19/

Элчин сайд болон манай талын албаны хүмүүсийн уулзалт болж, хоёр орны харилцааны талаар санал солилцжээ. Энэ үеэр хоёр орны хамтын ажиллагааг эрхлэх байгууллага байгуулах, худалдааны хэлэлцээр, соёл, шинжлэх ухаан-техникийн хэлэлцээр, шуудан цахилгаан холбоо, залуучуудыг солилцох хэлэлцээрүүдийг байгуулах... тухай саналыг манай талаас Элчин сайдад мэдэгдэж байжээ¹⁶.

Хоёр орны хооронд соёл, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх чиг шугамыг тохиролцох саналыг тусгасан Засгийн газрын ноот бичгийг Элчин сайд С.Дамбадаржаа 1974 оны хоёрдугаар сард Японы Гадаад Явдлын Яамны орлогч сайд С.Хоогэн-д гардуулсан тухайгаа “...тэдгээр саналуудын нэгэн зүйл нь соёл, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлаар хоёр Засгийн газрын төлөөлөгчид хэлэлцээ хийх тухай санал байв. Японы Засгийн газар манай саналыг зөвшөөрч, соёлын харилцааны хэлэлцээр байгуулах саналыг тэр жилийнхээ долдугаар сард тавьсан юм”¹⁷ хэмээн өгүүлсэн байдаг.

Түүнчлэн Япон Улсаас БНМАУ-д суугаа Элчин сайд Цүгэ Итарү 1974 оны 2 дугаар сард манай улсын ГЯЯ-ны орлогч сайд Д.Эрдэмбилэгт Соёлын хэлэлцээр байгуулах тухай Японы талын төслийг /ноотын хэлбэрээр/ гардуулжээ¹⁸. Энэ үеэс хоёр Засгийн газрын хооронд соёлын хэлэлцээр байгуулах яриа хэлэлцээ идэвхжиж, хоёр талаас нэг бус удаа төсөл боловсруулан хэлэлцсэн протокол Гадаад харилцааны төв архивт хадгалагдаж байна.

Японы Засгийн газрын ноотыг 1974 оны 7 дугаар сарын 8-нд Японы Гадаад явдлын Яамны Азийн товчооны дарга М.Такашима Элчин сайд С.Дамбадаржаад гардуулж, Соёл, шинжлэх ухаан-техникийн харилцаа хөгжүүлэх тухай Монголын талын саналыг зөвшөөрч байгаагаа илэрхийлээд “Юуны өмнө соёлын харилцааны хэлэлцээр байгуулъя. Энэ нь шинжлэх ухаан-техникийн харилцаанд туслах болно”¹⁹ хэмээн тайлбарласан байдаг.

Хоёр орны хооронд соёлын салбарын хамтын ажиллагаа хөгжүүлэх хэлэлцээр байгуулж, БНМАУ-ын Гадаад явдлын яамны хэлтсийн дарга Д.Цэрэндорж, Япон улсаас Монгол улсад суугаа Элчин сайд Цүгэ Итарү нар Улаанбаатар хотноо “БНМАУ Япон

¹⁶ Монгол Улсын Гадаад харилцааны төв архив, 119-1-1337

¹⁷ С.Дамбадаржаа Соёлын харилцааны 25 жил, “Ниппон ньюс” сонин, 1999 оны 8, 9-р сар, № 6,7 /18,19/

¹⁸ Монгол Японы харилцаа Эрт, эдүгээ, Интерпресс хэвлэлийн газар, УБ., 2001, 323-р тал

¹⁹ Л.Дашпүрэв Япон улсын эдийн засгийн дипломат үйл ажиллагаа ба Монгол Улс /1970-80-аад он/ диссертаци зохиол, УБ., 2014, 90-р тал

Улсын Засгийн газрын хооронд соёлын харилцаа тогтоосон тухай ноот бичиг”-ийг 1974 оны 9-р сарын 23-нд солилцжээ²⁰.

Тухайн үед Хэлэлцээр нь Парламентаар батлагддаг учир хугацаа шаарддаг, харин ноот бичиг солилцох шийдвэрийг Засгийн газар шуурхай гаргаж болдог нөхцөлийг харгалзан ноот бичиг солилцох хэлбэрийг хоёр тал сонгож авч байжээ.

Харилцан солилцсон адил утга бүхий ноот бичигт:

-Шинжлэх ухаан-техник, соёл урлаг, спортын байгууллагын төлөөлөгчид, мэргэжилтэн, аспирант оюутан болон дээрх салбарт ажиллаж буй хүмүүсийг харилцан солилцох;

-Кино урлаг, урлагийн тоглолт, лекц, уран бүтээл, гэрэл зургийн үзэсгэлэн зэрэг соёлын арга хэмжээг зохиох;

-Эрдэм шинжилгээний ажил хамтран хийхэд дөхөм үзүүлэх;

-Үзүүлэн таниулах, сонсох материал солилцох;

-Албан ёсны хэвлэл, мэдээллийн материал солилцох;

-Эрдэм шинжилгээний ажилд зориулсан хэвлэл, мэдээллийн материал солилцох зэрэг хамтын ажиллагаа хэрэгжүүлэхээр тусгажээ²¹.

Манай улс Япон улстай дипломат харилцаа тогтоосноос хоёр жилийн дараа ийнхүү соёлын хамтын ажиллагаа эхэлсэн түүхтэй. Энэ Хэлэлцээрийн хэрэгжилт нь хоёр орны хоорондын шинэ тутам хамтын ажиллагааг соёл шинжлэх ухаан, урлаг спортын зэрэг олон салбарт өргөтгөн хөгжүүлэх, монгол японы ард түмэн бие биеийг танин мэдэх, харилцан ойлголцлыг бий болгоход чухал ач холбогдолтой болсон юм. Улмаар энэ үйл явдал ХХ зуунд дэлхий дахин улс төр, үзэл суртлын хоёр системд хуваагдсан болон Зүүн хойт Азийн олон улсын харилцааны таагүй уур амьсгал, дайны уршгаар хоёр ард түмний дунд үлдэж хоцорсон бие биеийн талаарх сөрөг ойлголт хандлагыг өөрчлөх, найрсаг уур амьсгалыг бүрдүүлж батжуулахад гол үүрэг гүйцэтгэсэн хүчин зүйлийн нэг байсан юм. Энд хоёр зүйл цохон тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Нэгд, Манай улс 1970, 80-аад онд дипломат харилцаа тогтоосон, өнөөгийн гуравдагч хөрш орнуудтай соёлын харилцаа байгуулсан цөөн жишээг он цагаар авч үзвэл,

²⁰ Монгол Улсын Гадаад харилцааны төв архив, 119-1-1337, х.63

²¹ Монгол Улсын Гадаад харилцааны төв архив, 119-1-1337, х.1-2

- ХБНГУ-тай 1974.01.31-нд дипломат харилцаа тогтоосон бол Соёлын хамтын ажиллагааны хэлэлцээрийг 1986 онд байгуулсан /1988 онд соёлын хамтын ажиллагааны Протокол байгуулсан/.

- АНУ-тай 1987.01.27-нд дипломат харилцаа тогтоосон бол Боловсрол соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах “GLOBE хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллах Монгол АНУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 1997.05.06-нд байгуулжээ.

- Их Британи-тай 1963.05.20-нд дипломат харилцаа тогтоосон бол “Боловсрол, шинжлэх ухаан, соёлын салбарт хамтран ажиллах Монгол, Их Британийн Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 1996 онд байгуулж байжээ.

Эндээс тухайн үеийн капиталист орнууд буюу өнөөгийн гуравдагч хөршүүдтэй харьцуулахад Япон улстай соёлын хамтын ажиллагааны Хэлэлцээрийг харьцангуй богино хугацаанд байгуулсан нь харагдана. Энэ нь тухайн Хэлэлцээрийг байгуулж хэрэгжүүлэхэд хоёр тал хүчин чармайлт гаргаж идэвхитэй ажилласан, ингэх шаардлага, эрэлт хэрэгцээ аль алинд нь байсныг илтгэн харуулах баримт гэж бодож байна.

Хоёрт, Соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулахад түлхэц үзүүлсэн хүчин зүйлийн хувьд японы талын эрдэмтэн судлаачид, зохиолчдын нөлөө санаачлага хүчтэй байжээ. Япон улсын хувьд, өнгөрсөн дайны үр дагавар нь судалгаа шинжилгээний ажилд цоо шинэ нөхцөл үүсгэсэн талаар японы эрдэмтэд тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, монгол судлаач япон эрдэмтэд судалгааны ажлын талбаргүй болж, БНМАУ, Өвөр Монголд очиж ажиллах боломжоо алджээ. Энэ нь монгол судлалыг судалгааны объектоос салангид байдлаар эхлүүлэхээс өөр аргагүйд хүргэжээ. Монголын талаарх эрдэм шинжилгээний ажилд сурвалж бичгийн судалгаа, хэл шинжлэлийн чиглэл голлох болсон юм. “Түүхийн судлалын хувьд Японтой холбоотой сэдэв хөндөгдөх учир шинэ, шинэхэн үеийн түүхийн судалгаанаас зайлсхийх хандлага илэрч, Монголын эзэнт гүрэн, Юан улсын холбоотой судалгаа зонхилох болжээ”²², “Тэр ч байтугай дайнаас өмнө газар дээр нь ажиллаж цуглуулсан материал, судалгаа нь японы олон нийтэд дайнд ялагдсан “ялагдлын шалтгаан” болсон мэтээр ойлголт төрөхөд хүргэж байжээ...”²³.

²² Баба Кимихико Дайны дараах япончуудын Монголын тухай дүрслэл –Геополитикийн сонирхлоос уран зохиолын дүрслэл рүү- , “Монгол Японы харилцаа: өнгөрсөн ба эдүгээ (XX зуун)” эмхэтгэл, Бэмби сан хэвлэлийн компани, УБ., 2011, 158-р тал

²³ Мөн тэнд

Ийм байдлын улмаас судалгаа шинжилгээний ажлыг газар дээр нь хийх зайлшгүй шаардлага урган гарсан нь хоёр улсын албан ёсны гэрээ хэлэлцээр байгуулахад хүчин түлхэц үзүүлсэн гэж хэлж болох юм. Соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулагдахад эрдэмтэн судлаачдын зэрэгцээ зохиолчид, соёлын зүтгэлтэн нарын санаачлага, хүчин зүтгэл ч нөлөөлсөн нь харагддаг. Тухайлбал, Японы нэрт зураач, энх тайвны шагналт Маруки Ири, Акамацү Тошино нарын зургийн үзэсгэлэн 1956, 1966 онд Улаанбаатарт нээгдсэн, Японы нэрт монголч эрдэмтэд Абэмацү Гэничи, Сакамото Корэтада, Озава Шигэо нар 1959 онд хуралдсан Олон улсын Монгол хэлбичгийн эрдэмтдийн анхдугаар их хуралд оролцсон зэрэг үйл явдлууд болж байжээ. Түүнчлэн Японд манай улсын талаар судалгааны ажил идэвхжиж Сакамото Корэтада “Бүгд Найрамдах Монгол Ард Улс” /1955/, “Монголын улс төр, эдийн засаг” /1969/, Мацүно Танио “Мартагдсан улс” /1958/, “Сэкай шёочёо /Гадаад Монгол шинэ замаар урагшилж байна” сэтгүүл /1957/ гэх зэрэг судалгаа сурталчилгааны ном бүтээл нийтлэгдэж, NHK, Фүжи телевизүүд Монголын тухай өргөн нэвтрүүлэг цацаж, хэвлэл мэдээллийн томоохон компаниудын сурвалжлагч зураглаачид манай улсад ажиллаж, японы олон нийтэд мэдээлэл түгээж эхэлсэн юм.

Монгол Улстай харилцаа тогтоон хөгжүүлэх зорилго бүхий нийгэмлэг, олон нийтийн байгууллагууд ч үүсэн үйл ажиллагаа нь жигдэрч ирсэн байна. Тухайлбал, Япон Монголын нийгэмлэг 1959 онд байгуулагдаж, нийгэмлэгийн тогтмол хэвлэл “Найрамдал” сэтгүүл гарган, манай улсыг японы олон нийтэд сурталчилж эхэлжээ. Япон Монголын найрамдлын нийгэмлэг 1968 онд /хэвлэл нь “Япон ба Монгол” сэтгүүл/, Японы Монгол судлалын нийгэмлэг 1971 онд /хэвлэл нь “Монгол судлал” сэтгүүл/ тус тус байгуулагдан хоёр талын найрсаг харилцааг хөгжүүлэх чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулж, хүмүүнлэг, соёл урлаг, эрдэм шинжилгээний салбарт хамтын ажиллагаа эхлүүлэх талаар цөөнгүй алхам хийж иржээ. Мөн Японы Үйлдвэрчний эвлэл СОХИО-гийн төлөөлөгчид 1969 онд манай улсад айлчлах үед төлөөлөгчдийн гишүүдээс хоёр орны соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хооронд харилцаа холбоо тогтоож хөгжүүлэхийн чухлыг тэмдэглэж байв.

1970 оны 9 дүгээр сард Улаанбаатарт болсон Олон улсын монголч эрдэмтдийн II их хуралд Японы нэрт монголч эрдэмтэд Абэмацү Гэничи, Мураками Масацүгү, Озава Шигэо, Хаттори Широ нар оролцож, Монгол Улсын ШУА-тай хамтран ажиллах, эрдэм

шинжилгээний байгууллагууд, эрдэмтэдтэй холбоо тогтоох, манай улсад судалгаа хийх тухай санал тавьж, ШУА-д хүсэлт гаргаж байжээ²⁴.

Эдгээр үйл ажиллагаа нь зөвхөн соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр төдий бус хоёр орны дипломат харилцаа байгуулагдахад ч чухал нөлөө үзүүлсэн юм.

Энд тэмдэглэхэд, Монгол Япон хоёр орны ард түмэн өнгөрсөн зууны 70-аад он хүртэл бие биеийг танин мэдэх талаар учир дутагдалтай, сүүдэртэй талаас товойлгон үзэх хандлагатай, харилцаа холбоо эхлэлийн төдий, манай улсын хувьд Японтой харилцах гол гүүр нь ерөнхийдөө Монголын Энх тайвны Хороо, Улаан загалмай нийгэмлэгийн үйл ажиллагаа байсан юм. Чухам ийм үед Соёлын харилцааны хэлэлцээр нь хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны дараа харилцааг шинэ үеийн шинэ байдалд зохицуулан шат ахиулж хөгжүүлэх, хоёр ард түмний бие биеэ танин мэдэх хэмжээг дээшлүүлэх, харилцан итгэлцэх уур амьсгал бий болгох эрх зүйн шинэ үндсийг бүрдүүлж өгсөн юм.

Соёлын хэлэлцээр байгуулагдсаны дараа, 1974 оноос хоёр орны хооронд жил бүрийн хамтын ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлж, харилцаа, хамтын ажиллагааны хүрээ өргөжин тэлж иржээ. Соёлын хэлэлцээрийн дагуу монгол, япон багш, оюутан, аспирант, судлаачдыг хоёр талдаа тогтмол хүлээн авдаг болж, соёл урлагийн салбарт ч хамтын ажиллагаа идэвхжин, Японы дуу бүжгийн хэсэг 1974 онд Улаанбаатарт тоглолт хийж, Монголын Ардын дуу бүжгийн чуулгын хэсэг 1978, 1984 онд Токиод болсон Азийн болон Японы ардын урлагийн наадамд оролцжээ. Хоёр орны сонгодог бүжгийн жүжигчид ч хэд хэдэн удаа харилцан тоглолт хийх зэргээр хамтын ажиллагаа солилцоо өргөжиж, урлаг спортынхон, эрдэмтэд судлаачид, соёлын зүтгэлтэн, сурвалжлагчдын харилцан үйл ажиллагаа тогтмолжиж уламжлал болсон билээ. “Хоёр орны иргэд бие биеэ танин мэдэх, ойлгох нь харилцааны хөгжилд чухал ач холбогдолтойг харгалзан хүн солилцоо, харилцан айлчлалыг аль болох өсгөхөд хоёр тал, ялангуяа японы тал ихээхэн анхаарч байсан юм”²⁵.

Хэлэлцээрийн агуулгад тусгагдсан эрдэм шинжилгээ судалгааны ажлыг хамтран хэрэгжүүлэх заалтын дагуу Японы Монгол судлалын нийгэмлэгийн шугамаар 1975-1977 онд гурван жил дараалан жил бүр 20-иод хоногийн хугацаатай Монголыг судлах эрдэм шинжилгээний экспедицийг илгээн Монголын түүх, хэл шинжлэл, мал аж ахуй, газар

²⁴ Олон улсын монголч эрдэмтдийн II их хурлын материал.

²⁵ Ц.Батбаяр. Монгол ба Япон XX зуунд, Бемби сан хэвлэлтийн газар, УБ., 2012, 181-р тал

тариалан зэрэг чиглэлээр судалгаа явуулсан нь япон эрдэмтдийн манай улс дахь судалгаа шинжилгээний анхны томоохон ажил байсан юм. Экспедицийн бүрэлдэхүүнд Ивамура Шинобү, Озава Шигэо, Накаэ Тошитака, Хагивара Жюмпэй, Миаки Такэши, Нагахори Кинзо, Танака Кацүхико, Хасүми Харуо нарын нэртэй томоохон эрдэмтэд, профессорууд оролцож, өргөн хүрээтэй судалгаа явуулжээ. Судалгааны явцад Монгол улсын ШУА-ийн Түүх, Хэл зохиолын хүрээлэн, Хөдөө аж ахуйн яам, Хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй танилцан, уулзалт ярилцлага хийж, эрдэмтэн Ш.Ивамура “Япон дахь Монгол судлалын сүүлийн үеийн ололт амжилтаас”, Ж.Хагивара “Мингийн үеийн Монгол Хятадын харилцаа” зэрэг сэдвээр илтгэл хэлэлцүүлж байжээ. Эрдэмтэн К.Нагахори, Т.Накаэ, Т.Миаки нар Зүүнхараа, Хархорины сангийн аж ахуй, Өмнөговь аймгийн Булган сум зэрэг газруудаар явж, малчид тариаланчдын ахуй амьдрал, бэлчээрийн мал аж ахуйн байдал, малын ашиг шим, сүү цагаан идээ боловсруулах уламжлалт арга технологи, газар ашиглалт, бэлчээрийн өвс ургамлын бүтэц зэрэг өргөн агуулгатай ажиглалт судалгаа явуулж, зарим цагаан идээнд химийн шинжилгээ хийж үзэж байжээ.

Энэхүү гурван удаагийн экспедиц нь судалгааны ололтоос гадна монгол японы эрдэмтдийн хооронд харилцаа холбоо тогтоох, шинжлэх ухааны байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хоёр орны эрдэмтэд судалгааны арга зүйтэй харилцан танилцахад чухал ач холбогдолтой болжээ. Уг судалгааны үр дүнг хэлэлцэх эрдэм шинжилгээний хурлыг Японы Окаяма их сургууль дээр 1979 оны 2 дугаар сарын 3-нд зохион байгуулж, Монгол судлалын экспедицийн эрдэм шинжилгээний ач холбогдлыг дүгнэн, Япон дахь Монгол судлалын ажлын цаашдын чиг хандлагыг тогтоох талаар нухацтай ярилцсан, судалгааны ажилд Монгол улсын засгийн газрын байгууллагууд, Орон нутгийн засаг захиргааны зүгээс халуун дэмжлэг туслалцаа үзүүлж, найрсаг хандаж байсан²⁶ зэргийг экспедицийн тайланд дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг.

Нөгөө талаар, Соёлын хэлэлцээр байгуулахад манай улсын зүгээс баримталж байсан эхний чиг шугам бол соёл, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Хэлэлцээр байгуулахыг зорьж, яриа хэлэлцээний үеэр тэмдэглэсээр ирсэн байдаг. Харин хэлэлцээр байгуулах сүүлчийн тохиролцоог Соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр байхаар тогтсон байдаг нь анхаарал татдаг юм. Хэрэв тухайн үед “Соёл, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр” нэртэйгээр байгуулагдаж, шинжлэх ухаан

²⁶ 『モンゴル研究』/Монгол судлал/ сэтгүүд, № 11, 1980, 1-10-р тал

техникийн хамтын ажиллагаанд илүү ач холбогдол өгч хэрэгжүүлсэн бол үр дүн нь ямар байх байсан, цаашилбал, манай улс саналаа сулруулахад нөлөөлөх гадаад дотоодын ямар нэг зүйл байсан уу, эсвэл Япон улсын зүгээс Монгол улстай энэ салбарын хамтын ажиллагаа хэрэгжүүлэхийг хойш тавих шалтгаан байсан уу гэдэг асуудлыг нарийвчлан тодруулуштай гэж үзэж байна.

Монгол Японы соёлын харилцааны хэлэлцээр нь байгуулагдсан цагаас хоёр талын дэмжлэгийг хүлээж, олон салбарт хэрэгжиж эдүгээг хүрсэн билээ. Тухайлбал соёлын хэлэлцээрийн хэрэгжилт боловсрол, шинжлэх ухаан, соёл урлаг, утга зохиол, спорт аялал жуулчлалын салбар, цаашилбал, найрамдлын нийгэмлэг, олон нийтийн байгууллагууд, хувь хүмүүсээр дамжин өргөжин тэлж, хэлбэр агуулга нь улам баяжин, төрөл бүрийн шугамаар хүмүүнлэг солилцоо идэвхжиж хоёр ард түмний найрсаг хамтын ажиллагаа хөгжих, харилцан ойлголцол гүнзгийрэх, чухал суурь нөхцөлийн нэг байсаар улмаар өнгөрсөн зууны 90-ээд онд манай улсад эдийн засаг, нийгмийн өөрчлөлт, гадаад бодлогын цоо шинэ нөхцөл бий болж, Япон улстай харилцах харилцаа шинэ дээд шатанд бүх талаар өргөжин тэлэх түүхэн эргэлтийн цаг үетэй золгосон юм.

Өнөөг хүртэл Соёлын салбарын хамтын ажиллагаа тус хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны хөгжил дэвшилтэй уялдан улам өргөжиж, агуулга цар хүрээгээ тэлж гүнзгийрсээр ирлээ. Сүүлийн жилүүдэд “хоёр орны хооронд иргэд, хүүхэд залуучуудын солилцоо, боловсрол, судалгаа шинжилгээний болон сэтгүүл зүйн салбарын хамтын ажиллагаа шинэ түвшинд дэвшиж, ялангуяа Монгол улсын суурь бүрэн дунд боловсролын орчинг сайжруулах, манай улсын хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр хамтын ажиллагаа өргөжин тэлж байгааг”²⁷-г “Монгол Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2017-2021)”-т дүгнэн тэмдэглэжээ.

Монгол Японы харилцаа 1990 оноос шинэ шатанд дэвшиж, улмаар Иж бүрэн түншлэлийн харилцаа, Стратегийн түншлэлийн харилцаа, 1915 оноос Эдийн засгийн түншлэлийн хамтын ажиллагааны шатанд хүрч хөгжиж байна. Одоо хэрэгжиж буй “Монгол Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2017-2021)” –т хоёр орны харилцааг 3 чиглэлээр голлон хөгжүүлэхээр заасны нэг нь “Соёл, иргэд хоорондын харилцаа, хамтын ажиллагаа” байхаар тусгасан юм. Энэ хөтөлбөрт хоёр улсын засгийн газар хүүхэд залуучуудын харилцааг гүнзгийрүүлэх, хоёр улсын түүх, соёл, соёлын өв

²⁷ Монгол Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2017-2021), <https://www.mofa.go.jp/files/000241983.pdf>

болон улс төр, эдийн засаг, нийгмийн байдлыг хоёр улсын ард түмэнд таниулан сурталчлах, судлаач сэтгүүлчдийг харилцан солилцох, боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбар дахь хүний нөөцийн солилцоог хөгжүүлэх, шинжлэх ухаан, техник технологи, соёл урлагийн салбарын хамтын ажиллагааг дэмжих бодлого баримтлах²⁸ - аар заасан билээ.

Хоёр орны харилцаа өндөр дээд шатанд дэвшиж, Эдийн засгийн түншлэлийн харилцааны шатанд хүрээд буй өнөөгийн нөхцөлд ч хоёр ард түмний харилцан ойлголцол, бие биеийг танин мэдэх явдлыг гүнзгийрүүлж, харилцан итгэлцлийг улам дээшлүүлэх зорилт тавигдаж байгаа, цаашид энэ зорилт байсаар байх болно. Тийм ч учраас хоёр талын харилцаанд анхаарч анзаарч байвал зохих асуудал, өөрөөр хэлбэл энд өгүүлж буй бие биеийг танин мэдэх явдлыг гүнзгийрүүлэх, харилцан ойлголцлыг нэмэгдүүлэхэд соёлын харилцааны учир холбогдол оршино гэж бодож байна.

Эцэст нь Япон улстай Соёлын харилцааны Хэлэлцээр байгуулсан нь, хоёр ард түмний хооронд харилцан ойлголцол гүнзгийрэх, найрсаг хамтын ажиллагаа хөгжих үндсийг тавьж, улмаар Монгол Японы харилцаа өнөөг хүртэл өргөжин тэлэх чухал суурь нөхцөлийн нэг байсаар ирсэнд түүний түүхэн ач холбогдол оршино. Цаашид ч энэ учир холбогдол буурахгүй хэмээн үзэж байна.

Agreement between Mongolia and Japan for cultural relation, its historical significance

B.Serjav.

Leading researcher, PhD, Institute of International Affairs, MAS, Mongolia,

E-mail: serjavb@mas.ac.mn

Abstract. In this article, we aimed to discuss history of establishing an agreement on cultural cooperation between Mongolia and Japan, some factors affected on it, commencement and progress of cooperation, and implementation outcomes. Within framework of the agreement, the relationship developed with Japan have been high importance to the deepening of mutual-understanding and developing of friendship at all sectors, and moreover, we assume that it has been one of the important basis to the expansion of Mongolian–Japanese relationships up to date, and would still continue to inspire in further.

Keyword: Mongolian-Japanese relations, cultural cooperation agreement, creation and development of public mutual-understanding and trust.

²⁸ Мөн тэнд

Ашигласан материал:

1. Монгол Улсын Гадаад харилцааны төв архив, 119-1-1337
2. Олон Улсын Монголч эрдэмтдийн их хурлуудын материал
3. Монгол Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2017-2021), <https://www.mofa.go.jp/files/000241983.pdf>
4. Ц.Батбаяр. Монгол ба Япон XX зуунд, Бемби сан хэвлэлийн газар, УБ., 2012
5. С.Дамбадаржаа. Соёлын харилцааны 25 жил “Ниппон ньюс” сонин, 1999 оны 8, 9-р сар, № 6,7 /18,19/
6. Монгол Японы харилцаа Эрт, эдүгээ, Интерпресс хэвлэлийн газар, УБ., 2001
7. Баба Кимихико. Дайны дараах япончуудын Монголын тухай дүрслэл –Геополитикийн сонирхлоос уран зохиолын дүрслэл рүү-, “Монгол Японы харилцаа: өнгөрсөн ба эдүгээ (XX зуун)” эмхэтгэл, Бэмби сан хэвлэлийн компани, УБ., 2011, 158-р тал
8. 『モンゴル研究』 /Монгол судлал/” сэтгүүл, № 11, 1980, 1-10-р тал
9. Б.Сэржав. Монгол Японы харилцаа: XX зууны сүүлийн хагаст, Өргөө хэвлэлийн газар, УБ., 2003
10. Л.Дашпүрэв. Япон улсын эдийн засгийн дипломат үйл ажиллагаа ба Монгол Улс /1970-80-аад он/ диссертаци зохиол, УБ., 2014

АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ГЕОПОЛИТИКИЙН ОНЦЛОГ

Б.Цэнгэлхам, ОУХХ-ийн ЭША, доктор (Ph.D)

XXI зуун гарсаар дэлхий дахинд даяаршил улам бүр тэлж, шинжлэх ухаан, мэдээллийн технологи үсрэнгүй хөгжин, улс төр, эдийн засгийн интеграци өргөжиж, улс хоорондын харилцан хамаарал гүнзгийрч байна. Олон улсын харилцаа өнгөрсөн зууны сүүлийн хагасын “хүйтэн дайн”-ы хоёр туйлт үеийнхээс олон туйлт харилцааны шинэ үед шилжин эрс өөрчлөгдлөө. Хөгжил, хамтын ажиллагааны шинэ томоохон төвүүд тодорч, тэдгээрийн хүрээн дэх харилцаа, хамтын ажиллагааны шинэ механизм бий болж, түүний олон улсын харилцааны ерөнхий үйл явцад үзүүлэх нөлөө өсөх болов.

Өнөө үед бүс нутгийн улс гүрнүүд хооронд олон талт яриа хэлцэл өрнөж, Европын Холбоо, АПЕК (APEC), АСЕМ (ASEM), АСЕАН (ASEAN), Их 20 (G20), БРИКС (BRICS) зэрэг засгийн газар хоорондын хамтын ажиллагааны олон талт механизмууд идэвхитэй ажиллаж байна.

Монгол Улсын тухайд, 1994 оны Гадаад бодлогын үзэл баримтлалд “*Монгол Улсын гадаад бодлогын гурав дахь чиглэл бол Азийн бүс нутагт байр сууриа бататгаж, эндхийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох явдал мөн... Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (АПЕК)-д элсэн орохыг зорино. Бүс нутгийн интеграцид орох нөхцлийг юуны өмнө түүнд хамаарч буй улс орнуудтай хоёр талын харилцааг өргөтгөн хөгжүүлэх замаар бүрдүүлнэ*”²⁹ гэж зааж өгсөн байдаг. Гэвч гадаад бодлогын энэхүү томоохон зорилт амжилттай хэрэгжиж чадалгүй өнөөг хүрэв. Харин цаашид Монгол Улс энэхүү байгууллагад гишүүнээр элсэх асуудалдаа *хоёр талын болон олон талт хэлбэрээр* АПЕК-д чухал байр суурь эзэлдэг АСЕАН-ны гишүүн орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх замаар дам таатай орчинг бий болгох бүрэн боломжтой гэдгийг энэхүү судалгаанд үндэслэн тайлбарлах боломж бүрдэж байна.

Ази, Номхон далайн бүс нутгийн онцлог: Сүүлийн жилүүдэд Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын хамтын ажиллагаа түргэн хурдацтай хөгжиж, дэлхийн улс төрийн бодлого, үйл явцад тэдгээрийн үзүүлэх жин нөлөө мэдэгдэхүйц өсөн нэмэгдэх болжээ. Харилцаа, хамтын ажиллагааны механизм ч өргөжин тэлж, шинэ агуулга, хэлбэртэй болж байна. Үүний тодорхой илрэл нь Ази, Номхон далайн бүс

²⁹ *Монгол Улсын гадаад бодлогын хөх ном*, Улаанбаатар, 2006, 101-р тал.

нутагт төдийгүй дэлхий дахины олон улсын харилцааны механизмд хүчтэй нөлөөлөх болсон олон улсын улс төр, эдийн засгийн харилцааны томоохон институт болох АСЕАН, АПЕК юм.

АСЕАН, АПЕК бол дэлхийн улс төрийн бодлого, үйл явцын хүрээн дэх хамтын ажиллагааны том төв, бүс нутгийн харилцааны гол суурь тулгуур мөн.

1. Ази, Номхон далайн бүс нутгийн судалгаа

Ази, Номхон далайн бүс нутаг судалгааны объект болох нь, түүний онцлог:

Ази, Номхон далайн бүс нутаг гэдэг ухагдахууныг улс төр, олон улсын харилцаа, газар зүйн шинжлэх ухааны онол, аргазүйн талаас нь судалсан болно. Тухайлбал:

1. Ази, Номхон далайн бүс нутгийг олон улсын харилцааны онол, аргазүйн дагуу олон улсын эрх зүйн нутаг дэвсгэр гэж үзэв.
2. Ази, Номхон далайн бүс нутгийг физик газарзүйн шинжлэх ухааны арга зүйн дагуу ангилбал:
 - а. Судалгааны явцад Ази, Номхон далайн бүс нутаг бол олон улсын эрх зүйн нутаг дэвсгэр мөн, иймээс Монгол Улсын олон талт хамтын ажиллагааны бодит орон зай болно гэсэн дүгнэлтэнд хүрлээ;
 - б. Эх газрын тогтолцооны Ази ба Австрали тивийг хамарсан онцлогтой байна.
3. Ази, Номхон далайн бүс нутгийг нийгэм, эдийн засгийн газарзүйн шинжлэх ухааны онол, аргазүйн дагуу ангилбал:
 - а. Соёл иргэншлээр нь олон соёл иргэншлийн нийлбэр, гэхдээ суурин ба нүүдлийн (илүү сайн хадгалагдсан) иргэншлийн, харин хоорондоо төстэй;
 - б. Хүн амын хүчин зүйлээр нь дэлхийн хамгийн олон хүн оршин амьдардаг;
 - в. Үндэстний тархалтаар нь олон үндэстний;
 - г. Шашин шүтлэгээр нь дэлхийн бүх шашин дэлгэрсэн, харин харьцааны хувьд ойролцоо;
 - д. Төрийн тогтолцооны хэлбэрээр нь ардчилсан, цөөнх нь социалист хэв маягтай бүгд найрамдах улсууд;

е. Эдийн засаг, түүний зохицуулалтаар нь зах зээлийн, цөөнх нь төвлөрсөн зохицуулалттай;

ё. Хил хязгаарын хувьд нь эх газрын хил улсуудын хилээр, усан хил Номхон далайн эргийн хилээр тогтоогдсон онцлогуудтай байна. Үүнд зүүн, зүүн өмнөд, Азийн орнууд, АНУ, Канад, Чили, Перу улсууд, Ази, Австрали болон Номхон далайн бүх арлууд тус тус хамрагддаг.

Одоогоор Ази, Номхон далайн бүс нутаг гэдэг ухагдахууныг доктор (Ph.D) К.Дэмбэрэл³⁰ төв Азийн бүс нутгийг физик газарзүйн талаас нь судалсанаас өөр судалгаа алга байна.

Онолын хувьд Ази, Номхон далайн бүс нутаг бол энэ нутгийн шинэ зах зээлийг эзлэх, улмаар олон улсын тавцанд нөлөөгөө тогтоох (хүчний төвийг тодорхойлогч субъект болох), нөгөө хэсэг нь хөгжингүй орнуудаас өөрийгөө хамгаалах гэсэн хоёр өөр ашиг сонирхлуудын нэгдэл бүхий эдийн засаг-улс төрийн бүлэглэл мөн. Энэ бүс нутаг олон улсын эрх зүйн нутаг дэвсгэр учир Ази, Номхон далайн бүс нутгийн бүсчилсэн хөгжил (*бүс нутгийн интеграци-Б.Ц*) (бүс нутаг судлаач Б.Батжаргал бүс нутгийн бүсшил хэмээн нэрлэсэн) бол даяарчлагдах үйл явцын (*Ази, Номхон далайн нутаг дэвсгэр дэх-Б.Ц*) үргэлжлэл гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, бүс нутгийн бүсчилсэн хөгжил нь даяарчлалын нэг хэсэг гэж үздэг онолын урсгалын (Regionalism=Globalization буюу R=G томъёололтой) төлөөлөл мөн болно (онолын өөр урсгал нь R>G томъёололтой байдаг) гэж тус тус үзсэн байна.

Дээрх судалгаанаас үзэхэд АСЕАН ба АПЕК нь орон зайн хувьд Ази, Номхон далайн бүсийн эрх зүйн нутаг дэвсгэрийн бүрэлдэхүүн болно.

Геополитикийн болон институцийн онолын үүднээс авч үзвэл Монгол Улс өргөн уудам нутаг, байгалийн сэргээгдэх ба сэргээгдэхгүй баялаг, цөөн хүн ам, Орос, Хятадын дунд оршдог орны хувьд гуравдагч хөршийн хамтын ажиллагаа нэн чухал байна.

Онол, аргагүйн хувьд Ази, Номхон далайн бүс нутаг Монгол Улсын олон улсын харилцаа, улс төрийн бодлогын чухал зангилаа төв, бүс нутаг болж байна. Ийм учраас АПЕК нь Монгол Улсын олон талт хамтын ажиллагааны газар зүйн гадаад орчин бөгөөд улс төр, гадаад харилцаа, эдийн засгийн ашиг сонирхлын бодит орон зай мөн гэсэн дүгнэлтэнд хүрлээ.

³⁰ Дэмбэрэл.К., *Төв Азийн геополитик Монгол Улс*, Улаанбаатар, 2005, 16-р тал.

Ази, Номхон далайн бүс нутгийн нутаг дэвсгэр: Ази, Номхон далайн бүс нутгийн нутаг дэвсгэр нь олон улсын эрх зүйн нутаг дэвсгэр, мөн Зүүн, Зүүн өмнөд, өмнөд Азийн орнууд болон Номхон далайн арлын орнуудыг, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаагаар нь Канад, Чили, Мексик, Перу, АНУ, сэдвээс нь шалтгаалж Ази, Австрали болон Номхон далайн бүх арлуудыг хамруулан авч үзэв. Энэ нутагт өргөн утгаар нь хуурай, усан гадаргуу, гүний ба агаарын орон зай, түүнчлэн дэлхийг хүрээлэн буй сансрын орон зай, сар, нарны аймгийн эрхэс гариг болон түүний биетүүдийг хамрууллаа.

Ази, Номхон далайн бүс нутгийн геоэдийн засаг ба эдийн засгийн интеграци:

Бүс нутгийн эдийн засагт гарсан үндсэн өөрчлөлтүүд дор дурдсан зарим онцлогтой. 1967 онд энэ бүс нутагт АСЕАН байгуулагдсан. Тэр үеэс 1980 он хүртэл бүс нутгийн эдийн засгийн харилцаа үндсэндээ барааны худалдаагаар тодорхойлогдож байв. Олон улсын харилцаа өнгөрсөн зууны сүүлийн хагасын хоёр туйлт үеийнхээс эрс өөрчлөгдлөө.

1980-аад онд дэлхийн даяаршлын үйл явц өмнөх үеэс илүү өргөн хүрээтэй, нарийн төвөгтэй хөгжлийн үе шатанд гарч, олон улсын харилцаанд чухал хандлага³¹ бий болсон. Эдгээрийн үр дүнд эдийн засгийн харилцаа 1980-аад оноос хойш үйлчилгээ, хөрөнгө оруулалт, оюуны өмч, хөдөлмөр³², бараа, үйлчилгээ, зээл, технологи, ажиллах хүчин зэрэг чиглэлээр өргөжив.

Дэлхийн худалдааны байгууллагаас гадна бүс нутгийн хэмжээний байгууллагууд ч бий болж, түүнд оролцох улс орны тоо нэмэгдэж, зарим улс бүс нутгийн хэд хэдэн байгууллагын гишүүн болж эхлэв.

Бүс нутагт тулгараад байсан томоохон сорилтын нэг нь эдийн засгийн хямралын үеэс өмнөх эдийн засгийн хөгжлийн түвшиндээ хүрэх явдал байлаа. Эдийн засгийн өсөлт гадны хүчин зүйлсийн ачаар дээшлэх боломжтой ч тэр нь урт хугацаанд тогтвортой хадгалагдах боломжгүй байв. 1997 оны Азийн санхүүгийн хямрал нь Азийн орнуудын хувьд өөрийн хүчинд тулгуурлан урт хугацаанд хөгжлийг хангах, бүс нутгийн хэмжээнд

³¹ *An ninh kinh tế ASEAN và vai trò của Nhật Bản* (АСЕАН-ны эдийн засгийн аюулгүй байдал ба Японы үүрэг роль), Hà Nội, 2001, tr.10.

³² *Đổi sách của các nước Đông Á trước việc hình thành các khu vực mậu dịch tự do từ cuối những năm 1990* (1990 оноос чөлөөтэй худалдааны бүс нутаг бий болохоос Зүүн Азийн орнуудын сэргийлэх аргууд), Hà Nội, 2006, tr.361, 362.

өргөн цар хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлагатай, тэр нь оролцогч талуудад бүгдэд нь ашигтай³³ болохыг харуулсан.

XXI зуун гарсаар дэлхий дахинд даяаршил улам бүр тэлж, улмаар тус бүс нутаг, түүний улс үндэстнүүдийг бүхэлд нь хамраад байна. Үүнийг дагаад энэ бүс нутгийн эдийн засгийн интеграци гүнзгийрч, тэр нь Ази, Номхон далайн бүс нутгийн олон талт хамтын ажиллагааны хөгжлийн үндсэн хандлагыг тодорхойлох боллоо.

АСЕАН, АПЕК-ийн гишүүд, эдийн засгийн интеграцийн үйл явцаас Ази, Номхон далайн эдийн засгийн хөгжил шууд хамаарна. Үүний үр дүнд өнөөгийн байдлаар Ази, Номхон далайн эдийн засаг дэлхийн хүн амын 40 хувийг хамарч, ДНБ-ий 55 хувийг үйлдвэрлэж, дэлхийн худалдааны 44 хувийг гүйцэтгэж байна.

2. Бүс нутгийн аюулгүй байдал

Бүс нутгийн аюулгүй байдлын тулгамдсан асуудал: Тус бүс нутагт нийтийн энх тайвныг зөрчихгүй байх, бүсийн улс үндэстний аюулгүй байдалд занал учруулахгүй байх нөхцөл бүрдсэн, бүс нутагт үүсээд байгаа зөрчил, маргаан, түүнийг зохицуулах, шинэ голомтууд гарч болзошгүй байдлыг харгалзан судалсан болно.

Солонгосын хойгийн асуудал, БНАСАУ-ын цөмийн зэвсгээр заналхийлэх явдлыг арилгах, Вьетнам-Хятадын газар нутгийн маргааныг шийдвэрлэх зэрэг нь тухайн бүс нутагт аюулгүй байдлын тулгамдсан асуудал болоод байна.

Вьетнам-Хятадын маргаан Ази, Номхон далайн бүс нутгийн геополитикийн тулгамдсан асуудал мөн. Маргааны үр дагавар бүсээс хальж, дэлхийн тогтвортой байдлыг хамгаалах хурцадмал асуудал болон хувирсан.

Ази, Номхон далайн бүс нутагт (*зураг 1*) санал зөрөлдөөн, маргаан, давхацсан ашиг сонирхол их байна. Бүс нутагт дангаар ноёрхох санаархал байх боломжгүй юм.

Зураг 1: Өмнөд Хятадын тэнгисийн “U” хэлбэрт бүс

³³ Санжмятав. Б., *Дэлхийн эдийн засаг*, Улаанбаатар, 2014, 169-р тал.



Вьетнам-Хятадын газар нутгийн маргаан³⁴-ыг сонгон авч судалсан нь *нэгдүгээрт*, Хятад одоогоор газар нутгийн асуудлаар 11 оронтой, мөн хилийн асуудлаар олон орнуудтай маргаантай³⁵, *хоёрдугаарт*, энд сонгон авч судалсан газар нутгийн маргаан нь бүс нутаг дахь газар нутгийн маргааны сонгомол жишээ, өөрөөр хэлбэл бүрэн төлөөлөх боломжтой, *гумгаарт*, БНСВУ бол манай судалгааны үндсэн объект юм. Иймд манай хоёр орон бүс нутагт аюулгүй байдлын нэгдмэл орон зайг тогтооход үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, тус тусын хувь нэмрийг оруулах арга замыг судлахад илүүтэй анхаарлаа.

Өмнөд Хятадын тэнгисийн маргаан (*хүснэгт 1-д үзүүлэв*) нь 1974 онд Парасель, 1988 онд Спратлийн бүлэг арлын тулаанаас хойш гарч эхэлсэн гэж үздэг ч үнэндээ саяханаас хурцадмал байдалд ороод байгаа энэхүү маргаан бодит байдал дээр ХХ зууны эхний жилүүдэд анх гарсан байдаг.

Хүснэгт 1: Маргаантай газрын нэрс

<i>Олон улсын нэршил</i>	<i>Вьетнам нэршил</i>	<i>Хятад нэршил</i>
South China Sea (Өмнөд Хятадын тэнгис)	Biển Đông (Зүүн тэнгис)	Nanhai (Өмнөд тэнгис)

³⁴ Цэнгэлхам.Б., “Вьетнам-Хятадын газар нутгийн маргаан”, *Пакс Монголика сэтгүүл*, 2015, №1, 110-127-р тал.

³⁵ *Монгол Улс БНХАУ-тай 4673 км газраар хиллэдэг, хилийн маргаангүй, стратегийн түншлэлийн харилцаатай.*

Paracel Islands (Параселын бүлэг арлууд)	Hoàng Sa (Алтан элсний бүлэг арлууд)	Xisha (Баруун элсний бүлэг арлууд)
Spratly Islands (Спратлийн бүлэг арлууд)	Trường Sa (Урт элсний бүлэг арлууд)	Nansha (Өмнөд элсний бүлэг арлууд)
Woody Island (Ой модны арал)	Đảo Phú Lâm (Ой модны арал)	Yongxing dao (Аз жаргалын арал)
Itu Aba island (Итү Аба арал)	Đảo Ba Bình (Энх тайваны арал)	Taiping dao (Энх тайваны арал)
